| T4        | БНХЗ → ССХ   | . 267*** | Дэмжигдсэн                |

## 5. ДҮГНЭЛТ (Conclusion)

Цахим сургалт гэдэг нь заах, сурах үйл явцыг сайжруулах, дэмжих зорилгоор мэдээллийн технологийн хэрэглээг хэлдэг байна. Дэлхий дахинаа Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор ихэнхи улс орнууд их, дээд сургуулийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн билээ. Цахим сургалт нь сэдвээс үл хамааран хаана ч, хэзээ ч мэдлэгээ үр дүнтэй дамжуулах боломжийг олгодог хэдий ч оюутнуудын хувьд цөөнгүй бэрхшээлтэй тулгарч байсныг олон судлаачдын бүтээлээс харж болно. Цахимаар суралцах нь нь дэлхийн өнцөг булан бүрт сурч боловсрох боломжгүй тэр ертөнцийг нээж өгдөг бөгөөд үүнтэй зэрэгцэн өнөө үед дэлхийн мэдлэгийн эдийн засагт амжилтанд хүрэхэд чухал ач холбогдолтой мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг суралцагчдад эзэмшүүлдэг давуу талтайг эрдэмтэн, мэргэжилтнүүд нотолж байна. Монгол улсын хувьд 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилүүдэд ЕБС болон их, дээд сургуулиудын сургалт цахим хэлбэрээр явагдсан бөгөөд энэ үед олон бэрхшээлтэй тулгарчээ. Энэхүү судалгааны ажил цахим сургалтын үед тулгарч буй бэрхшээлийг хичээл, хувь хүн, технологи, байгууллага болон нийгмийн хүчин зүйлээр тандан судлах зорилготой байсан. Судалгаанд их, дээд сургуульд суралцаж буй оюутан, ахисан түвшиний 118 хүн оролцсон бөгөөд ихэнхи хувийг эмэгтэйчүүд эзэлсэн, оролцогчдын 54.2% нь 18-22 насныхан судалгаанд оролцсоноос харахад их, дээд сургуулийн бакалаврын түвшин суралцагсад идэвхитэй хамрагджээ. Судалгаанд нийгмийн болон байгалийн шинжлэх ухааны бүхий л салбар мэргэжлийнхнийг хамруулсанаараа энэхүү судалгааны онцлог юм. Цахим сургалтын чанарт нөлөөлөх байгууллага, нийгмийн хүчин зүйлийн талаар судалгаанд оролцогсад огт сэтгэл, ханамжгүй болон сэтгэл ханамжгүй гэсэн үнэлгээг өгсөн нь цахим сургалтад онцгой анхаарч дэмжлэг үзүүлэх шаардлагатайг харуулж байна. Хичээлтэй холбоотой хүчин зүйл тодруулбал цахим хичээлийн хөтөлбөр, хичээлийн агуулга, заах арга зүйн болон цахим хичээлийн тоехнологид харгалза асуудал бэрхшээлийн талаар судалгаанд оролцогсад “хариулж мэдэхгүй байна” гэсэн хариултыг өгсөн нь энэ талын мэдлэг хангалттай биш мөн хайхрамжгүй хандсан байх эсхүл сургууль багшийн зүгээс цахим хичээлийн чанартай зохион байгуулаагүй байж болох талтай. Тоон судалгааны аргаар урьчилсан бэлтгэсэн асуумжаар түүврийг цуглуулан SPSS, AMOS програм дээр тооцооллыг гүйцэтгэсэнээр дэвшүүлсэн 4 таамаглал батлагдсан. Энэ нь их, дээд сургуулиудын цахим сургалтын чанар “хувь хүний”, “хичээлтэй холбоотой”, “технологийн” болон “байгууллага, нийгмийн /их, дээд сургууль/ хүчин зүйл хамааралтай болохыг харуулж байна.

## 5. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Волери (2000)-ийн үзсэнээр хэрэв их дээд сургуулиуд бэлэн байгаа цахим сургалтын технологийг нэвтрүүлэхгүй бол даяаршлын эрэлхийлэлд хоцрогдох болно. Мөн Рибиеро (2002) хэрэв их дээд сургуулиуд дээд боловсрол олгох хэрэгсэл болох цахим сургалтын боломжийг дээд зэргээр ашиглах юм бол боловсролын онлайн загварыг амжилттай нэвтрүүлж чадна. Цахим сургалтын үеийн их сургуулиудын үйл ажиллагаа байнгын хяналт, хөндлөнгийн оролцоо ба багшийн тасралтгүй үнэлгээнд чиглэсэн байх ёстой. Ингэснээр сургалтын чанарыг үнэлж цаашид анхаарах асуудлаа тодорхойлно. Цахим сургалтын чанарыг тогтмол үнэлэх бөгөөд хичээлийн хөтөлбөрт шалгалт хийж зөвлөж байх явдал хамгийн чухал. Мөн төгсөгчдийн судалгааны ажил, ажлын тайлан зэргийг шалгах нь чанарыг үнэлэхэд дөхөм болно. Цаашид их, дээд сургуулиудын хичээл цахим хэлбэрээр бүрэн болон хэсэгчилсэн байдлаар явагдах нь тодорхой юм. Цахим сургалтын давуу талыг улс орнууд ойлгож ухамсарласан учраас энэ талд багш, суралцагчийг бэлтгэх, технологийн дэвшлийг бүрэн ашиглах, нутагшуулах, зардлаа хэмнэх зэрэг алхамуудыг аль хэдийн хийгээд бэрхшээлийг багасгаж аль болох зардал багатай, үр дүнтэй байдлыг харчихаад байгаа. Дээрх судлаачдын зөвлөмж болон энэхүү судалгааны үр дүнгийн дагуу цахим сургалтын бэрхшээлийг яаралтай тооцож, сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай юм.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Coakes, S. J., Steed, L., and Ong, C. (2009). *SPSS 16.0 for windows: Analysis without anguish*. Australia: John Wiley and Sons.
- Hair, J. F., Black, W. C., Babin, B. J., and Anderson, R. E. (2009). *Multivariate data analysis*. Upper Saddle River, New Jersey, NJ: Pearson Prentice Hall.
- Anderson, J.C.; Gerbing, D.W. Structural equation modeling in practice: A review and recommended
- Hannafin, M., Land, S., and Oliver, K. (1999). Open Learning Environments: Foundations, Methods, and Models. In Reigeluth, C.M. (ed.), *Instructional-Design Theories and Models: A New Paradigm of Instructional Theory*. Volume II (pp. 215-239). Lawrence Erlbaum.
- Andersson, A. & Grönlund, Å., 2009. A conceptual framework for eLearning in developing countries: A critical review of research challenges. *The Electronic Journal on Information Systems in Developing Countries*, 38(8), pp.1–16.
- Anderson, T., & Elloumi, F. (Eds.). (2004). *Theory and practice of online learning*. Canada: Athabasca University Press
- Eastmond, D. (2000) Realizing the Promise of Distance Education in Low Technology Countries, *Educational Technology Research and Development*, 48, 2, 100-111.
- Sehrt, M. (2003) E-Learning in the Developing Countries - Digital Divide into Digital Opportunities, *UN Chronicle Online*, 4, 3, 45-xx. <http://www.un.org/Pubs/chronicle/2003/issue4/0403p45.asp>
- Mapuva, J. (2009). Confronting challenges to e-learning in Higher Education Institutions. *International Journal of Education and Development using ICT*, 5(3), 101-114. Open Campus, The University of the West Indies, West Indies. Retrieved June 13, 2021 from <https://www.learntechlib.org/p/42282/>.

# **A Study of Factors Determining Economic Growth and Women's Labor Force Participation Rate in Developing Countries in Asia: An Empirical Analysis**

Amarjargal Gandolgor<sup>1</sup>, Ko Min Chang<sup>2</sup>  
*Department of Economic, Wonkwang University, [gando0516@gmail.com](mailto:gando0516@gmail.com)*

*Corresponding Author: Ko Min Chang*

**Abstract:** As Asia's economy continues to grow and poverty continues to decline, inequality continues to rise and large sections of society remain on the sidelines without benefiting from economic and social development. A clear example of this is women in developing countries in Asia. Women in developing and developed countries in Asia are more likely to be employed until old age, but they are still undergoing major economic restructuring, from pre-school to old age and retirement. Women make up the majority of the low-wage, the low-skilled labor force in the export-oriented, developing, agricultural, textile, footwear, and electronics industries of developing Asian countries. They are living in difficult living conditions, earning the minimum wage, and working in unregistered jobs.

As a result, the economy of developing countries in Asia, including women's employment, as well as the growth of fertility, is being diversified. There is a lack of research on real GDP growth per capita and women's employment in developing Asian countries. Therefore, the study was conducted between 1995 and 2019 in 20 Asian countries (Bangladesh, Bhutan, Cambodia, China, India, Indonesia, Kazakhstan, Kyrgyzstan, North Korea, Malaysia, Mongolia, Myanmar, Nepal, Pakistan, the Philippines, Sri Lanka, Tajikistan, Thailand, Uzbekistan, Vietnam) and the factors influencing the growth of per capita GDP and women's employment, and the important factors influencing these growths were identified. Based on the data from 20 developing countries in Asia, the empirical analysis was conducted using stata16, model1, model2, and model3, respectively.

In Model 1, per capita GDP has a positive impact on women's pre-school education and women's business and legal index scores, women's industrial employment, and female employers, while the number of women in agriculture has declined as the economy has grown. identified by research.

Model 2 analyzes the relationship between birth rate per capita GDP and shows that birth rates are declining as economic growth increases in developing Asian countries.

Model 3 shows that marital status and religion have a negative impact on the level of women's labor force participation, while growth rates and women's business and legal index positions do not affect women's labor force participation rates.

**Keywords:** Asian developing countries, GDP per capita, women's labor force participation, empirical analysis, random effects

## **1. Удирдтгал**

Эдийн засгийн өсөлт гэдэг нь тухайн улсын баялаг цаг хугацааны явцад өсөх үйл явц юм.

Хэдийгээр энэ нэр томъёо нь эдийн засгийн богино хугацааны гүйцэтгэлийн талаарх хэлэлцүүлэгт ихэвчлэн хэрэглэгддэг боловч эдийн засгийн онолын хүрээнд ерөнхийдөө урт хугацааны туршид баялгийн өсөлтийг илэрхийлдэг.

Өсөлтийг өөрчлөлтийн үйл явц гэж хамгийн сайнаар тодорхойлж болно. Хэрэв бид аль хэдийн орчин үеийн, үйлдвэржсэн эдийн засаг эсвэл хөгжлийн эхний шатандаа байгаа ч эдийн засгийг авч үзвэл өсөлтийн үйл явц нь пропорциональ бус байгааг олж харна. Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд дэлхий даяар гарсан нэг өөрчлөлт бол хөлстэй хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн явдал аж. Энэ нь нэг талаараа эдийн засгийн өсөлт болон нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн өсөхийн хирээр эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хэрхэн өсөлт үзүүлж мөн жил ирэх тусам нэмэгдэж байгааг судлах болно.

Amaia Altuzarra , Catalina Gálvez-Gálvez<sup>5</sup> нар нь 1990-2016 оны хооронд Европын Холбооны 28 орны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо ба эдийн засгийн хөгжлийн хоорондын хамаарлыг судалсан ба үр дүнд нь Европын бүх орнуудын (EX-28) үр дүн нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо болон эдийн засгийн хөгжлийн хооронд U хэлбэрийн хамаарал байгааг баталсан юм.

Paolo Verme, Abdoul Gadiry Barry, Jamal Guennouni<sup>6</sup> судлаачдын авч үзсэнээр судалгааг 1999-2012 оны хооронд явуулсан ба Арабын орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшинтэй харьцуулахад Арабын ертөнцөд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн оролцоо бага байгааг нотолсон юм. Мөн түүнчлэн эдийн засгийн өсөлтийн мөн чанар, жендэрийн хэм хэмжээнд оршдог ба эдийн засгийн өсөлт нь хөдөлмөр их шаарддаггүй, цөөн тооны ажлын байр бий болгосон, эмэгтэйчүүдэд ээлтэй салбарт байгаагүй нь эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээ, ялангуяа хотын боловсролтой дунд боловсролтой эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээг сулруулж байна. Хамгийн гол үзүүлэлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс ховор ажлын төлөө өрсөлдөхөд ажил олгогч болон өрхийн сонголтоос шалтгаалж эрчүүдэд давуу эрх олгох боломжтойг судалгаагаараа харуулсан юм.

Fatma Fehime AYDIN, Ekrem ERDEM<sup>7</sup> нар нь 1998-2008 онуудын хооронд самбарын өгөгдөлийг ашиглан судалгаа явуулсан бөгөөд Энэхүү судалгаанд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг Олон улсын менежментийн хөгжлийн хүрээлэн (IMD) болон Туркийн мэдээллийн дагуу хамгийн өрсөлдөх чадвартай улс орнуудын хооронд харьцуулсан болно. Шинжилгээний үр дүнгээс харахад өрсөлдөх чадвар өндөр орнуудад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлдөг бол хэлэлцэж буй бүх улс орнууд болон өрсөлдөх чадвар муутай орнуудад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөөлөл бага байна гэж дүгнэжээ. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо эдгээр бүх бүлгийн эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлдөг.

Alison Vásconez Rodríguez<sup>8</sup>(2003-2010) оны мэдээллийг ашиглан судалгааг явуулсан бөгөөл

---

<sup>5</sup> Amaia Altuzarra , Catalina Gálvez-Gálvez(2019) <https://www.mdpi.com/journal/sustainability>, Economic Development and Female Labour Force Participation: The Case of European Union Countries

<sup>6</sup> Paolo Verme, Abdoul Gadiry Barry, Jamal Guennouni(2014) Policy Research Working Paper-7031, Female Labor Participation in the Arab World Some Evidence from Panel Data in Morocco

<sup>7</sup> Fatma Fehime AYDIN, Ekrem ERDEM(2014), Erciyes University Faculty of Economics and Management, Journal, Issue: 44, July-September 2014 p. THE EFFECT OF WOMEN'S EMPLOYMENT ON COMPETITIVENESS AND ECONOMIC GROWTH: A COMPARISON OF TURKEY AND THE MOST COMPETITIVE COUNTRIES

<sup>8</sup> Alison Vásconez Rodríguez(2017) Associate Professor with the Latin American Faculty of Social Sciences (FLACSO). [avasconez@facso.edu.ec](mailto:avasconez@facso.edu.ec), Economic growth and gender inequality: an analysis of panel data for five Latin American countries

энэхүү судалгаа нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин болон эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлтийн харьцангуй өсөлт гэж тодорхойлсон хөдөлмөрийн зах зээлийн эмэгтэйчлэлийн харилцаа болон Латин Америкийн бусад орнуудын эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг авч үздэг ба нэг талаас, эдгээр чиг хандлага нь ажиллах хүчний оролцоо нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлж болзошгүй ба эрэлтэд нөлөөлдөг нь харагдаж байгаа боловч үр дүнгээс үзэхэд ажиллах хүчний эмэгтэйчүүлэлт нь өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг боловч хөдөлмөрийн нийлүүлэлтийн өсөлт (цагаар хэмжигддэг) тийм биш юм.

Мөн түүнчлэн бидний судалгаанд шашны хамааралтай орнуудын эмэгтэйчүүдийн ажиллах боломж нь нөлөөг судалж үзсэн ба нийгмийн янз бүрийн хэм хэмжээ, хандлага, соёлын болон институцийн хүчин зүйлийг хүндэтгэдэг өөр өөр шашин (Лалын шашинтнууд ба Христэд итгэгчид) улс орнуудад харилцааны мөн чанар өөр өөр байж болно (Фернандес, 2013)<sup>9</sup>. Жишээлбэл, лалын шашинтай орнуудад шашны хязгаарлалтын улмаас эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхгүй байдаг тул сайн үндэслэлтэй U хэлбэрийн харилцаа алга болж магадгүй юм .

Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байгаа нь эмэгтэйчүүдийн сайн сайхан байдал, эдийн засгийн бие даасан байдал, үр дүнтэй эрэлт, өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээс гадна жендэрийн харилцаанд үзүүлэх нөлөөгөөр бизнесийн мөчлөгт нөлөөлдөг.<sup>10</sup> Энэ үйл явц нь эмпирик байдлаар батлагдсан дор хаяж хоёр механизмаар дамждаг: (i) нийгмийн нөхөн үржихүйн зардлыг хариуцдаг цалингүй гэрийн ажил; мөн (ii) эрэгтэйчүүдийнхтэй ижил хэмжээний дундаж цалин багатай үйлдвэрлэдэг эмэгтэйчүүдийн цалинтай ажил.

Эдгээр хоёр механизм нь бизнесийн мөчлөгийн явцад хоёр сувгаар ялгаатай үр нөлөөг бий болгож чаддаг байна.<sup>11</sup>

- Нөхөн үржихүйн суваг. Үүнд цалингүй гэрийн ажил нь эдийн засагт “хуримтлал” бий болгодог тул энэ хэмнэлтийг бууруулбал ажиллах хүчнийг эмэгтэйчлэх нь сөрөг үр дагавартай (гэрийн ажлыг хувийн үйлчилгээ эсвэл засгийн газрын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээгээр төлж, нэг хэсэг юм. Гэрийн болон халамжийн ажил нь эдийн засагт ямар ч зардалгүйгээр шилжүүлдэг үнэ цэнийг эдийн засгийн эргэлтэнд оруулахаа больж, харин нийт цалингийн санг нэмэгдүүлэх болно). Гэсэн хэдий ч хямралын үед өрхүүд зардлаа цалингүй ажлыг "орлуулах" тохиолдолд (өөрөөр хэлбэл эдийн засгийг сэргээхэд шаардагдах хэмнэлтийг төсвийн зарлагыг хязгаарлах эсвэл гэрийн ажил хийх замаар хангадаг бол) энэ нь эерэг нөлөө үзүүлж магадгүй юм

- Хөдөлмөрийн зах зээлийн суваг. Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байгаа нь жендэрт суурилсан цалингийн тэгш бус байдлаас шалтгаалан цалингийн зардлыг бууруулах (бага цалинтай ажиллах хүчний нийлүүлэлт ихсэх нь дундаж цалин буурахад хүргэнэ) эерэг нөлөө үзүүлж болох юм.<sup>12</sup> Нөгөө талаас, цалингийн зөрүү болон дундаж цалингийн бууралтын дарамт нь үр ашигтай эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Эдгээр хоёр нөлөө нь нэгэн зэрэг тохиолдож болох бөгөөд цэвэр нөлөө нь эдийн засгийн бүтцээр тодорхойлогддог.<sup>13</sup>

<sup>9</sup> Ana González-Fernández(2013) [Quality & Quantity: International Journal of Methodology](#), 2013, vol. 47, issue 2, 895 pages, Weak cognitive image of cultural tourism destinations

<sup>10</sup> Dutt (1990), Lo Vuolo (2009) and Bhaduri (2007), For further information on the debate surrounding growth theory as viewed from the standpoint of effective demand

<sup>11</sup> Erturk and Darity(2000), Secular Changes in the Gender Composition of Employment and Growth Dynamics in the North and the South, [World Development](#), 2000, vol. 28, issue 7, 1231-1238

<sup>12</sup> Benería, 2005 and 2008, At the global level, the feminization of the workforce and the employment conditions associated with that process have given rise to structural inequalities in international labour markets and to increasing informalization as a result of the demand for capital.


<sup>13</sup> Blecker and Seguino(2002), Macroeconomic Effects of Reducing Gender Wage Inequality in an Export-Oriented, Semi-Industrialized Economy, [Review of Development Economics](#), 2002, vol. 6, issue 1, 103-119

Судалгааг 1995-2019 оны хооронд Азийн 20 оронд(Бангладеш, Бутан, Камбож, Хятад, Энэтхэг, Индонез, Казахстан, Киргизстан, БНАСАУ, Малайз, Монгол, Мьянмар, Балба, Пакистан, Филиппин, Шриланка, Тажикистан, Тайланд, Узбекистан, Вьетнам) улсуудыг оролцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн болон эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, эдгээр өсөлтөд нөлөөлж буй чухал хүчин зүйлсийг илрүүлсэн. Азийн хөгжиж буй 20 орны өгөгдөл дээр тулгуурлан стата16-аар дамжуулан эмпирик шинжилгээг загвар1, загвар2, загвар3 тус бүр судалгааны ажлаа явуулсан болно. Энэхүү судалгаа нь таван хэсгээс бүрдэх бөгөөд эхний хэсэгт удиртгал бол хоёрдугаар хэсэгт онолын судлагдсан байдлыг авч үзсэн байгаа. Гурав дахь хэсэгт өгөгдөл, аргагчлалыг тусгасан ба тоон үзүүлэлтийн үр дүнг харуулж өгсөн. Сүүлийн дөрөвдүгээр хэсэгт дүгнэлт болон ашигласан материалыг оруулж өгсөн болно.

## 2. Онолын судлагдсан байдал

Эдийн засгийн өсөлт болон эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн талаарх судлагдсан байдал Сүүлийн жилүүдэд дэлхий даяар гарсан нэг өөрчлөлт бол хөлстэй хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн явдал аж.

Жил ирэх тусам эдийн засаг өсөхийн хирээр тухайн улс орны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тоо хэмжээ нэмэгдэж байгаа үзүүлэлт харагдаж байгаа боловч доорх графикаас харвал Азийн хөгжиж буй улсуудын хувьд одоо хүртэл эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт өндөр хувьтай буюу өсөлт ихтэй нь харагдаж байна.



[График 1] 1995-2019 оны хоорондох ДНБ өсөлт болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн өсөлт

Хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцооны өсөлтийн энэхүү өөрчлөлтийг судлаачид 1960-аад онуудад хүчтэй өрнөсөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнтэй холбон тайлбарладаг. Мөн түүнчлэн жирэмсэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслүүдийг өргөнөөр хэрэглэх болсон, иргэдийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд өөрчлөлт гарсан, гэрийн хөдөлмөр хөнгөвчлөгдсөн, шинэ технологийн өөрчлөлттэй уялдан хөдөлмөрийн зах зээлд гарсан эмэгтэйчүүдийн

хөдөлмөрийн эрэлт өссөн явдалтай холбон үзэж байна (Jenkins, 2004)<sup>14</sup>. Зарим судлаачид эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг “шинэ мэдлэгт суурилсан эдийн засаг”-тай холбон үзсэн байна (Jenkins, 2004). Мэдлэгт суурилсан эдийн засгийн систем нь хүмүүс хоорондын өрсөлдөөний чигийг өөрчлөн, хүмүүсийг ажлын маш их ачаалалтай амьдрахад хүргэн улмаар эмэгтэйчүүд хүүхэдтэй байх явдлаас татгалзаж, хөлстэй хөдөлмөр эрхлэхийг чухалчлах хандлагатай болж байгаатай холбогдох юм.

Tzannatos(1999)<sup>15</sup>нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлийн тасралтгүй хөгжлийг хамгаалж, жендэрийн ялгааг багасгах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйлдвэрлэл, сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх боломжтой гэж үздэг. Тэрээр эдийн засгийн өсөлт нь бүх ажилчид, ялангуяа эмэгтэй ажилчдад богино хугацаанд ашигтай байх болно гэж тэр үзэж байна; Гэхдээ эдийн засгийн өсөлтөөс ихэвчлэн эмэгтэйчүүд ашиг хүртэх болно.

Dollar and Gatti(1999)<sup>16</sup>нар хүний капиталын хувьд эмэгтэйчүүдэд бага хөрөнгө оруулалт хийх нь хөгжиж буй орнуудын хувьд үр дүнтэй давуу тал биш бөгөөд сургалт, цалин хөлс, ажил эрхлэлтийн тэгш бус байдал нь сөрөг үр дагавартай гэж үздэг. Эдгээр судлаачдын өөрсдийн дүгнэлтийг тайлбарласнаар эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил хишиг хүртэж, ур чадвар, чадварын тэгш хуваарилалттай байх үед тэгш бус байдал үүсэх нь өндөр ур чадвартай эмэгтэйчүүдийг гадуурхаж, ур чадвар муутай эрчүүдийг хамруулахад хүргэнэ гэдгийг харуулж байна. Хэрэв эмэгтэйчүүдийг бага боловсролоор нь хасч, эрэгтэйчүүдэд боловсрол эзэмших боломжийг олговол өгөөж буурч байгаа нөхцөлд охидыг сургах нь илүү их өгөөжтэй байх болно гэсэн үр дүн гарсан байна. Энэхүү судалгааны багц нь хүний капиталын онолын үндсэн зарчмуудын нэг болох боловсролд оруулсан хөрөнгө оруулалт болон эдийн засгийн өсөлт хоёрын хооронд шууд хамаарал байдаг гэж үздэг. Энэ нь эргээд (албан ёсны) боловсрол нь бүтээмжийг нэмэгдүүлдэг зөн совин дээр суурилдаг (тухайн нарийн шалгагдаагүй). Бүтээмж нь ажиглагдахгүй, орлогын түвшин, ажил эрхлэлтийн эрэлт зэрэг нь боловсролын түвшинтэй холбоогүй хүйсийн ялгавартай байдлыг бий болгодог гэж үздэг хүмүүс энэ онолыг эргэлзээтэй болгожээ. Иймээс эдгээр судалгааны дүгнэлтүүд боловсролын тэгш бус байдал нь өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүйг (мэргэжилтэй ажиллах хүч алдагдаж байгаа тул) харуулж байгаа боловч хэрэв эмэгтэйчүүд боловсролд хөрөнгө оруулалт хийвэл (эсвэл боловсролын өндөр түвшинд хүрвэл) гэдгийг нотлох албагүй ба тэд илүү өндөр орлоготой байх эсвэл өндөр бүтээмжтэй ажилд орох боломжтой болно.

According to Klasen and Lamanna(2009)<sup>17</sup> ийн үзэж байгаагаар сургалт, ажил эрхлэлтийн тэгш бус байдал нь эдийн засгийн өсөлтийг мэдэгдэхүйц бууруулна. Ажил эрхлэлтийн ялгаварлан гадуурхалт нь Ойрхи Дорнод, Хойд Африк, Өмнөд Азийн орнуудын эдийн засгийн өсөлтийн зөрүү нэмэгдэж буйг харуулж байна. Энэ нөлөөллийн эх үүсвэр нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт удаашралтай нэмэгдэж байгаа нь нотлогддог.

### **3. Судалгааны аргазүй, шинжилгээний үр дүн**

---

<sup>14</sup> Jenkins, S. Gender, Place and the labour Market ASHGATE 200

<sup>15</sup> TZANNATOS, Zachariadis; (1999), “Women and Labor Market Changes in the Global Economy: Growth Helps, Inequalities Hurt and Public Policy Matters”, World Development, 27(3), pp. 551-569.

<sup>16</sup> DOLLAR, David and Roberta GATTI; (1999), “Gender Inequality, Income and Growth: Are Good Times Good for Women”, Policy Research Report on Gender and Development Working Paper Series, 1, pp. 1-40.

<sup>17</sup> KLASSEN, Stephan and Francesca LAMANNA; (2009), “The Impact of Gender Inequality in Education and Employment on Economic Growth: New Evidence for A Panel of Countries”, Feminist Economics, 15(3), pp. 91-132.

Энэхүү судалгаа нь хөгжиж буй Азийн орнуудын эдийн засгийн өсөлтөд тодорхой хувьсагчууд хэрхэн нөлөөлж байгаа болон эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөлж буйг харуулсан эмпирик судалгаа юм. Шинжилгээний хугацаа 1995-2019 он бөгөөд судлах улс орнуудад нь Азийн хөгжиж буй 20 (Бангладеш, Бутан, Камбож, Хятад, Энэтхэг, Индонез, Казахстан, Киргизстан, БНАСАУ, Малайз, Монгол, Мьянмар, Балба, Пакистан, Филиппин, Шриланка, Тажикистан, Тайланд, Узбекистан, Вьетнам)-д дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгаанд ашигласан өгөгдлийг (World Data Indicator Database) болон (UNCTADstate)-аас авсан болно. Бүх өгөгдлийн нэгжийг ам.доллараар илэрхийлсэн болно. Дараагийн бүлэгт дээр дурдсан зүйлсийг нэгтгэн дүгнэж, шинжилгээний үр дүнг авч хэлэлцэн, 1995-2019 оны хугацаанд дээр дурдсан хувьсагчдын тоон мэдээллийг улс орон бүрээр цуглуулсан болно. Бүтэн 20 бүлэг буюу 20 улсын, нийт 500 ажиглалттай. Эдийн засгийн өсөлт буюу нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөх хувьсагч болон эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөлөх үүргийг нарийн шилжлэж үзэхийн тулд самбар мэдээлэлийн(STATA16)-г ашиглан санамсаргүй нөлөө болон тогтмол нөлөөг Хаусманы тест дээр үндэслэн дараах загвар1, загвар2, загвар3 тус бүрт ашигласан.

1. Загвар1, хувьсагчдын тайлбар болон үр дүн

[Хүснэгт 1] Загвар 1 дэх хувьсагчдын тайлбар

| Хамааралтай хувьсагч                       | Бие даасан хувьсагч   |
|--|---|
| Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн | 1. Сургуулийн өмнөх боловсрол, эмэгтэй<br>Сургуулийн өмнөх боловсрол гэдэг нь бага насны хүүхдүүдийг сургуулийнх шиг орчинтой танилцуулах, гэр, сургуулийн хооронд гүүр болох зорилготой зохион байгуулалттай сургалтын эхний шатны хөтөлбөрүүдийг хэлнэ.   |
|  | 2. Эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индексийн оноо<br>Энэ индекс нь хууль тогтоомж нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжид хэрхэн нөлөөлж байгааг хэмждэг. Нийт оноог 100 оноо нь хамгийн өндөр буюу 100 гэсэн найман чиглэлийн (Ажиллах, ажил д орох, цалин авах, гэрлэх, хүүхэд төрүүлэх, бизнес эрхлэх, тэтгэвэр авах) дундаж оноог авч тооцдог индекс. |
|  | 3. Хөдөө аж ахуй дахь ажил эрхлэлт, эмэгтэй<br>Хөдөө аж ахуйн салбар нь 1-р хэсэг (ISIC 2) эсвэл А-В (ISIC 3) эсвэл А ангиллын (ISIC 4) дагуу хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуурын үйл ажиллагаанаас бүрдэнэ.  |
|  | 4. Аж үйлдвэрийн ажил эрхлэлт, эмэгтэй<br>Аж үйлдвэрийн салбар нь 2-5 (ISIC 2) эсвэл CF (ISIC 3) эсвэл BF (ISIC 4) ангиллын дагуу уул уурхай, олборлох аж ахуй, үйлдвэрлэл, барилга, нийтийн аж ахуй (цахилгаан, хий, ус) -аас бүрдэнэ.   |

Загвар1 – Дээрх хүснэгтээр дурьдчилан дараах байдалтай байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөх хувьсагчуудын шинжилгээны загвар

$$\ln Y_{it} = \beta_0 + \beta_1 \ln h_{it} + \beta_2 \ln LawScore_{it} + \beta_3 \ln Agriculture_{it} + \beta_4 \ln Industry_{it} + \mu_i + \varepsilon_{it} \quad (1)$$

Дээрх тэгшитгэлд(Загвар 1)  $i$  нь Азийн хөгжиж буй орнуудыг ( $i = 1, 2, 3, \dots, 20$ ),  $t$  нь жилийг ( $t = 1995, 1996, \dots, 2019$ ) илэрхийлнэ.  $\mu_i$  нь хувь хүний нөлөө,  $\varepsilon_{it}$  нь алдааны нэр томъёо юм.

Загвар 1-ийг шалгахын тулд эмпирик шинжилгээний үр дүнд санамсаргүй нөлөөлөл ба тогтмол эффектийн аль нь Хаусманы тестэд тохирохыг батлах боломжтой болсон ба санамсаргүй нөлөөлөлийн загвар нь илүү тохиромжтой болох нь шинжилгээний хувьд батлагдсан. Дараа нь

бие даасан хувьсагчид нэг хүнд ногдох ДНБ-д хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохын тулд энгийн хамгийн бага квадратын регресс, тогтмол эффект, санамсаргүй нөлөөнд дүн шинжилгээ хийсэн.

Энгийн хамгийн бага квадратын регресс:

1. Судалгаагаар нэг хүнд ногдох ДНБ-д хөдөө аж ахуй дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд сургуулийн өмнөх боловсрол, эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс, аж үйлдвэрийн ажил эрхлэлт нь эерэг нөлөөлөлтэй гарсан. Сургуулийн өмнөх боловсрол нь 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 1.48%-иар өссөх хандлагатай бөгөөд эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь 10%-иар нэмэгдвэл мөн нэг хүнд ногдох ДНБ нь 8.33%-иар өссөх нь судалгаагаар батлагдсан. Түүнчлэн эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт нь 10%-иар өсөх тохиолдолд нэг хүнд ногдох ДНБ нь 3.62%-иар өснө гэж гарсан.
2. Эсэргээрээ нэг хүнд ногдох ДНБ-д хөдөө аж үйлдвэрт ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэнээр ДНБ-д сөргөөр нөлөөлж буй үр дүн ажиглагдаж байна. Хөдөө аж үйлдвэрт ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо 10%-иар өсвөл нэг хүнд ногдох ДНБ нь 5.83%-иар буурах хандлагатайг харуулж байна.

Санамсаргүй нөлөө:

1. Сургуулийн өмнөх боловсрол болон эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт, эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь нэг хүнд ногдох ДНБ-д эерэгээр нөлөөлж статистикийн ач холбогдолтой хамааралтай болохыг баталсан. Бие даасан хувьсагчдын нөлөөллийн хамаарлыг нарийвчлан авч үзвэл сургуулийн өмнөх боловсрол 10%-р өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь ойролцоогоор 1.49%-иар өсдөг байгаа нь харагдаж байна. Тэгвэл эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт нь 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 1.95%-иар өссөн батлагдсан. Эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 7.94%-иар өсөх хандлагатай нь судалгаагаар нотолсон.
2. Нөгөө талаас хөдөө аж ахуй дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нь сөрөг нөлөөлөлтэй болох нь батлагдсан. Хөдөө аж ахуй дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нь 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 7.68%-иар бууруулж байгааг харуулсан.

Тогтмол эффект:

1. Нэг хүнд ногдох ДНБ-д эмэгтэйчүүдийн сургуулийн өмнөх боловсрол болон эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь эерэгээр нөлөөлдөг болох нь судалгаагаар харагдаж байна. Эмэгтэйчүүдийн сургуулийн өмнөх боловсрол нь 10%-иар өссөн тохиолдолд нэг хүнд ногдох ДНБ нь 1.46%-иар өсдөг. Тэгвэл аж үйлдвэрлэлийн ажил эрхлэлт нь 10%-иар өссөнөөр нэг хүнд ногдох ДНБ нь 1.95%-иар өссөлттэй байх нь судалгаагаар батлагдсан. Судалгаагаар мөн эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 7.56%-иар өсөх хандлагатай нь судалгаагаар нотолсон.
2. Хөдөө аж ахуй дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нь энгийн квадратын регресс болон санамсаргүй нөлөөллийн үр дүнгээр сөрөг нөлөөлөлтэй гарсан нь харагдаж байгааг тогтмол эффектрүү хөдөө аж ахуй дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 10%-иар өсөхөд нэг хүнд ногдох ДНБ нь 8.11%-иар буурах хандлагатай байгаа нь харагдаж бай

на.

[Хүснэгт 2] Нэг хүнд ногдох ДНБ-д нөлөөлөх хувьсагчдийн үр дүн

| VARIABLES            | (1)<br>OLS            | (2)<br>Random Effects | (3)<br>Fixed Effects  |
|----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| lnh                  | 0.134***<br>(0.0366)  | 0.164***<br>(0.0205)  | 0.165***<br>(0.0208)  |
| lnLawScore           | 0.549***<br>(0.140)   | 0.898***<br>(0.120)   | 0.914***<br>(0.123)   |
| lnAgriculture        | -1.163***<br>(0.0741) | -0.766***<br>(0.0530) | -0.756***<br>(0.0541) |
| lnIndustry           | 0.110<br>(0.0768)     | 0.0970**<br>(0.0477)  | 0.0920*<br>(0.0484)   |
| lnEmployersfemale    | -0.0867**<br>(0.0367) | 0.0646***<br>(0.0167) | 0.0661***<br>(0.0168) |
| Constant             | 8.752***<br>(0.702)   | 5.894***<br>(0.554)   | 5.770***<br>(0.552)   |
| Observations         | 322                   | 322                   | 322                   |
| R-squared            | 0.683                 | 0.853                 | 0.853                 |
| Number of countries1 |                       | 18                    | 18                    |
| Country RE           |                       | YES                   |                       |

Standard errors in parentheses \*\*\* p<0.01, \*\* p<0.05, \* p<0.1

## 2. Загвар 2, хувьсагчдын тайлбар болон үр дүн

[Хүснэгт 3] Загвар 2 дэх хувьсагчдын тайлбар

| Хамааралтай хувьсагч                       | Бие даасан хувьсагч   |
|--|---|
| Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн | 1. Төрөлтийн түвшин<br>Төрөлтийн нийт коэффициент гэдэг нь эмэгтэй хүн төрөх насаа дуустал амьдарч, тухайн жилийн төрөлтийн насны онцлогт тохируулсан хүүхэд төрүүлсэн тохиолдолд төрөх хүүхдийн тоог илэрхийлнэ. |

Загвар 2 – Дээрх хүснэгтээр дурьдчилан дараах байдалтай байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөх хувьсагчуудын шинжилгээны загвар

$$\ln Y_{it} = \beta_0 + \beta_1 \ln Fertility_{it} + \mu_i + \varepsilon_{it} \quad (2)$$

Дээрх тэгшитгэлд (Загвар 1)  $i$  нь Азийн хөгжиж буй орнуудыг ( $i = 1, 2, 3, \dots, 20$ ),  $t$  нь жилийг ( $t = 1995, 1996, \dots, 2019$ ) илэрхийлнэ.  $\mu_i$  нь хувь хүний нөлөө,  $\varepsilon_{it}$  нь алдааны нэр томъёо юм.

Загвар 2-ийг шалгахын тулд эмпирик шинжилгээний үр дүнд санамсаргүй нөлөөлөл ба тогтмол эффектийн аль нь Хаусманы тестэд тохирохыг батлах боломжтой болсон ба санамсаргүй нөлөөлөлийн загвар нь илүү тохиромжтой болох нь шинжилгээний хувьд батлагдсан.

Судалгааны үр дүнд энгийн хамгийн бага квадратын регресс, санамсаргүй нөлөө болон тогтмол эффектийн үр дүнгүүдэд бүгдэнд нь төрөлтийн түвшин нь нэг хүнд ногдох ДНБ-д сөрөг нөлөөтэй гарсан ба үүнээс санамсаргүй нөлөөллийн хариуг нь сонгох нь тохиромжтой бөгөөд төрөлтийн түвшин нь 10%-иар өссөн тохиолдолд нэг хүнд ногдох ДНБ нь 12.20%-иар буурах нь харагдаж

байна.

[Хүснэгт 4] Нэг хүнд ногдох ДНБ болон төрөлтийн түвшиний харьцуулсан үр дүн

|                      | (1)                  | (2)                   | (3)                   |
|----------------------|----------------------|-----------------------|-----------------------|
| VARIABLES            | OLS                  | Random Effects        | Fixed Effects         |
| lnFertilityrate      | -1.699***<br>(0.114) | -1.220***<br>(0.0906) | -1.206***<br>(0.0915) |
| Constant             | 9.012***<br>(0.115)  | 8.548***<br>(0.178)   | 8.534***<br>(0.0899)  |
| Observations         | 500                  | 500                   | 500                   |
| R-squared            | 0.308                | 0.266                 | 0.266                 |
| Number of countries1 |                      | 20                    | 20                    |
| Country RE           |                      | YES                   |                       |

Standard errors in parentheses \*\*\* p<0.01, \*\* p<0.05, \* p<0.1

### 3.Загвар3, хувьсагчдын тайлбар болон үр дүн

[Хүснэгт 5] Загвар 3 дэх хувьсагчдын тайлбар

| Хамааралтай хувьсагч  | Бие даасан хувьсагч  |
|---|--|
| Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин<br>Ажиллах хүчний оролцооны түвшин гэдэг нь эдийн засгийн идэвхтэй 15-64 насны хүн амын эзлэх хувь буюу тодорхой хугацаанд бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд ажиллах хүч нийлүүлдэг бүх хүмүүсийн эзлэх хувь юм. | 1. Төрөлтийн түвшин<br>Төрөлтийн нийт коэффициент гэдэг нь эмэгтэй хүн төрөх насаа дуустал амьдарч, тухайн жилийн төрөлтийн насны онцлогт тохируулан хүүхэд төрүүлсэн тохиолдолд төрөх хүүхдийн тоог илэрхийлнэ.   |
|   | 2. Эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индексийн оноо<br>Энэ индекс нь хууль тогтоомж нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжид хэрхэн нөлөөлж байгааг хэмждэг. Нийт оноо 100 оноо нь хамгийн өндөр буюу 100 гэсэн найман чиглэлийн (Ажиллах, ажилд орох, цалин авах, гэрлэх, хүүхэд төрүүлэх, бизнес эрхлэх, тэтгэвэр авах) дундаж оноог авч тооцдог индекс.. |
|   | 3. Шашин болон байр байдал<br>Азийн хөгжиж буй орнуудын хувьд Будда, Мусульман шашинтай улс орон их байдаг ба үүнийгээ даган шашин нь эдийн засгийн өсөлтөд хэр нөлөөлдөг болохыг дамми хувьсагчруу шилжүүлэн судалсан.  |
|   | 4. Гэрлэсэн эмэгтэйчүүд<br>15-24 насны гэрлэсэн эмэгтэйчүүдийн тоо   |

Загвар3 – Дээрх хүснэгтээр дурьдчилан дараах байдалтай байна.

Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлөх хувьсагчдын загвар

$$\ln LawScore_{it} = \beta_0 + \beta_1 \ln Married_{it} + \beta_2 \ln LawScore_{it} + \beta_3 \ln Fertilityrate_{it} + \beta_4 Dummy_{it} + \mu_i + \varepsilon_{it}$$

(3)

Дээрх тэгшитгэлд(Загвар 1)  $i$  нь Азийн хөгжиж буй орнуудыг ( $i = 1, 2, 3, \dots, 20$ ),  $t$  нь жилийг ( $t = 1995, 1996, \dots, 2019$ ) илэрхийлнэ.  $\mu_i$  нь хувь хүний нөлөө,  $\epsilon_i$  нь алдааны нэр томъёо юм. Загвар 3-ийг шалгахын тулд эмпирик шинжилгээний үр дүнд санамсаргүй нөлөөлөл ба тогтмол эффектийн аль нь Хаусманы тестэд тохирохыг батлах боломжтой болсон ба санамсаргүй нөлөөлөлийн загвар нь илүү тохиромжтой болох нь шинжилгээний хувьд батлагдсан.

Энгийн хамгийн бага квадратын регресс:

1. Судалгаараар төрөлтийн түвшин болон дамми хувьсагч буюу шашны байр байдал нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд сөргөөр нөлөөлдөг болох нь батлагдсан. Төрөлтийн түвшин нь 10%-иар өссөн тохиолдолд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин нь 2.97%-иар буурахаар харагдаж байна. Түүнчлэн шашны байр байдал нь 10%-иар өссөн тохиолдолд 4.95%-иар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин нь буурах хандлагатай байгаа нь судалгаагаар батлагдлаа.
2. Харин гэрлэлт болон эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индексийн оноо нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлөлгүй болох нь судалгаараар харагдаж байна.

Санамсаргүй нөлөө:

1. Эмэгтэйчүүдийн гэрлэлт болон шашны байр байдал нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд сөргөөр нөлөөлдөг нь судалгаанаас харагдаж байна. Эмэгтэйчүүдийн гэрлэлт нь 10%-иар өсвөл дагаад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь 0.474%-иар буурдаг ба шашны байр байдал нь 10%-иар өсвөл мөн адил эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо нь 4.57%-иар буурдаг нь харагдаж байна.
2. Түүнчлэн төрөлтийн болон эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс нь Азийн хөгжиж буй 20 орны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд нөлөөлөлгүй болох нь судалгаанаас харагдлаа.

Тогтмол эффект:

1. Тогтмол эффектийн үр дүнгээс эмэгтэйчүүдийн гэрлэлт нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд сөргөөр нөлөөлдөг гэсэн үр дүн гарсан. Энэ нь эмэгтэйчүүдийн гэрлэлт нь 10%-иар өссөн тохиолдолд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 0.498%-иар буурах хандлагатай харагдаж байна.
2. Мөн түүнчлэн төрөлтийн түвшин, эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индексийн оноо болон шашны байр байдал нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлөлгүй болох нь батлагдлаа.

#### 4. Дүгнэлт

Дээр өгүүлсэн судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн үзвэл Азийн хөгжиж буй орнуудын хувьд одоо хүртэл хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал болон нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтуудыг нягтлан үзвэл эдийн засгийн болон амьдралын бусад

талбарт жендэрийн ялгаатай байдал байсаар байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн эдийн засгийн өсөлтөд эмэгтэй хүмүүсийн оролцоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Загвар1: эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэхийн хирээр эдийн засгийн өсөлт харагдаж байна.<sup>18</sup> Эмэгтэйчүүдийн хүний капиталд оруулах хөрөнгө оруулалт нь Азийн хөгжиж буй улсуудын хувьд эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-г нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг нь судалгааны явцад батлагдсан. Тиймээс эмэгтэйчүүдийн хүний капиталд оруулах хөрөнгө оруулалтыг улам нэмэж өгсөнөөр гарах үр дүн нь эдийн засаг нэмэгдэхээс гадна эхийн эндэгдэл багасах, эмэгтэйчүүдийн дундаж наслалт нэмэгдэх, дээд боловсролтой эмэгтэйчүүд нэмэгдэх гэх мэт олон эерэг үр дагвартай байдаг бөгөөд тиймээс тухайн улс бүр эмэгтэйчүүдийн боловсролт анхаарал хандуулах мөн түүгээрээ эдийн засгийн өсөлтийг бий болгох олон үр дүнтэй гарц гаргалгаа олж харж болно. Түүнчлэн эмэгтэйчүүдийн бизнес ба хуулийн индекс сайжрахын хирээр нэг хүнд ногдох ДНБ нь нэмэгдэж байгаа үзүүлэлт гарсан. Үүгээрээ тухайн улс орон хуулийн хүрээнд хэрхэн зөв алхам хийх болон бизнесийн дарамт учруулахгүй/татварын бодлогын хүрээнд, эмэгтэйчүүдийн ажлын байрны дарамт гэх мэт/ аль болох багасгах бодлого баримталснаараа эдийн засгийн өсөлтийг авчрах боломжтой юм. Үүний дараагаар эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт нь нэмэгдэхийн хирээр нэг хүнд ногдох ДНБ өсдөг нь судалгаагаар батлагдсан. Мөн хөдөө аж ахуйд ажиллаж буй эмэгтэйчүүд нэмэгдэхийн хирээр эдийн засгийн өсөлт буурдаг нь үнэн болно. Энэ нь эмэгтэйчүүдийн аж үйлдвэрийн ажил эрхлэлт нь ажлын нөхцөл боломжийн бөгөөд илүү уян хатан чанарыг агуулсанаараа хөдөө аж ахуйд ажиллаж буй эмэгтэйчүүдтэй харьцуулахад эерэг үр дүн ихтэй байгаа нь харагдаж байна. Илүү аж үйлдвэрлэлийн ажил эрхлэлт хийснээрээ илүү боловсрох боломж буюу дэвших боломжыг олгож өгдөгөөрөө онцлогтой байж болно. Тиймээс цаашдаа илүү хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулж хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгах, ажил мэргэжлийн ирээдүйд зайлшгүй хийгдэх ёстой өөрчлөлтөнд бэлдэж эмэгтэйчүүдийн ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг тухайн улс тус бүр хамтран хэрэгжүүлвэл илүү их эдийн засгийг хөгжүүлж болох боломж бий юм.

Загвар2: төрөлтийн түвшин нь нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт буурах хандлагатай байгаа нь судалгаагаар батлагдсан. Энэ Азийн хөгжиж буй улсуудын хувьд төрөлт нь нэмэгдсэнээр эмэгтэй хүмүүс ажил хийх боломжгүй болдог ба амжиргааны түвшин буурдагтай холбож болох юм. Зөвхөн амжиргааны түвшинөөс гадна институци, нийгэм, төрийн бодлоготой хамаатуулж тайлбарлаж болох юм. Хөгжил тааруу мөн түүнчлэн хууль эрх зүйн зохицуулалт муутай Азийн хөгжиж буй орнуудын хувьд төрөлт гэдэг нь нэг талаараа улсдаа хөрөнгө оруулалт хийж буй мэт боловч нөгөө талаараа өөрсдийгөө эрсдэлд оруулж байдаг. Тиймээс тухайн улсуудын хувьд эмэгтэйчүүдийг дэмжих бодлого баримтлах хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлж өгөх хэрэгтэй нь харагдаж байна. Үүний дараагаар эмэгтэйчүүдийн төрөлт нэмэгдэж нэг талаасаа улсдаа хөрөнгө оруулалт хийн залуу хойч үеийг илүү тайван байдлаар бүтээн бий болгох боломжтой юм. Ихэвчлэн эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын хувьд төрөлт болон хүн ам нэмэгдэхийн хирээр эдийн засаг мөн даган өсдөг. Харин бидний судалгааны үр дүнгээс харахад Азийн хөгжиж буй орнуудын хувьд төрөлтийн өсөлт нь эдийн засгийн өсөлтийг авчрахгүй байгааг харуулж

---

<sup>18</sup> Torabi, Fatemeh and Abbasi-Shavazi, Mohammad Jalal (2015). Women's Human Capital and Economic Growth in the Middle East and North Africa. *Journal of International Women's Studies*, 16(3), 237-261.

байна.

Загвар3: гэрлэлт болон шашны байр байдал нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшинг бууруулдаг нь судалгаагаар батлагдсан. Азийн хөгжиж буй орнуудын хувьд гэрэлтийг бууруулсанаар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж болох үр дүн гарсан. Энэ нэг талаараа бидний судалгаандаа авч үзсэн Азийн орнуудын хувьд гэрэлсэнээрээ ажил хийх нь багасах мөн түүнчлэн хүүхэд гаргах гэх мэтээр нийгмийн харилцаанаас гарч гэртээ суух нь ихэсдэг. Мөн эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоонд шашны байр байдал мөн сөргөөр нөлөөлдөг байна. Шашин нь нэмэгдэхийн хирээр ажиллах эмэгтэй хүмүүс багасаж байна. Нийгмийн янз бүрийн хэм хэмжээ, хандлага, соёлын болон институцийн хүчин зүйлийг хүндэтгэдэг өөр өөр шашин (Лалын шашинтнууд ба Христэд итгэгчид) улс орнуудад харилцааны мөн чанар өөр өөр байж болно (Фернандес, 2013)<sup>19</sup>. Жишээлбэл, лалын шашинтай орнуудад шашны хязгаарлалтын улмаас эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх эрхгүй байдаг тул эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо хаалттай байсаар байна. Тиймээс бидний судлагаанд хамрагдаж байгаа улсын тал хувь нь Лалын шашинтай улс орон байгаа юм. Үүнээс үзэхэд Азийн хөгжиж буй 20 улсын хувьд эмэгтэйчүүдийн боловсролын түвшинг нэмэгдүүлэх, эмэгтэй хүмүүсийн ажиллаж буй бизнесийн салбарт хууль зүйг бүрэн хангаж аж үйлдвэрт ажиллаж буй эмэгтэйчүүдийг улам нэмэгдүүлсэнээр эдийн засгийг нэмэгдүүлж болох нь харагдаж байна. Гэрлэлтийн зөв зохистой байдлыг хангаж сургуулийн боловсрол олгож байхдаа гэр бүл төлөвлөлт хэрхэн хийх, төрөлтийн талаар хичээл оруулах эрсдэлийг таниулж өгөх хэрэгтэй нь хойчдоо эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг давхар авчрах боломжтойг харуулж байна.

## Ашигласан материал

[1] World bank <https://www.worldbank.org/>

[2] World Bank base <https://data.worldbank.org/>

---

<sup>19</sup> Ana González-Fernández(2013) [Quality & Quantity: International Journal of Methodology](#), 2013, vol. 47, issue 2, 895 pages, Weak cognitive image of cultural tourism destinations

- [3] United Nations Conference on Trade and Development
- [4] <https://unctadstat.unctad.org/EN/Index.html>
- [5] Amaia Altuzarra, Catalina Gálvez-Gálvez(2019) <https://www.mdpi.com/journal/sustainability>, Economic Development and Female Labour Force Participation: The Case of European Union Countries
- [6] Paolo Verme, Abdoul Gadir Barry, Jamal Guennouni(2014) Policy Research Working Paper-7031, Female Labor Participation in the Arab World Some Evidence from Panel Data in Morocco
- [7] Fatma Fehime AYDIN, Ekrem ERDEM(2014), Erciyes University Faculty of Economics and Management, Journal, Issue: 44, July-September 2014 p. THE EFFECT OF WOMEN'S EMPLOYMENT ON COMPETITIVENESS AND ECONOMIC GROWTH: A COMPARISON OF TURKEY AND THE MOST COMPETITIVE COUNTRIES
- [8] Alison Vásconez Rodríguez(2017) Associate Professor with the Latin American Faculty of Social Sciences (FLACSO). [avasconez@facso.edu.ec](mailto:avasconez@facso.edu.ec), Economic growth and gender inequality: an analysis of panel data for five Latin American countries
- [9] Ana González-Fernández(2013) Quality & Quantity: International Journal of Methodology, 2013, vol. 47, issue 2, 895 pages, Weak cognitive image of cultural tourism destinations
- [10] Dutt (1990), Lo Vuolo (2009) and Bhaduri (2007), For further information on the debate surrounding growth theory as viewed from the standpoint of effective demand
- [11] Erturk and Darity(2000), Secular Changes in the Gender Composition of Employment and Growth Dynamics in the North and the South, World Development, 2000, vol. 28, issue 7, 1231-1238
- [12] Benería, 2005 and 2008, At the global level, the feminization of the workforce and the employment conditions associated with that process have given rise to structural inequalities in international labour markets and to increasing informalization as a result of the demand for capital.
- [13] Blecker and Seguino(2002), Macroeconomic Effects of Reducing Gender Wage Inequality in an Export-Oriented, Semi-Industrialized Economy, Review of Development Economics, 2002, vol. 6, issue 1, 103-119
- [14] Jenkins, S. Gender, Place and the labour Market ASHGATE 200
- [15] TZANNATOS, Zachariadis; (1999), "Women and Labor Market Changes in the Global Economy: Growth Helps, Inequalities Hurt and Public Policy Matters", World Development, 27(3), pp. 551-569.
- [16] DOLLAR, David and Roberta GATTI; (1999), "Gender Inequality, Income and Growth: Are Good Times Good for Women", Policy Research Report on Gender and Development Working Paper Series, 1, pp. 1-40.
- [17] KLASSEN, Stephan and Francesca LAMANNA; (2009), "The Impact of Gender Inequality in Education and Employment on Economic Growth: New Evidence for A Panel of Countries", Feminist Economics, 15(3), pp. 91-132.
- [18] Torabi, Fatemeh and Abbasi-Shavazi, Mohammad Jalal (2015). Women's Human Capital and Economic Growth in the Middle East and North Africa. Journal of International Women's Studies, 16(3), 237-261.

## **MSOT-06**

### **Study on the candida species of the children aged between 1-16 with oral mucosal thrush**

Altansukh Suvdan<sup>1</sup>, Tseltmeg Baatarjav<sup>2</sup>, Oyuntsetseg Bazar<sup>3</sup>, Daariimaa Khurelbat<sup>4</sup>,  
Dolgorsuren Bayaraa<sup>5</sup>

<sup>1,2,3</sup> Department of Population Studies, Mongolian National University of Medical Sciences, ,  
suvdanchimeg@mnumns.edu.mn

<sup>4</sup> Department of Pharmacy, Mongolian National University of Medical Sciences

<sup>5</sup> Элит орчи лаборатори

Corresponding Author: Tseltmeg Baatarjav, Oyuntsetseg Bazar, Daariimaa Khurelbat

**Abstract:** Oral candidiasis is considered the most common mycosis occurring in human beings. The prevalence in healthy individuals was ranged between 17-75% and hence 54–71.4% of them occurs asymptomatic. The incidence of *Candida* species from the oral cavity has been reported to be in 45% of infants, 50-65% of people who wear removable full dentures, 55.2% of patients undergoing radiation therapy in the again head-neck cancer. The purpose of this study was to determine the candida species of the oral fungal infection. The children aged between 1-16 months with oral mucosal thrush at the Department of Pediatric and Preventive dentistry, A swab was swabbed from morphological elements of the oral mucosa and placed in a nutrient amies. Collected samples were inoculated with chloramphenicol Saburo dextrose agar medium, which is incubated at 35C for 24 to 48 hours. The patients with thrush aged 1-16 months the most common pathogen was *Candida albicans* with 90% and *Candida tropicalis* in 10%.

**Key words:** Thrush, Candida species, Candida albicans

**Хураангуй:** Хүн амын дунд ихээхэн тархсан салстын өвчнүүдийн нэг болох амны мөөгөнцөрт өвчин нь харьцангуй эрүүл хүмүүст 17-75%-ийн тархалттай тохиолддог ч тэдгээрийн 51-74%-д нь ямар нэг эмнэл зүйн шинж тэмдэг илэрдэггүй байна. Олон улсын судалгааны тоймоос авч үзвэл амны мөөг нь хэвийн жинтэй нярайд 45%, жин багатай, дутуу төрсөн нярайд 20-50%, эрүүл хүүхдэд 50-65%, насанд хүрэгчдэд 30-45%, таарамжгүй, арчилгаа хангалтгүй шахмал шүдэлбэртэй хүмүүст 50-65%, удаан хугацаагаар асаргаанд байдаг хэвтрийн үйлчлүүлэгчдэд 65-88%, химийн эмчилгээ хийлгэж байгаа, лейкозтой өвчтөнд 90%-иас дээш, хүний дархлалын олдмол хомсдлын өвчтэй хүнд 95%-иас дээш, 75-аас дээш насныханд 67%-д тус тус тодорхойлогдсон. Амны мөөгөнцөрт өвчний үүсгэгчийг зүйлийн түвшинд тодорхойлоход бидний судалгааны ажлын зорилго оршино. Нүүр ам судлалын төв эмнэлэгийн Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасгаар үйлчлүүлсэн сүүнцэртэл өвчтэй 1-16 сартай 10 хүүхдийг судалгаанд хамруулан асуумж судалгаа, бодит үзлэг, бичил амь судлалын шинжилгээнд үндэслэн агшингийн судалгааны аргаар хийж гүйцэтгэлээ. Судалгаанд оролцогчдын амны салстад гарсан морфологи элементээс хөвөн бамбараар арчдас авч, тэжээлт орчинд (амиес) хийсэн.

**Түлхүүр үг:** Сүүнцэртэл өвчин, мөөгний зүйл, *Candida albicans*

## 1. Удиртгал

Амны салстын сүүнцэртэл өвчтэй үйлчлүүлэгчээс шинжилгээг авч өсгөвөрлөн мөөгний ямар зүйл давамгайлж буйг илрүүлж үүсгэгчид тохирсон эмчилгээг хийх нь судалгааны ажлын шинэлэг тал боллоо. Бид агшингийн судалгааны загварыг ашиглан АШУҮИС-ийн, НАСТЭ-ийн

ХНАСУС-ийн тасгаар үйлчлүүлсэн амны салстын сүүнцэртэл өвчтэй 1-16 сартай 10 хүүхдийг хамруулсан. Судалгааны үр дүнг статистикийн Stata-15, Microsoft Excel программ ашиглан боловсруулалт хийж, нарийвчилсан статистик шинжилгээг хийлээ. Судалгааны үр дүнг үнэлэхдээ статистик ач холбогдлыг  $p$  утга 0.05-аас бага байх тохиолдолд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдлаа гэж үнэлсэн. АШУҮИС - ийн Судалгааны Ёс зүйн Хяналтын хорооны 2021.06.04 өдрийн хурлаар судалгааг явуулах Ёс Зүйн зөвшөөрөл авсан. Судалгаанд оролцогчийн хууль ёсны асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрөл авсны дараа судалгаанд хамруулсан болно.

## 2. Онолын судлагдсан байдал

Амны мөөгөнцөрт өвчин нь хүн амын дунд ихээхэн тархсан салстын өвчнүүдийн нэг юм. Бие махбодын хувьд эрүүл хүмүүст амны мөөгөнцөрт өвчин 17-75%-ийн тархалттай байдаг ба эдгээрийн 51-74%-д нь ямар нэгэн шинж тэмдэг илэрдэггүй байна [1] [2].

Тохиолдлоор нь авч үзвэл нярайд 45%, жин багатай, дутуу төрсөн нярайд 20-50%, эрүүл хүүхдэд 50-65%, эрүүл насанд хүрэгсдэд 30-45%, таарамжгүй, арчилгаа хангалтгүй шахмал шүдэлбэртэй хүмүүст 50-65%, удаан хугацаагаар өвдсөн, асаргаанд байдаг хэвтрийн өвчтөнд 65-88%, химийн эмчилгээ хийлгэж байгаа, цусны хавдартай өвчтөнд 90%-иас дээш, хүний дархлалын олдмол хомсдлын өвчтэй хүнд 95%-иас дээш, 75-аас дээш насны хүмүүсийн 67%-д тус тус илэрдэг байна [3][4]. Мөөгөнцөрт өвчнийг АНУ-д ерөнхий халдварт өвчний дотор цусны халдварын 4 дүгээрт ордог өндөр тархалттай өвчин гэж үздэг байна [5]. Дэлхийн нийт хүн амын 20% нь ямар нэгэн байдлаар мөөгөнцрийн халдвар авч байсан талаар 2005 онд ДЭМБ мэдээлсэн байдаг [6].

Амны мөөгөнцөрт өвчнийг үүсгэгч мөөгний 150-200 орчим төрөл тодорхойлогдсоноос [7] *Candida albicans* нь хамгийн өндөр тархалттай тохиолддог бөгөөд эрүүл болон өвчтэй хүний 60-80%-д нь илэрдэг эмгэг төрөгч юм [8]. Мөн *C. glabrata*, *C. krusei*, *C. parapsilosis*, *C. dubliniensis*, *C. tropicalis*, *C. kefyr*, *C. guilliermondii* төрлүүд түгээмэл илэрдэг [1, 7, 8].

## 3. Дизайн аргачлал

Амны салстын мөөгөнцрийн үүсгэгчийн ялган дүйх шинжилгээг бичил амь судлалын лабораторт хийж гүйцэтгэсэн. АШУҮИС-ийн НАСТЭ-ийн ХНАСУС-ийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн асран хамгаалагчаас 2 бүлэг 13 асуулт бүхий асуумж судалгааг авч, мэдээллийг картад тэмдэглэсэн. Үзлэгийн өрөөнд, нүүр амны үзлэгийн сандал дээр үйлчлүүлэгчийг суулган байгалийн болон нэмэлт гэрэлтүүлэг дор нэг удаагийн үзлэгийн толь, хэл дарагчийн тусламжтайгаар амны хөндийд үзлэг хийж салстад гарсан анхдагч, хоёрдогч морфологи элемент, түүний хэлбэр, хэмжээ, байрлал зэргийг тодорхойлж амны сүүнцэртэл өвчний шинж тэмдгүүдийг /хацар, хэл, тагнай, буйл, залгиур, төвөнхийн салстад цайвар цагаан ээдэм шиг өнгөр тогтсон, хялбар хусагдан өнгөр нь ховхордог/ үзлэгийн картад тэмдэглэлээ.

### Бичил амь судлалын шинжилгээ

- **Шинжлэгдэхүүн цуглуулсан нь:**

Судалгаанд оролцогчдын амны салстад гарсан морфологи элементээс зориулалтын хөвөн бамбараар бага зэргийн даралттайгаар арчдас авч, тэжээлт орчинд (амиес) хийсэн.

- **Шинжлэгдэхүүн зөөвөрлөсөн нь:**


Цуглуулсан шинжлэгдэхүүнийг зохих журмын дагуу тээвэрлэн, 2-4 цагийн дотор лабораторт хүргэсэн.

**Өсгөвөрлөх шинжилгээ**

1. Цуглуулсан шинжлэгдэхүүнийг мөөгний сонгомол тэжээлт орчин болох Хлорамфениколтой Сабуро декстроз (Sabouraud Dextrose Agar SDA) тэжээлт орчинд тарьж 35<sup>0</sup>С хэм бүхий термостатад 24-48 цагийн турш өсгөвөрлөсөн.
2. Сабуро декстроз тэжээлт орчинд ургасан колонийг грамын аргаар будаж, микроскопоор дүгнэн, мөөгний колонийг ялган авч өвөрмөц тэжээлт орчин буюу Хром Агарт (CHROMagar-Candida) сэлгүүлэн тарьж 35<sup>0</sup>С хэмд 24-48 цагийн турш өсгөвөрлөсний дараа цэвэр өсгөвөрийг ялган авсан.

Өсгөвөрийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

- *Candida albicans* – Ногоон
- *Candida glabrata* – Цагаан шаргал
- *Candida krusei* – Нил ягаан
- *Candida tropicalis* – Цэнхэр




[Зураг 1] Мөөгийг тэжээлт орчинд өсгөвөрлөсөн байдал

#### 4. Үр дүн


Судалгаанд 1-16 сартай 10 оролцогч оролцсон ба хүйсийн харьцаа 1;1 байсан бол дундаж нас 6.5± 0.3 сар байлаа. Судалгаанд оролцогчдын 50 хувь нь хугацаанаасаа өмнө төрсөн дутуу нярай байсан. Асуумж судалгаагаар ээжүүдийн 40 хувь нь үтрээний мөөгөнцөрт өвчнөөр өвчилсөн байна.

Асран хамгаалагчдын 50% хүүхдийнхээ амын хөндийг тогтмол цэвэрлэдэг бол, 30% огт цэвэрлэдэггүй, 20% заримдаа цэвэрдэг байна \*p<0.05. [зураг 2]




[Зураг 2] Хүүхдийнхээ амын хөндийг тогтмол цэвэрлэдэг эсэх

Хүүхдийн хооллолтын байдлыг авч үзвэл 60% холимог хооллолттой, 40% дан хөхөөр хооллодог байлаа.




[Зураг 3] Хүүхдийн хооллолт



[Зураг 4] Ээж нь хөхөө тогтмол цэвэрлэдэг эсэх

Хүүхдээ хөхүүлэхдээ ээжүүдийн 50% хөхөө тогтмол цэвэрлэдэг бол 50% үгүй гэж хариулсан байна.



[Зураг 5] Сүүнцэртэл өвчтэй хүүхдэд мөөгний зүйлийг илрүүлсэн дүн

Сүүнцэртэл өвчтэй хүүхдийн 90%-д *C. albicans*, 10% *C. tropicalis* илэрсэн байна. Энэхүү ялгаатай байдал нь 1% түвшинд статистик ач холбогдолтой байна. [ $X^2_{(15)}=36.39$ , p-утга=0.000]

## 5. Дүгнэлт

Амны салстын сүүнцэртэл өвчтэй 1-16 сартай оролцогчдын арчдасын шинжилгээгээр *Candida albicans* давамгайлж, *Candida tropicalis* илэрлээ.

## Ашигласан материал

- [1]Cannon R, Chaffin W:(1999) Oral colonization by *Candida albicans*. *Critical Reviews in Oral Biology & Medicine* 10(3):359-383.
- [2]Hauman CHJ, Thompson IOC, Theunissen F, Wolfaardt P (1993)Oral carriage of *Candida* in healthy and HIV-seropositive persons. *Oral surgery, oral medicine, oral pathology* 76(5):570-572.
- [3]Akpan A, Morgan R(2002) Oral candidiasis. *Postgraduate medical journal* 78(922):455-459.
- [4]Nittayananta W, Jealae S, Winn (2001) Oral *Candida* in HIV-infected heterosexuals and intravenous drug users in Thailand. *Journal of oral pathology & medicine* 30(6):347-354.
- [5]Kao AS, Brandt ME, Pruitt WR, Conn LA, Perkins BA, Stephens DS, Baughman WS, Reingold AL, Rothrock GA, Pfaller MA(1999) The epidemiology of candidemia in two United States cities: results of a population-based active surveillance. *Clinical infectious diseases* 29(5):1164-1170.
- [6]Луницына Ю, Токмакова С (2012) Кандидоз слизистой оболочки полости рта актуальная проблема стоматологии XXI века. *Проблемы стоматологии*(2).
- [7]Odds FC(1988)*Candida* and candidosis: a review and bibliography: Bailliere Tindall;
- [8]Li L, Redding S, Dongari-Bagtzoglou A(2007) *Candida glabrata*, an emerging oral opportunistic pathogen. *Journal of dental research* 86(3):204-215.

SSEC-07

E-Commerce and Taxes

**Хураангуй:** Орчин үеийн технологийн хурдацтай хөгжил, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, глобалчлал нь бидний амьдралд томоохон хэмжээний өөрчлөлтийг бий болгож, үүний нөлөөгөөр уламжлалт эдийн засгаас гадна дижитал эдийн засаг хэмээх шинэ ойлголт бий болсон. Дижитал эдийн засаг нь апп дэлгүүр, онлайн сурталчилгаа, үүлэн тооцоолол, онлайн төлбөрийн үйлчилгээ, цахим худалдаа зэрэг бизнесийн загваруудыг бий болгоод байна. Цахим худалдаа нь компьютерийн сүлжээгээр дамжуулан бараа үйлчилгээ худалдах, худалдан авах үйл явц юм. Цахим худалдаа нь 40 гаруй жилийн түүхтэй бөгөөд анх 1979 онд Английн бизнесмэн Майкл Алдрич санаачлан систем боловсруулж, улмаар Их Британи, Ирланд, Испани зэрэг орнуудад борлуулж байжээ. Цахим худалдааг шууд болон шууд бус хэлбэрээр хийдэг. Мөн b2b (бизнесээс бизнес рүү), b2c (бизнесээс хэрэглэгч рүү), c2c (хэрэглэгчээс хэрэглэгч рүү) гэсэн үндсэн гурван загвартай байдаг. (OECD, 2015) Цахим худалдааны дээрх бизнесийн загваруудаас хамаарч хэн татвар төлөх, хаана татвар ногдуулах, ямар төрлийн татвар төлөх, юунд суурилж татварыг тодорхойлох зэрэг нь ялгаатай байдаг. Цахим худалдааны биет шинж чанаргүй, газар зүйн хувьд тодорхойгүй байдал нь татвар ногдуулахад тодорхой бус байдлыг бий болгодог. Татвар ногдуулахад төвөгтэй байдаг цахим худалдааны төрлүүдийг ангилбал дараах байдалтай байна. Үүнд: Контентод суурилсан (Content-related), хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанууд (Regulated activities), олон талт платформ (Multisided platforms), хэрэглэгчид суурилсан (User-related) гэсэн төрөлтэй байна (World Bank Group, 2021). 2013 онд OECD-ээс татварын суурийг гажуудуулан ашиг шилжүүлэх (BEPS) үйл ажиллагаанаас сэргийлэхийн тулд олон улсын татвар дахь дижиталчлалын үзүүлж буй үр нөлөөг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байна. Хамгийн анх 2016 онд Энэтхэг улс оршин суугч бус, дижитал үйлчилгээ үзүүлэгчийн онлайн зар сурталчилгааны үйл ажиллагаанд татвар ногдуулсан. Үүнээс хойш Европын холбооноос Чех, Франц, Австри зэрэг орнуудад дижитал үйлчилгээний татвар (DST) ногдуулахаар нэвтрүүлсэн нь амжилтгүй болж байжээ. Хамгийн сүүлд Турк улс цахим төлбөр тооцоонд татвар ногдуулж эхэлсэн байна.

**Түлхүүр үг:** Дижитал татвар, цахим худалдаа, бизнесийн загвар, дижитал үйлчилгээний татвар

## ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

### 2.1 Цахим худалдаа гэж юу вэ?

Цахим худалдаа нь дижитал эдийн засгийн бизнесийн шинэ загвар юм. Дижитал эдийн засаг

гэдэг нь дижитал тооцооллын технологид суурилсан эдийн засаг юм. Өөрөөр хэлбэл хүмүүс хооронд, бизнес хооронд, төхөөрөмж хооронд, өгөгдөл хооронд, үйл явц хооронд өдөр бүр хийгдэж байгаа сая сая онлайн холболтуудын үр дүнд бий болж байгаа эдийн засгийн үйл ажиллагаа юм. (Deloitte, 2020)

Цахим худалдаа нь компьютерийн сүлжээгээр дамжуулан бараа үйлчилгээ худалдах, худалдан авах үйл явц юм. Цахим худалдаа нь b2b (бизнесээс бизнес рүү), b2c (бизнесээс хэрэглэгч рүү), c2c (хэрэглэгчээс хэрэглэгч рүү) гэсэн үндсэн гурван загвартай байдаг. (OECD, Addressing the Tax Challenges of the Digital Economy, 2015). Үүнээс гадна дижитал технологийн хөгжилтэй уялдан шинээр d2c (Шууд хэрэглэгч рүү), c2b (Хэрэглэгчээс бизнес рүү) гэсэн бизнесийн загварууд бий болсон байна. (The future of customer engagement and experience)

- d2c нь ямар нэгэн жижиглэнгийн болон бөөний худалдаачин, борлуулагчаар дамжуулалгүйгээр шууд зорилтот хэрэглэгчиддээ бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгож борлуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, Instagram, Pinterest, Facebook, SnapChat зэрэг социал платформуудаар дамжуулан хэрэглэгчиддээ хүрдэг.
- c2b нь дийлэнх тохиолдолд influencer, blogger-ууд байдаг. Өөрөөр хэлбэл бизнесийн байгууллагууд нь эдгээр хүмүүсээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан олон нийтэд хүргэдэг. Энэ тохиолдолд бизнесийн байгууллагууд нь үйлчилгээ авагч буюу хэрэглэгч болдог.

## 2.2 Цахим худалдааны үүсэл хөгжил

Анх 1969 онд цахилгааны инженерийн оюутнууд болох R.Goltz ба Jeffrey Wilkins нар шилэн кабель суурьлуулах үйлчилгээг анх нэвтрүүлсэн. Үүнээс хойш 1979 онд Английн зохион бүтээгч Michael Aldrich телевизорыг утасны шугамаар дамжуулан ажил гүйлгээ боловсруулдаг компьютертэй холбосон цахим худалдааны системийг нэвтрүүлсэн. Энэхүү технологи нь орчин үеийн цахим худалдааны эхлэл нь болсон. Технологийн тасралтгүй хөгжлийн үр дүнд 1994 онд Windows платформ ашиглалтанд орж, 1995 онд Amazon, eBay зэрэг онлайн худалдааны платформууд үүссэн байна. Мөн 1998 онд PayPal нь цахим төлбөрийн системд нэвтэрч мөнгөн шилжүүлэг хийх хэрэгсэл болсон. 1999-2000 онд Alibaba худалдааны сүлжээ цахим худалдааны платформоо нэвтрүүлж, Google анхны онлайн зар сурталчилгааны Google Ad Words хэрэгслийг хэрэглээнд нэвтрүүлсэн.

2005-2017 онд Square компани анхны аппкейшинд суурилсан үйлчилгээг нэвтрүүлсэн бол Google, Apple компаниуд өөрийн цахим худалдааг дэмжсэн төлбөрийн аппкейшнуудыг нэвтрүүлсэн байна. Мөн Facebook болон Instagram хөгжүүлэгчид зар сурталчилгаа ба борлуулалтын сувгуудыг ашиглалтанд оруулсан байна.

2017 оноос хойш өнөөг хүртэл социал медиа нь борлуулалтаа өсгөх, брэндээ таниулах гол хэрэгсэл болсон. Ложистикын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан болон автомажсан хэрэгслүүдийг ашиглах болсноор компаниудын үйл ажиллагааны зардалд ихээхэн хэмжээний хэмнэлт бий болсон. COVID-19 цар тахлын улмаас хэрэглэгчид худалдан авалтаа цахимаар түлхүү хийх хандлагатай болж, үүнээс улбаалан бизнес эрхлэгчдийн хүргэлтийн зардал ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн байна. Бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон сувгаар (omnichannel) хэрэглэгчдэд хүргэхийг зорих болсон. Өөрөөр хэлбэл, уламжлалт дэлгүүр, социал

медиа, вэб сайт, гэрээт борлуулагчаар дамжуулан борлуулах буюу нэг дор борлуулалтын хэд хэдэн сувгийг зэрэг ашигладаг болсон. (Shiprocket)

### 2.3 Цахим татвар

Дижитал эдийн засаг нь мэдээлэл, харилцаа холбооны технологиос үүдэлтэй өөрчлөлтийн үр дүн бөгөөд технологийг илүү хямд, хүчирхэг, өргөн цар хүрээтэй болгож, бизнесийн үйл явцыг сайжруулах, эдийн засгийн бүх салбарт инновацийг идэвхжүүлэх арга зам болсон. (Addressing the Tax Challenges of the Digital Economy, ACTION1, 2015)

Сүүлийн үеийн хурдацтай, өргөн цар хүрээтэй дижитал өөрчлөлт нь эдийн засаг, нийгэмд гүнзгий нөлөөлж, томоохон өөрчлөлтийг бий болгож байна. Энэ нь дэлхийн улс орнуудын хууль эрхзүйн зохицуулалтанд маргаантай байдлыг бий болгосон ба олон улсын татварт томоохон сорилт болж байна. Тухайлбал татварыг хаана төлөх ёстойг тодорхойлох, байнга оршин суугчийг тодорхойлох, ашгийн аль хэсэгт татвар ногдуулах, татварын тодорхой байдал мөн давхар татварыг арилгах гэх мэт асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Дижитал эдийн засгийн үр дүнд бизнесийн шинэ загварууд бий болж байгаа бөгөөд эдгээр нь дараах шинж чанарыг агуулж байна.

- Дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүсийг холбож байгаа. Өөрөөр хэлбэл, хамтын эдийн засгийг бүтээж, хуваалцаж байна.
- Үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгч хоёр хол байгаа ч гэсэн ажил, үйлчилгээ явуулах боломжийг олгож байна.
- Дэд бүтэц болон үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн байгаа газарт хүрч очихыг шаарддаггүй.

Дижитал эдийн засгийг татваржуулахад уламжлалт ба орчин үеийн татварын тогтолцооны ялгааг анхаарч үзэх нь зүйтэй юм. (Г.Алтанзаяа, 2020)

#### Уламжлалт татварын тогтолцоо

- Нутаг дэвсгэрийн болон биет байдалтай
- Татваржуулах бодит бүс болон татваржуулах эрх бүхий бүс тодорхой

#### Орчин үеийн татварын тогтолцоо

- Даяарчлагдсан болон дижиталчлагдсан
- Татваржуулах бодит бүс болон татваржуулах эрх бүхий бүс тодорхойгүй

XXI зууны бизнес нь өнгөрсөн үеийн бизнесээс ялгагдах ялгаа нь биет бус хөрөнгө, түүний хөдөлгөөн нь биет буюу бодит зүйлсийн ажил гүйлгээнээс илүү орлого бий болгож байгаа бөгөөд уг орлого нь ямар этгээдэд харьяалагдаж байгааг тодорхойлоход төвөгтэй байдаг учир татвараас зайлсхийх хэрэгсэл болж байна.

Дижитал бизнесийн загваруудад татварыг ногдуулахад төвөгтэй байдаг ба үүнтэй холбоотойгоор эдгээр загваруудыг дараах байдлаар ангилж болно. (World Bank Group, 2021)

[Хүснэгт1]. Дижитал бизнесийн загварын төрлүүд

| Дижитал бизнесийн загварын төрлүүд | Дижитал бизнесийн жишээ |
|------------------------------------|-------------------------|
| Контентод суурилсан                |                         |

|  |   |
|--|---|
| 1. Дижитал контенттыг борлуулах  | 1.1 Kindle Store, Apple iTunes Store  |
| 2. Дижитал контенттыг лицензээр ашиглуулах   | 2.1 Microsoft, IBM, Apple, Cisco, Oracle  |
| 3. Дижитал контенттыг захиалгаар ашиглуулах  | 3.1 Netflix, Spotify, Amazon Prime  |
| <i>Хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанууд</i>   |   |
| 4. Виртуал банк  | 4.1 First Direct, ING Direct, Revolut   |
| 5. Виртуал даатгал   | 5.1 ZhongAn, Bowtie, Insurance  |
| 6. Онлайн бооцоот тоглоом  | 6.1 Bet365, Bwin, Betfair, 888  |
| <i>Олон талт платформ</i>  |   |
| 7. Цахим худалдааны платформ   | 7.1 Amazon, Uber, Airbnb, Booking, eBay, Alibaba, Tencent, Expedia, crowdfunding platforms, online poker  |
| <i>Хэрэглэгчид суурилсан</i>   |   |
| 8. Хэрэглэгчид суурилсан өгөгдөл ба хэрэглэгчид бий болгодог дижитал контентуудын борлуулалт | 8.1 Facebook, Instagram, Twitter<br>9.1 Google, ADS, Amazon, LinkedIn, Alibaba, YouTube, Facebook, Reddit |
| 9. Хэрэглэгчдэд чиглэсэн онлайн сурталчилгаа   | 10.1 Instagram, LinkedIn, WhatsApp, Skype, Waze, YouTube, Fitbit  |
| 10. Дижитал бизнесийн нэр хүндийн борлуулалт   |   |

## ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### 3.1 Олон улсын цахим худалдааны өнөөгийн байдал

Дэлхийн нийт хүн амын интернетийн хэрэглээ жил ирэх тусам өсч байна. 2009 онд 1.7 тэрбум буюу нийт хүн амын 26% нь интернет хэрэглэдэг байсан бол 2019 онд 4.1 тэрбум буюу нийт хүн амын 54% нь интернет хэрэглэдэг болсон байна. Сүүлийн арван жилд ийнхүү 2.4 дахин өссөн нь интернетэд суурилсан цахим худалдааны зах зээлийн хэмжээ огцом нэмэгдэх шалтгаан болж байна.

2020 оны 1 дүгээр сарын байдлаар дэлхийн интернет хэрэглэгчдийн тоо 4.54 тэрбумд хүрсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 7%-ийн өсөлттэй буюу нийт хүн амын 59%-г эзлэж байна. Мөн гар утас хэрэглэгчдийн тоо 5.19 тэрбумд хүрсэн байгаа нь бидний амьдарлын өдөр тутмын салшгүй хэрэглээ болсоор байгааг илтгэж байна (*Зураг 1*). Нэг хүн өдөрт дунджаар 6 цаг 43 минутыг интернет орчинд өнгөрүүлж байгаагийн 3 цаг 22 минут нь гар утсаа ашиглан нэвтэрсэн байна.


Зураг 1. Дэлхийн хүн амын интернет хэрэглэгчдийн тоо (2020 оны 1 сарын байдлаар)



Хүн амын интернетийн хэрэглээ өсөн нэмэгдэхтэй уялдан дэлхийн цахим худалдааны зах зээлийн хэмжээ 2019 онд 3.5 их наяд ам.долларт хүрч сүүлийн 5 жилд 2.6 дахин өсчээ. eMarketer 2019 судалгааны тайлангаас харахад жижиглэн цахим худалдааны борлуулалт 2023 он гэхэд 6.5 их наяд ам.доллар буюу 2019 оноос 85%-иар өсөх, жижиглэн худалдааны зах зээлд эзлэх хувь 14%-иас 22% болж өсөх хандлагатай байна. Харин жилийн борлуулалтын өсөлт саарч 15% болж буурах төлөвтэй байгааг дурджээ. (eMarketer, 2019)

Улс орнуудын цахим худалдааны нэвтрүүлэлтийн түвшинг авч үзвэл Их Британи улс 84%-аар тэргүүлж байна. Нэвтрүүлэлтийн түвшин өндөр байгаа эдгээр улс орнууд нь мөн дэлхийн зах зээлд цахим худалдааны борлуулалтаараа дээгүүр эрэмбэлэгдэж байгаа улсууд юм.


График 1. Улс орнуудын цахим худалдаа нэвтрүүлэлтийн түвшин (2020 он)



Эх сурвалж: (www.statista.com)

2019 оны байдлаар Өмнөд Солонгос улс нэг хүний цахим худалдан авалтын зарцуулалтын дүнгээр тэргүүлж байгаа нь дэлхийн дундажтай харьцуулахад бараг 3 дахин өндөр байна. Манай хоёр хөрш болох БНХАУ дэлхийд 8-р байранд эрэмбэлэгдсэн буюу нэг хүний дундаж зарцуулалт нь 1,021 ам.доллар, харин ОХУ-ын хувьд 190 ам.долларын зарцуулалттай буюу дэлхийн дунджаас 2.6 дахин бага байна. (График 2)


График 2. Улс орон бүрийн цахим худалдаанд зарцуулж буй нэг хүний дундаж зарцуулалт



Эх сурвалж: (Digital 2020: Global digital yearbook )

Covid-19 цар тахлын өмнөх үе, оргил үе, одоогийн жижиглэнгийн худалдаанд эзлэх цахим худалдааны хувийг харьцуулан харвал оргил үедээ ойролцоогоор 50%-ийн өсөлттэй байна. Одоогийн цахим худалдааны хувь хэмжээ нь цар тахлын өмнөх үетэй харьцуулбал бүх улс оронд өссөн болохыг дараах графикаас харж болно. Үүнээс дүгнэвэл Covid-19 цар тахал нь цахим худалдааны хөгжилд эерэгээр нөлөөлсөн байна. (График 3)

График 3. Дэлхийн жижиглэнгийн худалдаанд эзлэх цахим худалдааны хувь




Эх сурвалж: (www.statista.com)

Дэлхийн цахим худалдааны зах зээлийн гол оролцогчдыг эрэмбэлвэл, 2020 оны байдлаар БНХАУ 2,296.95 тэрбум ам.доллар, АНУ 794.5 тэрбум ам.долларын борлуулалтаар тэргүүлсэн бол Их Британи 180.39 тэрбум ам.доллар, Япон 141.26 тэрбум ам.доллар, Өмнөд Солонгос улс 110.6 тэрбум ам.долларын борлуулалтаар топ-5 ангилалд багтаж байна. Энэхүү жагсаалтыг 2018 оны үр дүнтэй харьцуулбал эхний дөрвөн байранд өөрчлөлт ороогүй ба 5-р байранд эрэмбэлэгдэж байсан ХБНГУ нэг байраар хойшлон оронд нь Өмнөд Солонгос улс жагссан байна.

2021 оны хувьд энэхүү эрэмбэ хэвээр хадгалагдах төлөвтэй байгаа ба цахим худалдааны зах зээлийн өсөлт цаашид үргэлжлэх хандлагатай байна. (График 4)

График 4. Дэлхийд жижиглэнгийн цахим худалдаагаар тэргүүлэгч орнууд (2020-2021он)



Эх сурвалж: (www.statista.com)

Дэлхийн хамгийн том цахим худалдааны зах зээл болох БНХАУ-ын гаалийн байгууллага нь В2С төрлийн гүйлгээний статистик мэдээллийг гаргаж авахын тулд Хил дамнасан цахим худалдааны мэдээллийн системийг (CBEIS)<sup>20</sup> байгуулжээ. Энэ нь барааны гүйлгээ, логистик, төлбөр тооцооны гинжин хэлхээг хянах өндөр чанартай өгөгдлийн систем бөгөөд мэдээллийг төвөггүй боловсруулж тайлагнадаг байна. Мөн гаалийн байгууллага нь гадаад, дотоодын цахим худалдааны платформуудаас мэдээлэл хүлээн авч, нийт хил дамнасан цахим худалдааны статистик тооцооллыг хийхдээ ашигладаг. Түүнчлэн тооцооллын үнэн зөв байдлыг сайжруулахын тулд төрийн бусад байгууллагуудаас гаргадаг хил дамнасан логистик, төлбөрийн тайлан мэдээг big data аргачлалаар нэгтгэж, тоо өгөгдлийг харьцуулан хянадаг байна. (IMF, 2019)

### 3.2 Олон улсын татварын өнөөгийн байдал

Улс орон болгон татварын бодлоготой байдаг. Татварын бодлогоороо дамжуулан аливаа салбарын хөгжлийг хурдасгах, эсвэл удаашруулах, аль эсвэл хүн амын тоог ихэсгэх гэх мэт маш олон төрлийн зүйлийг зохицуулдаг.

Дэлхийд татварын хоёр төрлийн тогтолцоо байдаг. Үүнд:

- **Тухайн улсад олсон орлогоосоо татвар төлөх:** Оршин суугч бус татвар төлөгчийн тухайн улсад /улсаас/ олсон орлогод ногдох татварын асуудал үүсдэг.
- **Дэлхийг хамарсан орлогоосоо тухайн улсад татвар төлөх:** Оршин суугч татвар төлөгчийн гадаад улсад олсон орлогод ногдох татварын асуудал үүсдэг.

Дэлхийн татварын тогтолцоонд оршин суугч хувь хүн, хуулийн этгээд орлогоо хаанаас олж байгаагаас үл хамааран дэлхий нийтийг хамарсан орлогоосоо татвар төлдөг бол нутаг дэвсгэрийн татварын тогтолцоо нь татвар төлөгчийн оршин суугаа газраас үл хамааран зөвхөн өөрийн хил хязгаарын дотор олсон орлогоосоо татвар ногдуулна. Өөрөөр хэлбэл, дэлхийн татварын тогтолцоо нь оршин суугаа газар ба хувь хүн, хуулийн этгээдийн харьяаллыг татвар ногдуулалтын холбогч хэрэгсэл болгодог бол нутаг дэвсгэрийн тогтолцоо нь орлогын эх үүсвэрийг татвар

<sup>20</sup> Cross-border E-commerce Information System

ногдуулалтын холбогч хэрэгсэл болгодог. Дээрх 2 системийн алийг нь дагаж мөрддөгөөс хамааран татварын давхардал үүсдэг. Энэ нь хууль зүйн давхар татвар үүсэх нэг шалтгаан болдог.

Дэлхийн ихэнхи улс орнууд нь оршин суугчийн системтэй байдаг ба энэ нь татварын орлогоо хамгаалж байгааг илэрхийлнэ.

Хил дамнасан бараа ажил үйлчилгээ, хөрөнгөнд ногдуулж байгаа татваруудыг олон улсын татвар гэнэ. Олон улсын татварыг ногдуулах “Олон улсын татварын хууль” гэж байдаггүй. Харин байнга байрладаг улсын татварын хууль болон орлого олж, үйл ажиллагаа явуулсан гадаад улсын татварын хуулиудын дагуу олон улсад хамаарах орлогод татвар ногдуулдаг. Хэрэв тухайн 2 улсын засгийн газар хооронд байгуулсан “Давхар татварын гэрээ” /ДТГ/ байвал дээрх 2 улсын татварын хуулиудын үйлчлэх эрх зүйг зааглан тогтоож өгдөг. Өөрөөр хэлбэл татварын давхардлыг үүсгэхгүй байхаар, эсвэл хөнгөлөх талаар энэхүү гэрээнд тусгагдсан байдаг. ДТГ нь хил дамнасан ажил гүйлгээнд мөрдөгдөх ба хоёр болон түүнээс дээш тооны улс орнуудын татварын хууль тогтоомжийн зохицуулалтын харилцан үйлчлэл юм. Улс орнууд бусад улстай байгуулсан гэрээний дагуу төлөх татварыг тооцоолох, татварын давхардлыг бууруулахын тулд хөнгөлөлт, чөлөөлөлт, хасалтын аргыг өөрийн орны онцлогт тохируулан ашигладаг байна.

### **3.3 Зарим улс орны цахим худалдааны татварын өнөөгийн байдал**

Бизнесийн өгөгдлийн платформ [www.statista.com](http://www.statista.com)-д байршуулснаар 2020 оны байдлаар дэлхийд жижиглэнгийн цахим худалдаагаараа БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Өмнөд Солонго, ХБНГУ, Франц, Энэтхэг, Канад, Испани улсууд тэргүүлж байна. Үүнээс зарим улсын цахим худалдаанд татвар ногдуулахтай холбоотой хууль эрхзүйн зохицуулалт болон онцлогийг авч үзлээ.

#### **БНХАУ**

БНХАУ нь цахим худалдааны хуулийг 2019 оны 01-р сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлсэн ба 6 бүлэг 88 зүйлтэй. Уг хуулийн дагуу интернет зэрэг мэдээллийн технологийн сүлжээгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн борлуулах үйлчилгээ үзүүлэх бүхий л бизнесийн үйл ажиллагааг цахим худалдаа гэж тодорхойлдог. 2016 оны 4-р сарын 08-нд Хятад улсын засгийн газраас цахим худалдаатай холбоотой журам гаргасан ба уг журмын дагуу хэрэглэгч бараа бүтээгдэхүүн импортлосон бол импортын татвар, импортын НӨАТ, шаардлагатай бол хэрэглээний татвар (онцгой албан татвар, гаалийн албан татвар)-ыг төлөх ёстой гэж заасан.

Хятад хэрэглэгчид дараах дөрвөн сувгаар гадаадын бүтээгдэхүүнийг авах боломжтой байдаг.

- a) Гадаадын цахим худалдааны сайтаас шууд захиалга хийх.(Amazon, Macys, Rakuten)-haitao
- b) Агентаар дамжуулан захиалга хийх. -daigou
- c) Гадаадын брендийг дотоодын хил дамнасан цахим худалдааны платформоор дамжуулж хятад хэрэглэгчдэд шууд борлуулдаг худалдаачид. (Taobao, JD Worldwide, XiaoHongShu)
- d) Ердийн худалдаа (b2b)

Эхний хоёр сувгаар БНХАУ-ын байнга оршин суугч зөвхөн хувийн хэрэглээндээ зориулж худалдан авалт хийсэн тохиолдолд шуудангийн татвар буюу Parcel Tax (Import Tax) -ыг 15%, 25%, 50% гэсэн гурван хувь хэмжээгээр төлдөг. Хэрэв импортоор авсан барааны үнэ нь 50 юаниас бага бол энэхүү татвараас чөлөөлөгддөг. Татварыг тооцох суурь нь барааны жижиглэнгийн үнэн дээр тээврийн зардал болон цахим худалдааны үйлчилгээ үзүүлэгчээс авч буй даатгалын хураамжийг нэмсэн дүн дээр үндэслэн тооцогдоно.

Хэрэв гадаадын компани Хятад улсад салбар охин компани байгуулбал импортлосон

бараандаа импортын албан татвар төлөх ба борлуулсан бараанд ногдох НӨАТ, худалдаанаас бий болсон ашигтаа ААНОАТ-ыг төлөх үүрэгтэй. Хятад дахь охин компани нь бараа худалдан авч байгаа тохиолдолд үүн дээр үнэ шилжилтийн асуудлыг авч үзэх шаардлагатай болно. Хэрэв Хятад улсын компани нь гадаад улсад өөрийн салбар, охин компаниа байгуулсан тохиолдолд цахим худалдааны тухай хуулиар зохицуулагдах бөгөөд мөн энэ асуудал нь тухайн улстай байгуулсан давхар татварын гэрээгээр зохицуулагдана.

## **АНУ**

АНУ-ын хувьд муж болон хотуудаасаа хамаараад цахим худалдаанд өөр өөр хувь хэмжээгээр татвар ногдуулдаг. Тухайлбал, борлуулалтын татвар (sales tax)-ыг АНУ-ын нийт 45 муж болон нийслэл Вашингтон хотод ногдуулдаг байна. АНУ-д улсын борлуулалтын татварын хууль гэж байдаггүй. Хэрвээ та онлайн аар ямар нэгэн бараа зардаг бол муж бүр цахим худалдааны татвар ногдуулах өөрийн дүрэм, журамтай байдаг тул өөр өөр мужуудад зориулсан өөр өөр дүрмийг дагаж мөрдөх ёстой юм. Борлуулалтын татвар ногдуулж байгаа мужуудын ихэнх нь борлуулалтын орлого 100,000\$ ба 200 ажил гүйлгээнээс доогуур байвал уг татвараас чөлөөлдөг байна. Оклахама, Пенсилвани мужуудын хувьд уг босго нь 10,000 ам.доллар байдаг байна.

## **Их Британи**

Их Британид уламжлалт жижиглэнгийн худалдааг дэмжихийн тулд цахим худалдааны борлуулагч болон зах зээлд 2%-ийн онлайн борлуулалтын татвар ногдуулахаар төлөвлөж байна. Тус улс нь онлайн худалдаачин, шууд хэрэглэгчдэд хүргэх бизнес загвар (d2c), онлайн зах зээлд зориулсан нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын бүртгэл, тайлагналын суурь өөрчлөлтүүдийг хийсэн ба эдгээр өөрчлөлтүүд нь 2021 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Гадаадаас импортолсон 135 фунт стерлингээс өндөр үнэ бүхий бүх бараанд 0%, 5%, 20%-ийн НӨАТ-ыг ногдуулдаг. Уг улсын татварын бодлогын дагуу байнгын оршин суугчийн хувьд дэлхийг хамарсан орлогоос, байнга оршин суугч бус татвар төлөгчийн хувьд тус улсын нутаг дэвсгэрт бий болсон орлогоос татвар төлөхөөр заасан байдаг. Уламжлалт худалдаа эсвэл онлайн худалдаа эсэхээс үл хамаараад жилийн 85,000 фунт стерлингийн борлуулалтын орлоготой бол борлуулалтандаа НӨАТ суутган, тайлагнаж төлөх ёстой. НӨАТ-ын хувь хэмжээ нь ихэнхи бараа үйлчилгээнд 20% байдаг.

## **БНСУ**

Цахим худалдаа нь БНСУ-ын нийт хэрэглээний зах зээлийн гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд айл өрхүүдийн бараг 99.5% нь компьютер, гар утас эсвэл бусад төхөөрөмжөөс интернетэд холбогддог байна. БНСУ-ын цахим худалдааны онцлог нь дотоодын нийт худалдан авалтанд эзлэх хувь нь өндөр байдаг ба 2019 онд 116.0 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 136.5 тэрбум ам.долларт хүрчээ. Солонгосчууд хилийн чандаас бараа үйлчилгээг хямд үнээр авах хандлагатай байдаг тул хил дамнасан цахим худалдаа нэмэгдсээр байна. 2020 оны байдлаар хил дамнасан цахим худалдаа нь олон улсын тээврийн хураамж, импортын татварыг нэмсний дараа 3.5 тэрбум ам.доллар хүрсэн байна. БНСУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээрийн дагуу 200 ам.доллараас доош үнэтэй бараа бүтээгдэхүүнийг АНУ-аас худалдан авсан тохиолдолд уг бараа татвараас чөлөөлөгддөг байна. Мөн АНУ-д үйлдвэрлэсэн 1,000 ам.долларын үнэтэй барааг чөлөөт худалдааны хэлэлцээрээр чөлөөлнө.

Дэлхийн улс орнуудын цахим худалдааны зах зээлийн харилцааг зохицуулж буй хууль

эрхзүйн дараах нийтлэг зохицуулалт, стандарт байдаг:

- Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц
- Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн конвенц
- Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай Гаагийн конвенц
- Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенц
- Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц
- Цахим худалдааны загвар хууль

### 3.4 МУ-ын цахим худалдаа ба татварын өнөөгийн байдал

Монгол Улсын интернет хэрэглэгчдийн тоо 2019 оны байдлаар давхардсан тоогоор 5.5 сая байгаа нь 2014 онтой харьцуулахад 2.9 дахин өссөн үзүүлэлт болж байна. 2014 онд 3G сүлжээ, 2016 онд LTE сүлжээ нэвтэрснээр интернет хэрэглэгчдийн тоо огцом өсөх шалтгаан болжээ. (Ц.Цэрэндаваа, 2020) 2019 оны 6-р сарын байдлаар Монгол улсын нийт хүн амын 2.6 сая нь интернетэд холбогдсон, 2 сая нь ухаалаг утас хэрэглэдэг, 1.3 сая нь өдөр тутамдаа Facebook, Twitter зэрэг социал медиа ашиглаж байсан байна. ([www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn))

Монгол дахь цахим худалдааны хөгжил:

- 2006 он – Анхны онлайн цэцгийн дэлгүүр нээгдсэн
- 2007 он – [toybox.mn](http://toybox.mn) Хүүхдийн тоглоомын анхны онлайн дэлгүүр нээгдэв
- 2010 он – Онлайн захиалгатай хоол хүргэлтийн ресторан бий болсон
- 2011 он – Мобиком компани CANDY цахим мөнгийг зах зээлд нэвтрүүлсэн
- 2013 он – Songo delivery хоол, хүнс зэрэг өргөн хэрэглээний барааны онлайн хүргэлтийн үйлчилгээ нэвтэрсэн
- 2016 он – Анхны фин-технологийн LEND.MN нээлтээ хийсэн
- 2018 он – Блокчэйн суурилсан анхны крипто валют арилжааны платформ [ubex.mn](http://ubex.mn) бий болсон.

Монгол банкны 2020 оны 5-6 дугаар сард хийсэн судалгаагаар цахим худалдааны зах зээлийн нийт орлого өнгөрсөн жилийнхээс 60 гаруй хувиар өссөн байна. (Монгол банк, 2020) “Analysis of E-Commerce Adoption in Mongolia” өгүүллийн судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын худалдан авалтын 95% нь хувийн хэрэгцээнд зориулан авсан бүтээгдэхүүн байсан бол 5% нь дамжуулан борлуулах зорилгоор авсан байна. (Urandelger.G, Burmaa.S, Avirmed.D, 2021) Үүнээс харахад манай улсад бизнесээс хэрэглэгч рүү (b2c) цахим худалдааны бизнесийн загвар давамгайлж, цөөн хувийг бизнесээс бизнес рүү (b2b) загвар эзлэж байна.

Монгол улсад хил дамнасан цахим худалдаа Amazon, eBay, Alibaba болон бусад гадны платформуудаар дамжуулан бизнесээс хэрэглэгч рүү (b2c), бизнесээс бизнес рүү (b2b), хэрэглэгчээс хэрэглэгч (c2c) хоорондын онлайн худалдаа нэмэгдэж байгаа боловч тоон үзүүлэлтүүдийг тодорхойлох боломжгүй байна. (International Trade Administration, 2019) Энэ нь манай орны статистикийн нэгдсэн мэдээлэл, өгөгдөл хангалтгүй, холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдаа хангалттай сайн байдаггүйтэй холбоотой байж болох юм.

Б.Амарсанаагийн “Mongolia on e-commerce” илтгэлд дурдсанаар цахим худалдааны өнөөгийн байдалд дараах сорилтууд тулгарч байна. Үүнд: (Amarsanaa.B, 2019)

- ✓ Цахим худалдааны орчинг зохицуулах үндэсний хэмжээний хууль, тогтоомж, зохицуулалт дутмаг
- ✓ Газарзүйн байршил, салбарын болон дэд салбарын онцлог
- ✓ Худалдан авагчдын хүсэл сонирхолд нийцсэн худалдан авалтын олон төрлийн сонголт, зохиогчийн эрх, хуурамч бүтээгдэхүүнтэй холбоотой зохицуулалт муу
- ✓ Шуудангийн систем, хүргэлтийн системийн хөгжил муу
- ✓ Гадаад гүйлгээ, мөнгөн гуйвуулгад ногдуулдаг шимтгэл, хүлээлгийн хугацаа, банкны картын талаарх мэдээлэл болон хил дамнасан татварын хэлбэрүүд, хувь хэмжээ, суурийн талаар мэдээлэл дутмаг байна.

Цахим худалдааны эрхзүйн зохицуулалт:

Цахим худалдааны үйл ажиллагаанд олон талын эрхзүйн зохицуулалт шаардлагатай байдаг. Тухайлбал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, маркетинг, зар сурталчилгаа, шударга өрсөлдөөний асуудал, оюуны өмчийн асуудал, татвар төлөлт, хувь хүн болоод цахим худалдаанд оролцогчдын хувийн мэдээллийн нууцлал, хамгаалалт, цахим гарын үсэг гэх олон асуудал байдаг. Манай улсад цахим худалдааны эрхзүйн зохицуулалт боловсронгуй болоогүйн дээр хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэн яаж шийдвэрлэх эрхзүйн орчин одоогоор хангалттай бүрдээгүй байна.

Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн зохицуулалтын дараах баримт бичгүүд хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хэдий ч эдгээр нь уг шинэ зах зээлийн харилцааг зохицуулах хэрэгсэл болж чадахгүй байна:

- Иргэний хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль

Цахим худалдааны татварын асуудал:

Манай улсын цахим худалдааны зах зээлийн дийлэнх хэсгийг бизнесээс хэрэглэгч рүү (b2c) буюу гадаадын цахим худалдааны платформуос иргэд хувийн хэрэгцээндээ зориулан худалдан авалт хийх хэлбэр давамгайл байна. Энэ нөхцөлд хувь хүн эсвэл хуулийн этгээд байхаас үл хамааран гадаадаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээндээ холбогдох татварыг төлөх ёстой. Гэхдээ НӨАТ-ын тухай хуулийн 13.1.24-т зааснаар “нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, зөөврийн компьютерийн хувьд 30 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж”-ийг НӨАТ-аас чөлөөлнө. Хэрэв энэ хязгаараас хэтэрсэн бол хувь хүн импортлосон бараа, ажил үйлчилгээгээ ГЕГ-т мэдүүлж холбогдох татварыг төлөх үүрэгтэй. Гэвч манай улсад энэ үйл ажиллагаанд тавигдах хяналт сул байгаагаас татварын бүрдүүлэлт болон далд эдийн засгийг илчлэх боломжгүй байна. Үүний үндсэн шалтгаан нь хил дамнасан худалдан авалтын үед хоёр улсад давхар татвар төлөх асуудал юм.

Манай улсын хувьд уг асуудлыг зохицуулах энгийн хөнгөлөлтийн аргыг ашигладаг. Энэ арга нь нөгөө улсад төлсөн татварыг Монгол улсад төлөх татвараас хасч тооцох бөгөөд ингэхдээ хөнгөлөлтийн хэмжээ нь манай улсын холбогдох татварын хувь хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой. Монгол улс дэлхийн нийт 35 улстай давхар татварын гэрээ байгуулснаас одоогоор 26 нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна. (Зураг2)

*Зураг 2. Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа давхар татварын гэрээтэй орнууд*

| Д/Д | Улсын нэрс                                  | Үзэглэсэн  | Гарын үсэг зурсан | Үйлчилж байгаа |
|-----|---|------------|-------------------|----------------|
| 1   | Бүгд Найрамдах Хятад Ард Улс                | 1991.07.29 | 1991.08.26        | 1993.01.01     |
| 2   | Бүгд Найрамдах Солонгос Улс                 | 1992.02.27 | 1992.04.17        | 1992.01.01     |
| 3   | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс          | 1992.05.18 | 1994.08.22        | 1997.01.01     |
| 4   | Бүгд Найрамдах Энэтхэг Улс                  | 1994.12.24 | 1994.02.22        | 1994.01.01     |
| 5   | Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс        | 1996.02.29 | 1996.05.09        | 1997.01.01     |
| 6   | Оросын Холбооны Улс                         | 1993.05.25 | 1995.04.05        | 1998.01.01     |
| 7   | Бүгд Найрамдах Турк Улс                     | 1993.06.26 | 1995.09.12        | 1997.01.01     |
| 8   | Бүгд Найрамдах Франц Улс                    | 1994.01.31 | 1996.03.18        | 1999.01.01     |
| 9   | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс | 1994.05.13 | 1996.03.23        | 1997.01.01     |
| 10  | Бүгд Найрамдах Чех Улс                      | 1996.07.10 | 1997.02.27        | 1999.01.01     |
| 11  | Бүгд Найрамдах Унгар Улс                    | 1994.05.20 | 1994.09.13        | 1997.01.01     |
| 12  | Евельгийн Вант Улс                          | 1994.07.01 | 1995.09.26        | 1999.01.01     |
| 13  | Бүгд Найрамдах Польш Улс                    | 1995.02.02 | 1997.04.18        | 2002.01.01     |
| 14  | Малайз Улс                                  | 1995.07.23 | 1995.07.27        | 1997.01.01     |
| 15  | Бүгд Найрамдах Казахстан Улс                | 1995.09.22 | 1998.03.16        | 2000.01.01     |
| 16  | Бүгд Найрамдах Индонез Улс                  | 1995.10.21 | 1996.07.02        | 1998.01.01     |
| 17  | Бүгд Найрамдах Болгар Улс                   | 1996.11.25 | 2000.02.28        | 2002.01.01     |
| 18  | Украин Улс                                  | 1997.03.26 | 2002.07.01        | 2003.01.01     |
| 19  | Швейцарийн Холбооны Улс                     | 1998.06.24 | 1999.09.20        | 2002.01.01     |
| 20  | Бүгд Найрамдах Беларусь Улс                 | 1998.04.23 | 2001.05.28        | 2002.01.01     |
| 21  | Бүгд Найрамдах Киргиз Улс                   | 1999.06.20 | 1999.12.04        | 2000.01.01     |
| 22  | Канад Улс                                   | 2000.04.07 | 2002.05.27        | 2003.01.01     |
| 23  | Сингапур Улс                                | 2001.08.16 | 2002.10.10        | 2005.01.01     |
| 24  | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс   | 2002.10.03 | 2004.05.03        | 2005.01.01     |
| 25  | Австри Улс                                  | 2003.07.03 | 2004.10.01        | 2005.01.01     |
| 26  | Бүгд Найрамдах Итали Улс                    | 2001.06.18 | 2003.07.15        | 2004.01.01     |

Эх сурвалж: (www.mta.mn)

Дотоодын цахим худалдааны b2b, b2c хэлбэрүүдийн хувьд татварын асуудал харьцангуй бага байх боломжтой. Учир нь эдгээр хэлбэрүүд аж ахуй нэгж байгууллагатай холбоотой ба тэдгээрийн борлуулалтанд нь үндэслэн татвар ногдуулдаг тул борлуулалтаар нь дамжуулан далд хэсгийг нь ил болгох боломжтой. Үүний тулд төлбөрийн баримт буюу и-баримтын хэрэглээг сайжруулах, татварын алба хяналт сайн тавьж ажиллах шаардлагатай. Борлуулалтыг ил болгосноор гадаад ба дотоодын худалдан авалт ч үнэн зөв болох ач холбогдолтой юм. Харин c2c бизнесийн загвар нь хяналтаас гадуур байна. Энэ төрлийн бизнесийн хэлбэрт фэйсбүүк, инстаграм зэрэг социал платформ ашиглан хэрэглэгчээс хэрэглэгчид бараа ажил үйлчилгээ борлуулах үйл ажиллагаа хамаарна. Манай улсад энэ төрлийн бизнесийн загвар ихээхэн дэлгэрсэн боловч татвар ногдуулах асуудал тэр чигээрээ орхигдсон. Энэ нь цахим худалдааны үйл ажиллагаа болон татварын асуудлыг зохицуулсан хууль эрхзүйн орчин, баримт бичиг дутмаг байгаатай шууд холбоотой.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

- Цахим худалдаа нь дижитал эдийн засгийн бизнесийн шинэ загвар юм.
- Covid-19 цар тахал нь цахим худалдааны хөгжилд эерэгээр нөлөөлсөн байна.
- 2020 оны байдлаар дэлхийд жижиглэнгийн цахим худалдаагаараа БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Өмнөд Солонго, ХБНГУ, Франц, Энэтхэг, Канад, Испани улсууд тэргүүлж байна.
- Манай улсад бизнесээс хэрэглэгч рүү (b2c) цахим худалдааны бизнесийн загвар давамгайлж, цөөн хувийг бизнесээс бизнес рүү (b2b) загвар эзлэж байна.
- Цахим худалдааны үйл ажиллагаанд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, маркетинг, зар сурталчилгаа, шударга өрсөлдөөний асуудал, оюуны өмчийн асуудал, татвар төлөлт, хувь хүн болоод цахим худалдаанд оролцогчдын хувийн мэдээллийн нууцлал, хамгаалалт, цахим гарын үсэг гэх олон асуудал байдаг.

- Манай улсад цахим худалдааны эрхзүйн зохицуулалт боловсронгуй болоогүйн дээр хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэн яаж шийдвэрлэх эрхзүйн орчин одоогоор хангалттай бүрдээгүй байна.
- XXI зууны бизнес нь өнгөрсөн үеийн бизнесээс ялгагдах ялгаа нь биет бус хөрөнгө, түүний хөдөлгөөн нь биет буюу бодит зүйлсийн ажил гүйлгээнээс илүү орлого бий болгож байгаа бөгөөд уг орлого нь ямар этгээдэд харьяалагдаж байгааг тодорхойлоход төвөгтэй байдаг учир татвараас зайлсхийх хэрэгсэл болж байна.
- Улс орнууд бусад улстай байгуулсан гэрээний дагуу төлөх татварыг тооцоолох, татварын давхардлыг бууруулахын тулд хөнгөлөлт, чөлөөлөлт, хасалтын аргуудаас өөрийн орны онцлогт тохируулан ашигладаг байна. Манай улсын хувьд уг асуудлыг зохицуулах энгийн хөнгөлөлтийн аргыг ашигладаг.
- Монгол улс дэлхийн нийт 35 улстай давхар татварын гэрээ байгуулснаас одоогоор 26 нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна.
- Манай улсад с2с бизнесийн загвар ихээхэн дэлгэрсэн боловч татвар ногдуулах асуудал тэр чигээрээ орхигдсон.
- Цахим худалдааны зах зээлийн хууль эрхзүйн таатай орчинг бүрдүүлэх, цахим худалдаатай холбоотой татварын тусгайлсан хууль боловсруулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах хэрэгцээтэй байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- (2021). Shiprocket: <https://www.shiprocket.in/>-ээс Гаргасан
- (2021). [www.statista.com](http://www.statista.com).-ээс Гаргасан
- (2021). The future of cusmomer engagement and experience: <https://www.the-future-of-commerce.com/>-ээс Гаргасан
- Addressing the Tax Challenges of the Digital Economy, ACTION1. (2015).
- Amarsanaa.B. (2019). MONGOLIA ON E-COMMERCE.
- Deloitte. (2020). What is the digital economy?
- eMarketer. (2019). *Global Ecommerce* .
- IMF. (2019). *How to move forward on measuring digital trade. 32th meeting of the IMF committee on BOP statistics. Thimphu.*
- International Trade Administration. (2019). Privacy Shield Framework: [https://www.privacyshield.gov/article?id=Mongolia-ECommerce&fbclid=IwAR2BeMAkDBrK1p1YpH1QtFQEUSLTSo3EJAPXwX\\_QUYicWBxv-unWzN2GNwk](https://www.privacyshield.gov/article?id=Mongolia-ECommerce&fbclid=IwAR2BeMAkDBrK1p1YpH1QtFQEUSLTSo3EJAPXwX_QUYicWBxv-unWzN2GNwk)-ээс Гаргасан
- OECD. (2015). Addressing the Tax Challenges of the Digital Economy.
- Urandelger.G, Burmaa.S, Avirmed.D. (2021). Analysis of E-Commerce Adoption in Ulaanbaatar, Mongolia. *Journal of International Trade & Commerce* , 67-80.
- We are Social Ltd. (2020). *Digital 2020: Global digital yearbook* .
- World Bank Group. (2021). Tax Theory Applied to the Digital Economy. 23.
- [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn). (2019). *Харилцаа холбооны зохицуулах хороо*. [www.crc.gov.mn](http://www.crc.gov.mn).-ээс Гаргасан
- Г.Алтанзаяа. (2020). *Татвар*. Улаанбаатар.
- Монгол банк. (2020). <https://www.mongolbank.mn/>. Монгол улсын төв банк: <https://www.mongolbank.mn/>-ээс Гаргасан
- МТА. (2021). [www.mta.mn](http://www.mta.mn). [www.mta.mn](http://www.mta.mn): [www.mta.mn](http://www.mta.mn)-ээс Гаргасан
- Ц.Цэрэндаваа. (2020). *Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ*. Улаанбаатар: Монгол банк.

## The effects of Person Job fit and Person Supervisor fit on Turnover Intention: Moderating effects of Career Satisfaction and Career Adaptability

Baterdene Munkhgerel<sup>1</sup>, WonJun Kwak<sup>2</sup>

<sup>1</sup>Ph.D student, Department of Business Administration, Soongsil University(bgerlee1027@gmail.com)

<sup>2</sup>Professor, Department of Business Administration, Soongsil University,(kwak@ssu.ac.kr)

Correspondin Author: WonJun Kim

**Abstract:** The purpose of this study is to examine the effects of person job fit and person supervisor fit on turnover intention through a mediating variable of career satisfaction. Therefore, it is important for us to know what to focus on in order to reduce turnover intention. Also, this study will examine the effects of career satisfaction and career adaptability to the turnover intention. We will conduct surveys for 200-300 employees who have been working for more than 3 months at various Korean or Mongolian companies in order to prove 9hypothesis, including 5 variables, that we raised. In order to make a regression and factor analysis, we are going to use SPSS and AMOS programs.

**Keywords:** Person Job fit, Person Supervisor fit, Turnover Intention, Career satisfaction, Career Adaptability

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажлын зорилго нь ажилтнуудын ажлаас гарах сэдэл(turnover intention)-д тухайн ажилтны ажил(person-job fit) болон удирдлага(person-supervisor fit)-тайгаа зохицож буй байдал нь хэрхэн нөлөөлж буйг судлах юм. Ингэснээр бид тухайн ажилтны ажлаасаа гарах сэдэл(turnover intention)-ийг багасгахын тулд ямар хүчин зүйлс дээр анхаарч ажиллах боломжтойг мэдэж авах ач холбогдолтой. Түүнчлэн энэхүү судалгааг хийхдээ тухайн ажилтны карьертаа хэр сэтгэл ханамж(career satisfaction)-тай байгаа болон хэр дасан зохицож(career adaptability) байгаагаас хамааран ажлаас гарах сэдэл(turnover intention)-д хэрхэн нөлөө үзүүлж байгааг нарийчлан авч үзнэ. Тус зорилгынхоо хүрээнд онол болон судалгааны ажлуудад үндэслэн нийт 5 хувьсагчтайгаар 9 таамаглал дэвшлүүлээд байна. Эдгээр таамаглалуудыг батлахын тулд анхдагч өгөгдөл цуглуулах анкетын аргыг ашиглан тухайн байгууллагадаа 3 сараас дээш ажиллаж байгаа ажилтнуудаас 200-300 хүний түүвэртэй судалгаа авахаар төлөвлөж байна. Өгөдлийн шилжилгээг хийхдээ SPSS болон AMOS зэрэг програмуудыг ашиглан регрессийн болон фактор шинжилгээнүүдийг хийнэ.

**Түлхүүр үг:** Хувь хүн ажлын зохицол, хувь хүн удирдлагын зохицол, ажлаас гарах сэдэл, карьерийн сэтгэл ханамж, карьерийн дасан зохицол

## 1. 서론

개인-환경 적합성 이론에서는 조직구성원 개인의 속성과 환경의 속성 간 상호작용에 의해 구성원들이 속해 있는 환경과의 적합성을 예측할 수 있으며, 이러한 적합성에 의해 조직몰입, 이직의도 및 직무만족, 성과 등이 나타난다고 주장하고 있다 (Karen & Guido, 2007). 이러한 개인-환경 적합성에 관련된 선행연구에서 개인-조직 적합성 및 개인-직무 적합성이 조직 수준의 태도변수(조직몰입, 조직시민행동, 이직의도 등)와 개인 수준의 태도변수(직무만족 등)에 차별적으로 영향을 미친다고 보고되고 있으며, 특히 개인-조직 적합성은 조직 수준의 태도변수에, 개인-직무 적합성은 개인 수준의 태도변수에 더 큰 영향을 미친다고 보고되고 있다(강영순, 2012; 최명옥, 유태용, 2005; Kristof-Brown, Jansen, & Colbert, 2002; Kristof-Brown, Zimmerman, & Johnson, 2005). 따라서 개인-직무 적합성과 개인-상사 적합성은 직무만족 및 이직의도에 영향을 미치는 것을 볼 수 있다.

또한 (Schneider et al., 1995)는 직무 환경에 적합하지 않은 구성원은 조직을 떠날 가능성이 높다고 밝혔다. 직업적응이론(The Theory of Work Adjustment -TWA; Dawis and Lofquist, 1984)은 개인-환경 적합성과 이직 간의 연관성을 이해하는 데 유용한 프레임워크로 제시되었다. 즉, 이러한 직업적응이론은 구성원과 직무-환경 간의 지속적인 상호작용 프로세스를 설명하여, 구성원과 조직이 상호작용을 하고 서로의 요구 사항을 충족하도록 제안한다. 따라서 직업적응 과정의 성공은 구성원의 만족도(즉, 개인이 직무 요구를 충족할 수 있는 정도)와 직무에 대한 만족도에 반영되며, 구성원이 조직에 남을 가능성에 영향을 미칠 것으로 예상되었다(e.g. Dahling and Librizzi, 2015; Hesketh, 1993). 이상의 정의와 논의들을 요약하면, 적합성이 올라가면 만족을 하게 될 것이고 회사를 떠나고자 하는 의도가 낮아질 것이다. 다시 말해 개인 환경 적합성에 관련 변수들이 만족에 영향을 주고 이후에 이직의도에 영향을 주게 되는 것이다.

따라서 본 연구에서는 은행, 공공기관, 호텔, 병원 및 일반기업을 대상으로 한 선행연구를 바탕으로 표본 집단을 일반기업으로 선정하여 일반기업 구성원이 지각하는 개인-환경적합성이 경력만족 및 이직의도에 미치는 영향과 이들 관계 속에서 경력적응성의 조절 역할에 대해 분석을 하고자 한다. 즉, 적합성의 향상을 통해 이직의도를 감소시키기 위해 구성원과 가장 밀접하게 있는 개인 간 인간관계나 적합성을 동시에 측정하며 적응성과에 미치는 영향을 더 설명할 예정이다.

## 2. 이론 및 가설

### 2.1 이론적 배경

#### 2.1.1 개인-직무 적합성과 개인-상사 적합성

개인-환경 적합성(Person-Environment fit) 이론은 조직 구성원과 다양한 근무환경과의 적합성을 의미하여(Schneider, 2001), 개인과 환경 두 차원의 유사성, 수요-만족, 수요-능력 등에 의해 구성된다. 또한 개인-환경 적합성은 환경의 범주에 따라 개인-조직 적합(Person-Organization fit), 개인-직업 적합(Person-Vocation fit), 개인-집단 적합(Person-Group fit), 개인-팀 적합(Person-Team fit), 개인-직무 적합(Person-Job fit), 개인-상사 적합(Person-Supervisor fit), 개인-동료 적합(Person-Coworker fit) 등으로 다양하게 구분되고 있다(Kristof-Brown et al., 2005). 본 연구에서는 개인-환경 적합성과 관련해서 개인-직무 적합성 및 개인-상사 적합성을 중심으로 연구하고자 한다.

개인-직무 적합성은 개인-환경 적합성(Person-Environment fit)의 개인 수준 하위차원의 하나이다. 개인-직무 적합성은 일반적으로 개인의 특성과 직무의 특성 간 일치 정도를 나타내지만, 그것의 구체적인 개념과 정의는 다양하다(Kristof-Brown et al., 2005). 개인-직무 적합성이란 개인이 직무에 제공할 수 있는 것과 직무가 개인에게 제공해 줄 수 있는 것들 사이의 일치 정도라고 정의된다(Caldwell and O'Reilly, 1990). 개인-직무 적합성은 개인의 지식, 기술, 능력과 담당 직무가 필요로 하는 여건 간 상호부합 정도 및 개인의 욕구와 담당직무의 속성 간 상호부합 정도 모두를 의미한다고 볼 수 있다(Caldwell & O'Reilly, 1990; Carless, 2005; Edwards, 1991; O'Reilly, Chatman, & Caldwell, 1991). 또한 Saks and Ashforth(1997)는 개인의 능력, 가치가 직무요건 및 직무특성과 일치하는 정도로, 개인의 능력이 직무요건과 일치하는지 직무특성이 개인의 가치에 부합하는지를 개인-직무 적합성으로 보았고, Edwards(1991)는 개인-직무 적합성을 개인의 능력과 직무의 요구 특성 간의 적합 또는 개인의 요구와 직무의 속성 간의 적합이라고 정의하였다. 이에 따라서 수요-능력 적합성과 욕구-공급 적합성이라는 두 가지 하위차원으로 개념화하였다. 수요-능력 적합성은 직무수행자가 보유하고 있는 지식, 기술, 능력이 그 직무에서 요구하는 것과 상응하는 정도를 의미하며, 욕구-공급 적합성은 직무에서 제공하는 것이 직무수행자의 욕구를 충족시킬 수 있는 정도를 의미한다.

개인-상사 적합성은 개인-환경 적합성의 또 다른 하위차원으로 지속 연구되고 있다. 개인-상사 적합성은 개인과 작업 환경 간의 2인 관계(dyadic relationships)에 있어서 직속상사와 부하 간의 적합성의 정도(예, Adkins, Russel, & Werbel, 1994; Van Vianen, 2000)를 나타냈으며, 특히 목표(Witt, 1998), 가치(Colbert, 2004), 성격(Schaubroeck & Lam, 2002), 전반적 특성 측면에서 적합성을 나타낸다. Bauer 와 Green(1996)은 상사와 부하의 성격 유사성이 상호 좋은 관계를 형성하는 데 도움을 준다는 것을 밝혔고, Antonioni 와 Park(2001)은 성실성 차원에서 성격이 유사한 사람들이 서로의 업무수행을 높게 평가하는 것으로 정의하였다. 또한 Witt(1998)과 Schaubroeck & Lam(2002)의 연구에서는 개인-상사 간의 가치관, 성격, 목표 등의 전반적 특성들의 적합성으로 정의하였으며, 양유진(2009)의 학위논문에서는 개인과 상사의 협업 과정에서 인지할 수 있게 되는 개인과 개인(상사) 서로의 유사성으로 정의되어 있다.

### 2.1.2 경력만족

경력(career)이란 일생을 통해 자신의 통제 또는 타인의 통제하에서 개인 및 조직 목표를 달성하기 위해 수행한 관련 작업에 대한 경험 및 활동의 연속을 일하는 것으로 정의되어 있다(Hall, 1986; 1990)[3]. 또한 (Artur, Hall, & Lawrence, 1989)는 일생에 걸쳐 지속하는 개인의 일과 관련된 경험으로 정의하였다. 즉, (Greenhaus et al., 2000)는 경력만족(career satisfaction)의 경력은 한 개인의 생애 전반에 걸친 직무 관련 경험의 일정한 패턴을 의미하였다. 다시 말하면 개인의 삶에서 업무와 관련한 직무 경험의 집합체로 정의할 수 있다. 따라서 경력만족은 개인의 직무 관련 중요한 개념의 하나이다.

조직에서 개인이 가지고 있는 자기 자신의 경력에 대한 전반적인 심리적 지향성을 의미하며 직무만족의 한 차원으로 간주하여 있다(Gattiker & Larwood, 1988). Greenhaus 외(1990)는 경력만족에 대해 자신이 쌓은 경력에 대한 심리적 동일시로 정의하였다. 즉, 경력 만족은 개인의 가치가 자신의 경력에 적용된 정도를 말하는 것으로(홍경옥, 임인환, 2014), 최재영(2004)은 개인의 직무와 관련된 연속적인 경험과 역할 및 욕구 변화에 있어서 자신 또는 다른 사람이 지각하고 있는가와 자신이 지식과 능력을 투입한 결과 얻게 되는 가치에 대한 정서적인 반응으로 정의하였다.

또한 경력만족에 대한 연구의 중요성을 살펴보면, 조직은 조직 유효성을 증대시키기 위해 조직목표 달성과 직무수행에 요구되는 기술과 능력을 기준으로 구성원을 선발하고 체계적 절차와 제도를 통해 구성원 개인의 경력관리 노력을 지원하고 있다. 또 경력만족은 개인 경력에 대한 성공 여부 뿐만 아니라 경력성과를 평가하는 중요한 요소 중 하나로서 평가되어 왔다(King, 2004). 따라서 조직과 구성원의 경쟁력을 동시에 높이기 위해서는 구성원이 다른 기회를 찾아 이탈하지 않도록 하는 전략을 위해 경력만족에 대한 연구가 필요하다고 볼 수 있다.

### 2.1.3 이직의도

대부분의 이직연구들은 많은 조직 구성원들이 조직을 떠나게 하는 요인이 무엇인지를 찾아내고, 그러한 요인들에 대해 물질적인 보상을 제공함으로써 조직 구성원들이 조직에 남게 할 수 있다는 결론을 제시해 왔다(Lee et al., 2005). 즉 March 와 Simon(1958)이 주장한 조직균형이론에 따르면 조직으로부터 자신이 원하는 보상을 충족하지 못하거나 조직 내에서 불만족을 느낄 때 이직을 생각하게 되고 다른 대안을 탐색하여 그 대안이 더 경제적이라면 이직을 하게 된다는 것이다.

이직의도에 대한 개념은 이직의 전 단계로 간주하는 직무 태도로서 조직을 떠나려는 의식적이고 고의적인 의지를 말한다(오인수 외, 2007; Tett & Meyer, 1993; Wang et al., 2017). 이직의도가 있다고 해서 이직의 행동으로 반드시 이어지는 것은 아니지만

이직의도가 실제 이직에 영향을 준다는 연구가 많다. 즉, 이직의도는 조직구성원이 현재 조직에서 직무수행을 포기하고 떠나고자 하는 의도를 의미하며(Meyer & Allen, 1984), 이직의도는 조직구성원의 자격을 버리고 자발적으로 조직을 떠나려고 하는 정도로서 영향을 미치는 독립변수로는 크게 인구 통계적 요인, 개인-직무적 요인, 조직-구조적 요인을 들 수 있다고 하였다(이만기, 2013). Allen and Meyer(1984)에 따르면, 이직의도(prospensity to move)는 종업원이 조직의 구성원이기를 포기하고 현직장을 떠나려고 의도하는 정도로 정의되어 있고, Mobley(1982)는 구성원이 현재 자신의 조직을 떠나고 싶은 의도로서 직장을 옮기고 싶다는 생각, 자신의 직업을 바꾸고 싶다는 의지 등을 의미한다고 정의하였다.

## 2.1.4 경력적응성

경력(career)은 원래 전문직 종사자에게 한정되어 사용하던 개념이었지만, 최근에는 일반인의 일생에서 직무와 관련하여 획득된 총체적인 경험으로 확대되고 있다. 즉, 경력은 경력개발(career develop), 경력관리(career management), 경력만족(career satisfaction), 경력몰입(career commitment), 경력성공(career success), 경력적응성(career adaptability) 등 다양한 개념으로 확대되며, 이들과 관련 연구들도 많아지고 있다. 따라서 본 연구에서는 경력적응성에 대한 하고자 한다.

경력적응성은 기존의 경력개발이론을 구성주의 관점에서 통합한 것(Rudolph, Lavigne, & Zacher, 2017)으로 환경과의 상호작용을 강조하는 새로운 개념으로 정의된다. 경력적응성은 예상치 못한 상황에 처했을 때 자신의 새웠던 경력 계획을 변환하고 새롭게 적응하는 능력이다(Spark et al, 2019). 변화하는 업무 환경에 대처하기 위해서 개인은 기존의 행동, 감정, 사고 등을 바꿀 수 있는 역량인 경력적응성을 갖추어야 한다고 하였다(Johnston et al, 2016). 또한 경력환경이 불확실할 때 원만하게 적응하는 역량이 경력적응성이며(Zacher, 2014), Savickas(2013)는 경력적응성을 관심(concern), 호기심(curiosity), 통제(control), 신뢰(confidence)의 네 가지 범주로 세분화하였다(Johnston, Luciano, Maggiori, Ruch, & Rossier, 2013). 이는 경력적응성이 높다면, 미래의 경력에 대한 깊은 관심을 갖고 다양한 경력대안을 탐색하는 호기심을 나타내는 것을 의미한다.

## 2.2 가설설정

### 2.2.1 개인-직무 적합성 및 개인-상사 적합성과 이직의도

개인-직무 적합성은 개인-환경 적합성(Person-Environment fit)의 개인 수준 하위차원의 하나로서 연구자들의 많은 관심을 가지고 연구되고 있다. 이 개념은 여러 학자의 연구에서 다양하게 정의되고 있다. 이러한 연구 개념과 결과를 살펴보면, 일반적으로 개인-직무 적합성은 직무에서 필요한 요구사항을 개인이 충족시켜야 하는 측면과 개인이 필요한 욕구를 직무가 충족시켜야 하는 측면을 모두 포함한다. Edward(1991)는 이 두 가지 측면을 분류하여 수요-능력 적합성과 욕구-공급 적합성이라는 두 가지로 개념화하였다. 수요-능력 적합성은 직무수행자가 보유하고 있는 지식, 기술, 능력이 그 직무에서 요구하는 것과 상응하는 정도를 의미하며, 욕구-공급 적합성은 직무에서 제공하는 것이 직무수행자의 욕구를 충족시킬 수 있는 정도를 의미하였다. Kristof-Brown(2005)의 논문에서도 개인-직무 적합성을 2 하위차원으로 분류하고 연구하였다. 그 결과에 따르면 개인-직무 적합성이 직무만족, 조직몰입, 이직의도, 동료만족, 조직동일시, 이직 등 변수들에 영향을 미쳤으며, 욕구-공급 적합성은 수요-능력 적합성보다 이직의도에 더 강한 부정적인 영향을 미친다고 하였다. 이는 욕구-공급 적합성과 수요-능력 적합성이 높을수록 이직의도가 낮아지는 의미이다.

또한 개인-환경 적합성과 이직의도에 관련 선행연구들을 살펴보면, Lyons(1971)의 연구에서는 개인-환경 적합성이 이직의도와 강한 부정적인 영향을 미쳤으며, Vancouver et al.(1994)의 개인-상사 적합성을 중심으로 연구한 결과에 있어서도 상사와 개인 간의 목표가 일치할수록 이직의도가 낮아지는 결과를 보여주었다. Saks and Ashforth(1997)는 개인-직무 적합성은 직무만족과 정적관계를, 이직의도와는 부적관계를 갖는다고 하였으며, 반면에 Lauver and Kristof-Brown(2001)은 개인-직무 적합성이 직무만족과 이직의도에 영향을 미친다고 주장하였다. (Wilk & Sackett 1996)는 직무와 적합하지 않은 구성원들이 그 조직을 떠나고 자신에게 적합할 조직을 찾았다고 하였으며, (Iplik, Kilic, & Yalcin, 2011)는 개인조직과 개인직무 적합성이 조직몰입, 직무만족 및 성과를 증가시키면, 이직의도를 감소시킬 수 있다는 것을 입증하였다. 즉, 최근 진행된 연구들을 종합해보면 개인-직무 적합성은 개인 수준의 태도 변수(직무만족, 직업만족, 직업몰입)에 더 큰 영향을 미치고 있음을 확인할 수 있다(Kristof-Brown et al., 2002; Cable and DeRue, 2002; 최명옥, 유태용, 2005; 신유형, 2008).

Судалгааны зорилго нь 1-рт, Хэрэглэгчдийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг сонгохдоо ямар шаргуурууд тавьдаг, тэдгээрийн үндсэн хүчин зүйлс нь юу болохыг тодорхойлох 2-рт, Үндсэн болон дэд хүчин зүйлсийг харьцуулж харилцан жинг (mutual weight) шалгах. Судалгааны үр дүнгээр дамжуулан сүү, сүүн бүтээгдэхүүний чанарын бодлогод тодорхой хувь нэмэр оруулах мөн эдийн засгийн ач холбогдолтой юм.

## 2. Онолын судалгаа

### 2.1 Монголын сүүний салбарын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсад 2018 оны эцсийн байдлаар жилд 993 сая литр суурилагдсан хүчин чадал бүхий нийт 230 сүү, сүүний үйлдвэр, 72 хөргөлтийн төвтэй байв. 139 сая литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулдаг нь өмнөх оныхоос 56 орчим хувиар өсч, дотоодын үйлдвэрлэлийн 15 орчим хувийг эзэлж байна. Иймээс сүүлийн үед сүү, сүүн бүтээгдэхүүний талаархи судалгааг Монголд идэвхтэй хийж, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ихээхэн сонирхох болжээ. [Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia, 2018] Зураг №1 дээрх хөх өнгөөр Хөдөө аж ахуйн сүүний нөөц /сая литр/, улаанаар Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүн бүтээгдэхүүн /сая литр/, ногооноор Боловсруулсан сүүний хэмжээ /сая литр/-г илэрхийлнэ.

<Figure 1> The Dairy Product for the Industry



## 2.2 Сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, худалдан авалтын шалгуур үзүүлэлт

Компаниуд бүтээгдэхүүнээ бусад бүтээгдэхүүнээс ялгарах хамгийн түгээмэл арга бол дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал юм. Хэрэв бүтээгдэхүүн нь өндөр чанартай бол түүнийг худалдан авч буй хэрэглэгчид үнэтэй байсан ч худалдаж авах хандлагатай байдаг. [Kim, S. H., 2012] Чанар нь хэрэглэгчдийн сэтгэл, хэрэгцээ шаардлагад нийцэх байдлаар тодорхойлогдох ба үнэ, аюулгүй байдал, бэлэн байдал, бат бөх , найдвартай байдал зэрэг шинж чанаруудыг бүтээгдэхүүндээ агуулсан байх ёстой. Мөн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангаж буй бүтээгдэхүүний чанарыг бүтээгдэхүүний үнэ, бат бөх, найдвартай байдал зэрэг нэгтгэсэн цогц байдлаар тодорхойлох шаардлагатай байдаг. [Besterfield, D. H., 1986]

Тухайлбал, органик хувцасны чанарын үнэлгээний судалгаанд гоо зүйн, менежмент, чиг үүргийн гэсэн гурван үндсэн хүчин зүйл, 17 дэд хүчин зүйлийг санал болгон судалсан байна.[Park, H. R., 2015]. Үүнийг доорхи <Table 1> -ээс харж болно.

<Table 1> The Criteria for the Quality of the Organic Clothing

| Variables                | Operational Definition                   |
|--------------------------|--|
| The symbol of the beauty | Style and design                         |
|                          | Image of clothes                         |
|                          | Personality expression                   |
|                          | Impression to others or the opposite sex |
|                          | The latest fashion                       |
|                          | Harmony with other clothes               |
|                          | Expression of dignity or status symbol   |
|                          | Brand recognition                        |
| Management               | Laundry care                             |
|                          | Degree of stimulation to the skin        |
|                          | Exchange and repair                      |
|                          | Sweat absorption and hygiene             |
|                          | Sewing and finishing                     |
| Fuctionality             | Wearability                              |
|                          | Convenience of activity                  |
|                          | Tactility                                |
|                          | Environment and quality mark             |

Хувцас худалдан авагчдын чанарын үнэлгээний өөр нэг судалгаагаар практик байдал, удирдах чадвар, гоо зүй, бэлгэдэл гэсэн 4 үндсэн хүчин зүйл, 19 дэд хүчин зүйлийг санал болгожээ. [Kim, M.-S. and Kim, M.-S., 2003].

Судалгааны хүрээг бага зэрэг нарийвчлан, хүнсний чиглэл дэх судалгаануудаас харахад шинэлэг бүтээгдэхүүн (fresh food-хадгалалтын хугацаа бага шаардагддаг , хэрэглэгчдэд шинэ, шинэлэг байдлаар хүргэгдэх хүнсний бүтээгдэхүүн )-ийн талаархи хийгдсэн судалгаанд дизайн, бүтэц, амт, хоол тэжээл, эрүүл ахуй зэргийг сонгох хүчин үндсэн хүчин зүйл болгон оруулсан [Kader, A. A., 2004 ] байгааг доорхи <Table 2> хүснэгтээс харж болно.

<Table 2> The Criteria for the Fresh Cut Product

| Variables                    | Detailed Variables   |
|------------------------------|--|
| The value for the appearance | Size: dimensions, weight, volume   |
|                              | Shape and form: diameter/depth, ratio, compactness, uniformity   |
|                              | Color: uniformity, intensity   |
|                              | Gloss: nature of surface wax   |
|                              | Defects: can originated form pre/postharvest, morphological, physical and mechanical, physiological, pathological, entomological |
| The value for the texture    | Firmness, hardness, softness   |
|                              | Crispness  |
|                              | Succulence, juiciness  |
|                              | Mealiness, grittiness  |
|                              | Toughness, fibrousness   |
| The value for the flavor     | Sweetness  |
|                              | Sourness   |
|                              | Astringency  |
|                              | Bitterness   |
|                              | Aroma  |
|                              | Off-flavors and off-odors  |
| The value of the nutrition   | Carbohydrates  |
|                              | Proteins   |
|                              | Lipids   |
|                              | Vitamins   |
|                              | Minerals   |
|                              | Bioactive compounds  |
| The value for the hygiene    | Naturally occurring toxicants  |
|                              | Contaminants   |
|                              | Mycotoxins   |
|                              | Microbial contamination  |

Хадгалалтын хугацаа, эрүүл ахуй, чанар, үнэ зэргийг мөн хүчин зүйл гэж үзсэн [Choi, M. S, 2002] ба [Lee, M. H.,2012] -ийн Сүү, сүүн бүтээгдэхүүний талаархи судалгаанд хэрэглэгчдийн хүйс, хоол тэжээлийн боловсрол, хоол тэжээлийн мэдлэгийг харгалзан судалгааг хийсэн бол хадгалах хугацаа, үнэ, брэнд зэргийг мөн шалгуур үзүүлэлт болгон судалжээ.[Park, S. Y., 2011].

Нэмж дурдахад хэрэглэгчийн органик хүнсний сонголтыг тодорхойлох хүчин зүйлсийн судалгаа [Angowski, M.and Vujanowicz-Haras, B., 2019], жимс жимсгэнэ, хүнсний ногоо зардаг жижиглэн худалдааны дэлгүүрүүдээс хэрэглэгчдийн худалдан авалтын судалгаанд үнэ, эрүүл ахуй, бэлэн байдал зэрэг хүчин зүйлсийг АНР аргаар судалсан судалгаа[Sabir, L. B., 2016], жижиглэн худалдааны дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн сонголт хийх хүчин зүйлсийн судалгаа [ Shin, S. Y., et al 2019] зэргээс хэрэглэгчдийн чанарын хүчин зүйлсийг онолын түвшинд харж болохоор байна.

Сүүн бүтээгдэхүүний чанар, худалтан авалтын хүчин зүйлсэд сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэснээр авч болох ашиг тус, маркетинг, хэрэглэгчийн сэтгэлзүй зэргийг тодорхойлсон байдаг. [Noh, Y. H., 2000]. Мөн өөр нэгэн судалгаанд амт, найрлага, үнэ , үйлдвэрлэгч , савлагаа, реклам сурталчилгаа, үнэр, эрүүл мэнд зэрэг нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг сонгохдоо чухалчилдаг чанарын хүчин зүйлс мөн ба эдгээр нь худалдан авалтанд нөлөөлнө хэмээн үзжээ. [Lee, M. H., 2012].

Словак хэрэглэгчдийн сүү, сүүн бүтээгдэхүүний худалдан авалтанд нөлөөлдөг хүчин зүйлсийг судлахдаа 8 үндсэн хүчин зүйлс (бүтээгдэхүүн, үнэ, зах зээлийн мэдээлэл, орчин, хувийн болон сэтгэлзүйн хүчин зүйлс), 45 дэд хүчин зүйлсээр тодорхойлсон байна.[Kurajdova, K. and Taborecka-Petrovicova, J. 2015]. Үүнийг <Table 3>-аас харж болно.

| The Criteria for the Dairy Product |                     |
|------------------------------------|---------------------|
| Main Variables                     | Detailed Variables  |
| Product                            | Assortment          |
|                                    | Brand               |
|                                    | Country of Origin   |
|                                    | Fat                 |
|                                    | Freshness           |
|                                    | Nutrition           |
|                                    | Package             |
|                                    | Processing          |
|                                    | Quality             |
|                                    | Sensory Appeals     |
|                                    | Utility             |
| Price                              | Bargains            |
|                                    | Price               |
|                                    | Price Strategy      |
| Information                        | Advertisement       |
|                                    | Competition         |
|                                    | Coupons             |
|                                    | Leaflets            |
|                                    | Press Advertisement |
|                                    | Price Packages      |

|                      |                      |
|----------------------|----------------------|
|                      | Public Relations     |
|                      | Samples              |
|                      | Seller               |
|                      | Web Page             |
| Enviroment           | Arrangement          |
|                      | Cleanliness          |
|                      | Location             |
|                      | Orientation          |
| Culture              | Tradition            |
| Socio factor         | Children             |
|                      | Experts              |
|                      | Family and Relatives |
|                      | Friends              |
| Personal factor      | Age                  |
|                      | Animal Possession    |
|                      | Gender               |
|                      | Education            |
|                      | Family Status        |
|                      | Household Size       |
|                      | Number of Children   |
|                      | Income               |
| Psychological factor | Attitude             |
|                      | Learning             |
|                      | Motivation           |
|                      | Perception           |

Косовогийн сүү, цагаан идээний хэрэглэгчдийн судалгаанд хэрэглэгчийн итгэл, чанар, худалдан авах дадал зуршил, үнэ, сав баглаа боодол зэрэг нь хувьсагч байдлаар мөн судлагдсан байна.[Hysen, B., Mensur, V., Muje, G., Hajrip, M., Halim, G., Iliriana M., and Njazi, B., 2008].

### 3. Судалгааны загвар

#### 3.1 Судалгааны дизайн, хүчин зүйлсийн тодорхойлолт

Сүү, сүүн бүтээгдэхүүн чанар, сонголтын хүчин зүйлсийг гаргаж авахын тулд өмнөх онолын тойм судалгаанд үндэслэн үндсэн болон дэд хүчин зүйлсийг тодорхойлсон.

<Table 4> Operational Definition of the Main Variables

| Main Variables | Detailed Variables | Operational definition      |
|----------------|--------------------|-----------------------------|
| Product        | Ingredient         | Ingredients of the products |

|           |                 |   |
|-----------|-----------------|---|
|           | Taste           | Taste when having the products                                  |
|           | Flavor          | Flavor when having the products                                 |
|           | Origin          | Origin producing the milk and the dairy                         |
|           | Process         | The process to produce the dairy                                |
| Marketing | Advertisement   | Promote the product to the customers                            |
|           | Brand           | Brand recognition   |
|           | Packaging       | Design, size, appearance, and convenience                       |
|           | Price           | The price of the product and promotion                          |
|           | Expiration date | The date on the product can be used                             |
| Quality   | Sanitation      | Whether it is safe from all kind of disease                     |
|           | Certification   | Certified from ISO, HACCP                                       |
| Social    | Recommendation  | Decision on whether the food is safe enough to recommend others |
|           | Custom          | An old habit from the past                                      |

Хүснэгтээс харахад бүтээгдэхүүн, маркетинг, чанар, нийгмийн хүчин зүйлсийг үндсэн хүчин зүйл болгон гаргаж авсан. Дэд хүчин зүйлсийн хувьд орц, амт, үнэр, гарал үүсэл, боловсруулах аргыг бүтээгдэхүүний хүчин зүйлсэд, зар сурталчилгаа, брэнд, сав баглаа боодол, үнэ, дуусах хугацааг маркетингийн хүчин зүйлсэд, чанарын хүчин зүйлсэд эрүүл ахуй, баталгаажуулалт, нийгмийн хүчин зүйлийн хувьд зөвлөгөө зөвлөмж, зан заншил зэргээр тодорхойлов.

Хүснэгтэд үзүүлсэн хүчин зүйлс дээр үндэслэн асуулга боловсруулж, хэрэглэгчдийн ач холбогдлыг судалсан.

### 3.2 Судалгааны бүрэлдэхүүн

<Figure2> ба <Figure 3>-д үзүүлснээр, бүтээгдэхүүний чанар, сонголтын шалгуур үзүүлэлтийг багтаасан асуулга боловсруулсан.




<Figure 2> Variables

|      |                         |           |              |       |                  |         |                  |       |              |           |                         |      |   |   |   |   |   |   |
|------|-------------------------|-----------|--------------|-------|------------------|---------|------------------|-------|--------------|-----------|-------------------------|------|---|---|---|---|---|---|
| Ранк | Харьцуулсан<br>Үзүүлэлт | Маш чухал | Нилээд чухал | Чухал | Бага зэрэг чухал | Адилхан | Бага зэрэг чухал | Чухал | Нилээд чухал | Маш чухал | Харьцуулсан<br>Үзүүлэлт | Ранк |   |   |   |   |   |   |
|      |                         | ←         | ←            | ←     | ←                | →       | →                | →     | →            | →         |                         |      |   |   |   |   |   |   |
| A    | 9                       | 8         | 7            | 6     | 5                | 4       | 3                | 2     | 1            | 2         | 3                       | 4    | 5 | 6 | 7 | 8 | 9 | B |

<Figure 3> Survey Marking

Бүтээгдэхүүний хүчин зүйлсийг жишээ болгон авч үзвэл, шаталсан бүтэц, холбогдох асуултуудыг цэгцлэх замаар, бүтээгдэхүүний хүчин зүйлийн дэд хүчин зүйлсийн тайлбарыг багтаасан. Дэд хүчин зүйлсийн тодорхойлолт нь дараах байдалтай байна.

<Figure 4> Survey Marking



<Table 5> Definition of the Detailed Variables of the Product

| Detailed Variables | Definition  |
|--------------------|---|
| Ingredient         | Ingredients and nutrients of the dairy product        |
| Taste              | Sensing the dairy food in the mouth                   |
| Flavor             | The smell of the dairy food                           |
| Origin             | The origin of the milk used to make the dairy product |
| Process            | The process to produce the dairy product              |

## 4. Судалгааны үр дүн

### 4.1 Судалгааны түүвэр, хүн ам зүйн шинж

Энэхүү судалгааг явуулахын тулд 2020 оны 6 дугаар сараас эхлэн нэг сарын хугацаанд нийт 100 хүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт ажилладаг 50 мэргэжилтэн (Монголын том, жижиг 4 компанид ажиллаж байсан), 50 хэрэглэгчээс санал асуулга явуулсан. Мэргэжилтний салбарын хувьд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүдэд үйлдвэрлэл үйл ажиллагааны

менежерүүд, маркетингийн менежерүүд, үйлдвэрийн бусад мэргэжилтнүүдээс бүрдсэн байдлаар судалгааг авав. Үүнээс Consistency index-CI нь 0.1 ба түүнээс дээш гарсан 4 хүнийг эс тооцвол нийт 46 мэргэжилтний үр дүнгээр эмпирик шинжилгээ хийсэн. Хүснэгт 6-д хүн ам зүйн мэдээллийг харуулав. Харин хэрэглэгчийн салбарын төлөөлөл болох 50 хүний үр дүнгээс Consistency index-CI нь 0.1 ба түүнээс дээш гарсан 8 хүнийг хасаж 42 хэрэглэгчийн үр дүнг нэгтгэн гаргав.

<Table 6> Demographic Information

| Expert Group |       |           |
|--------------|-------|-----------|
| Gender       | Count | Ratio(%)  |
| Female       | 26    | 57        |
| Male         | 20    | 43        |
| Total        | 46    | 100       |
| Age          | Count | Ratio (%) |
| 20s          | 4     | 9         |
| 30s          | 24    | 52        |
| 40s          | 14    | 30        |
| 50s          | 4     | 9         |
| Total        | 46    | 100       |

<Table 7> Demographic Information

| Customer Group |       |           |
|----------------|-------|-----------|
| Gender         | Count | Ratio(%)  |
| Female         | 24    | 57        |
| Male           | 18    | 43        |
| Total          | 42    | 100       |
| Age            | Count | Ratio (%) |
| 20s            | 5     | 12        |
| 30s            | 9     | 22        |
| 40s            | 17    | 40        |
| 50s            | 11    | 26        |
| Total          | 42    | 100       |

#### 4.2 1-р түвшний үндсэн хүчин зүйлийн шинжилгээ

Мэргэжилтнүүдийн салбарын үндсэн хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдлыг үнэлэхэд бүтээгдэхүүний хүчин зүйл (0.469) ач холбогдлын зэрэг хамгийн өндөр, маркетингийн хүчин зүйл (0.350) дараагийн чухал хүчин зүйлээр тодорхойлогдож, чанарын хүчин зүйл (0.121) болон нийгмийн хүчин зүйл (0.061) 3 ба 4-рт эрэмбэлэгдэв. Мэргэжилтний салбарын чухалчилж сонгосон бүтээгдэхүүний хүчин зүйлийн нарийвчилсан хүчин зүйлсэд найрлага, амт, үнэр зэрэг орно.

<Table 8> Relative Importance of the Main Variables

| Variables | Product | Marketing | Quality | Social | Total |
|-----------|---------|-----------|---------|--------|-------|
| Weight    | 0.469   | 0.350     | 0.121   | 0.061  | 1.00  |
| Rank      | 1       | 2         | 3       | 4      |       |

Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглэгчдийн бүлгийн үр дүнгээр маркетингийн хүчин зүйлийг хамгийн өндөр буюу 0.398, чанарын хүчин зүйл (0.243) хоёрдугаарт, бүтээгдэхүүний хүчин зүйл (0.236) гуравдугаарт тус тус сонгогдсон байгааг хүснэгт 9-аас харж болно.

<Table 9> Relative Importance of the Main Variables

| Variables | Product | Marketing | Quality | Social | Total |
|-----------|---------|-----------|---------|--------|-------|
| Weight    | 0.236   | 0.398     | 0.243   | 0.123  | 1.00  |
| Rank      | 3       | 1         | 2       | 4      |       |

### 4.3 2-р түвшний дэд хүчин зүйлсийн шинжилгээ

Мэргэжилтний салбарын хамгийн чухал хүчин зүйлээр сонгосон бүтээгдэхүүний хүчин зүйлсийн дэд хүчин зүйлсийг үнэлсний үр дүнгээр нэгдүгээрт найрлага (0.319), дараа нь үнэр (0.236), амт (0.234) тус тус оржээ <Table 10>. Харин хэрэглэгчийн салбараар харвал хамгийн их хувийн жинтэй нь амт (0.368) удаах байрт найрлага, үнэр зэрэг орсон байна.

<Table 10> Relative Importance of the Detailed Variables of the Product

| Expert Group |        |            | Customer Group |      |
|--------------|--------|------------|----------------|------|
| Rank         | Weight | Variables  | Weight         | Rank |
| 1            | 0.319  | Ingredient | 0.199          | 2    |
| 3            | 0.234  | Taste      | 0.368          | 1    |
| 2            | 0.236  | Flavor     | 0.175          | 3    |
| 5            | 0.105  | Origin     | 0.107          | 5    |
| 4            | 0.106  | Process    | 0.151          | 4    |
|              | 1.00   | Total      | 1.00           |      |

<Table 11> Relative Importance of the Detailed Variables of the Marketing

| Expert Group |        |                 | Customer Group |      |
|--------------|--------|-----------------|----------------|------|
| Rank         | Weight | Variables       | Weight         | Rank |
| 1            | 0.398  | Advertisement   | 0.180          | 3    |
| 4            | 0.151  | Brand           | 0.396          | 1    |
| 3            | 0.170  | Packaging       | 0.216          | 2    |
| 2            | 0.172  | Price           | 0.111          | 4    |
| 5            | 0.109  | Expiration date | 0.096          | 5    |
|              | 1.00   | Total           | 1.00           |      |

Маркетингийн хүчин зүйлсийн дэд хүчин зүйлсийн үнэлгээний үр дүнг харахад мэргэжилтний салбараар нэгдүгээрт зар сурталчилгаа (0.398), хоёрдугаарт үнэ (0.172), гуравдугаарт сав баглаа боодол (0.170), дөрөвдүгээр байрт брэнд (0.151) сүүлийн байр нь дуусах хугацаа (0.109) байсан. <Table 11> Хэрэглэгчийн салбарын хувьд брэнд(0.396) хамгийн өндөр, сав баглаа боодол(0.216) болон зар сурталчилгаа (0.180) удаах байруудад орсон бол үнэ болон хадгалалтын хугацааг төдийлөн чухалчилж үзээгүй үр дүн гарчээ.

<Table 12> Relative Importance of the Detailed Variables of the Quality

| Expert Group |        |               | Customer Group |      |
|--------------|--------|---------------|----------------|------|
| Rank         | Weight | Variables     | Weight         | Rank |
| 1            | 0.595  | Certification | 0.443          | 2    |
| 2            | 0.405  | Sanitation    | 0.557          | 1    |
|              | 1.00   | Total         | 1.00           |      |

<Table 13> Relative Importance of the Detailed Variables of the Social

| Expert Group |        |                | Customer Group |      |
|--------------|--------|----------------|----------------|------|
| Rank         | Weight | Variables      | Weight         | Rank |
| 1            | 0.615  | Custom         | 0.504          | 2    |
| 2            | 0.385  | Recommendation | 0.496          | 1    |
|              | 1.00   | Total          | 1.00           |      |

Мэргэжилтний салбарын хувьд чанарын хүчин зүйлээр нэгдүгээрт баталгаажуулалт (0.595), хоёрдугаарт эрүүл ахуй (0.405) тус тус орсон бол нийгмийн хүчин зүйлийн хувьд соёл уламжлал (0.615), дараа нь зөвлөгөө зөвлөмж (0.385)-ыг сонгожээ. Харин хэрэглэгчийн салбарын хувьд чанарын хүчин зүйлээс бүтээгдэхүүний эрүүл ахуйн үзүүлэлтийг чухалчилж үзсэн бол нийгмийн хүчин зүйлээс найз нөхдийн зөвлөгөө, зөвлөмжийг соёл, уламжлалаас чухал үзүүлэлт хэмээн үзсэн байна.<Table 13>

#### 4.3 Сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, сонголтын шалгуур үзүүлэлтийн харьцангуй ач холбогдол, зэрэглэлийн дүн шинжилгээ

<Table 14> The Relative Importance and The Rank of the Dairy products

| Expert Group                   |                                      |                    | Customer Group |             |          |                   |                                      |                                |
|--------------------------------|--------------------------------------|--------------------|----------------|-------------|----------|-------------------|--------------------------------------|--------------------------------|
| Main Variables and the weights | The Weights of the Detailed Variable | Detailed Variables |                |             |          |                   | The Weights of the Detailed Variable | Main Variables and the weights |
|                                |                                      | The total weights  | The Rank       | Gap ranking | The Rank | The total weights |                                      |                                |
| Product 0.469                  | 0.319                                | Ingredients        |                |             |          |                   | 0.199                                | Product 0.236                  |
|                                |                                      | 0.150              | 1              | (1)         | 9        | 0.046             |                                      |                                |
|                                | 0.234                                | Taste              |                |             |          |                   | 0.368                                |                                |

|                    |       |                 |    |     |    |       |       |                    |  |  |
|--------------------|-------|-----------------|----|-----|----|-------|-------|--------------------|--|--|
|                    |       | 0.110           | 4  | (9) | 4  | 0.086 |       |                    |  |  |
|                    | 0.236 | Smell           |    |     |    |       | 0.175 |                    |  |  |
|                    |       | 0.111           | 3  | 4   | 11 | 0.041 |       |                    |  |  |
|                    | 0.105 | Origin          |    |     |    |       | 0.107 |                    |  |  |
|                    |       | 0.049           | 10 | (9) | 14 | 0.025 |       |                    |  |  |
|                    | 0.106 | Process         |    |     |    |       | 0.151 |                    |  |  |
|                    |       | 0.050           | 9  | 13  | 13 | 0.036 |       |                    |  |  |
| Marketing<br>0.350 | 0.398 | Advertisement   |    |     |    |       | 0.180 | Marketing<br>0.398 |  |  |
|                    |       | 0.139           | 2  | 5   | 6  | 0.071 |       |                    |  |  |
|                    | 0.151 | Brand           |    |     |    |       | 0.396 |                    |  |  |
|                    |       | 0.053           | 8  | 1   | 1  | 0.157 |       |                    |  |  |
|                    | 0.170 | Packaging       |    |     |    |       | 0.216 |                    |  |  |
|                    |       | 0.059           | 7  | 8   | 5  | 0.085 |       |                    |  |  |
|                    | 0.172 | Price           |    |     |    |       | 0.111 |                    |  |  |
|                    |       | 0.060           | 6  | 12  | 10 | 0.044 |       |                    |  |  |
|                    | 0.109 | Expiration date |    |     |    |       | 0.096 |                    |  |  |
|                    |       | 0.038           | 12 | 14  | 12 | 0.038 |       |                    |  |  |
| Quality<br>0.121   | 0.405 | Sanitation      |    |     |    |       | 0.557 | Quality<br>0.243   |  |  |
|                    |       | 0.049           | 11 | 3   | 2  | 0.135 |       |                    |  |  |
|                    | 0.595 | Certification   |    |     |    |       | 0.443 |                    |  |  |
|                    |       | 0.071           | 5  | 7   | 3  | 0.107 |       |                    |  |  |
| Social<br>0.061    | 0.385 | Custom          |    |     |    |       | 0.504 | Social<br>0.123    |  |  |
|                    |       | 0.023           | 14 | 6   | 7  | 0.062 |       |                    |  |  |
|                    | 0.615 | Recommendation  |    |     |    |       | 0.496 |                    |  |  |
|                    |       | 0.037           | 13 | 9   | 8  | 0.061 |       |                    |  |  |

<Table 15> The Relative Importance and Gap Model

| The Rank | Customer ranking | Expert group ranking | Detailed Variables | Need for improvement | Gap    | Main Variables |
|----------|------------------|----------------------|--------------------|----------------------|--------|----------------|
| 1        | 1                | 8                    | Brand              | +                    | 0.104  | Marketing      |
| (1)      | 9                | 1                    | Ingredients        |                      | -0.104 | Product        |
| 3        | 2                | 11                   | Sanitation         | +                    | 0.086  | Quality        |
| 4        | 11               | 3                    | Smell              |                      | -0.07  | Product        |
| 5        | 6                | 2                    | Advertisement      |                      | -0.068 | Marketing      |
| 6        | 7                | 14                   | Recommendation     | +                    | 0.039  | Social         |
| 7        | 3                | 5                    | Certification      | +                    | 0.036  | Quality        |
| 8        | 5                | 7                    | Packaging          | +                    | 0.026  | Marketing      |

|     |    |    |                 |   |        |           |
|-----|----|----|-----------------|---|--------|-----------|
| 9   | 8  | 13 | Custom          | + | 0.024  | Social    |
| (9) | 14 | 10 | Origin          |   | -0.024 | Product   |
| (9) | 4  | 4  | Taste           | + | -0.024 | Product   |
| 12  | 10 | 6  | Price           |   | -0.016 | Marketing |
| 13  | 13 | 9  | Process         |   | -0.014 | Product   |
| 14  | 12 | 12 | Expiration date | + | 0.000  | Marketing |

## 5. Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд 2017 оноос сүү, сүүн бүтээгдэхүүнтэй холбоотой аян өрнүүлж, нийт долоон төсөл хэрэгжиж байгаа бөгөөд энэхүү аяны зорилго нь сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хэдийд ч улирлын хэлбэлзэлгүйгээр нийлүүлэх зорилготой юм. Энэ утгаараа манай улсын сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын мэргэжилтнүүдийн субъектив үнэлгээ, дүгнэлтийг судлах нь ихээхэн ач холбогдолтой. Ялангуяа хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай шинж чанар, үнэ, амт зэргийг цогцоор нь нэгтгэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулах боломжтой юм. Үүний тулд энэхүү судалгаагаар сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, худалдан авалтын шалгуур үзүүлэлт болох үндсэн болон дэд (нарийвчилсан) хүчин зүйлсийг онолын тойм судалгаан дээр үндэслэн олж тогтоон, тэдгээрийг хооронд нь харьцуулан эрэмбэлсэн. Үүнийг АНР (Analytic Hierarchy Process) аргаар монголын сүүний салбарын мэргэжилтнүүдээс авсан санал асуулгын дагуу эмпирик байдлаар баталгаажуулсан. Энэхүү судалгааны хураангуй үр дүн дараах байдалтай байна.

Нэгт, Нэг сарын хугацаанд нийт 100 хүнээс сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт ажилладаг 50 мэргэжилтэнг оролцуулан санал асуулга явуулсан. Үүнээс Consistency index-CI нь 0.1 ба түүнээс дээш гарсан 4 хүнийг эс тооцвол нийт 46 мэргэжилтний үр дүнгээр эмпирик шинжилгээ хийсэн. Харин хэрэглэгчийн салбарын төлөөлөл болох 50 хүний үр дүнгээс Consistency index-CI нь 0.1 ба түүнээс дээш гарсан 8 хүнийг хасаж 42 хэрэглэгчийн үр дүнгээр судалгааны үр дүнг нэгтгэн гаргав.

Хоёрдугаарт, Мэргэжилтнүүдийн салбарын үндсэн хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдлыг үнэлэхэд бүтээгдэхүүний хүчин зүйл (0.469) ач холбогдлын зэрэг хамгийн өндөр, маркетингийн хүчин зүйл (0.350) дараагийн чухал хүчин зүйлээр тодорхойлогдож, чанарын хүчин зүйл (0.121) болон нийгмийн хүчин зүйл (0.061) 3 ба 4-рт эрэмбэлэгдсэн бол хэрэглэгчдийн бүлгийн үр дүнгээр маркетингийн хүчин зүйлийг хамгийн өндөр буюу (0.398), чанарын хүчин зүйл (0.243) хоёрдугаарт, бүтээгдэхүүний хүчин зүйл (0.236) гуравдугаарт тус тус сонгогдсон байна.

Гуравдугаарт, Үндсэн хүчин зүйлсийн харьцангуй ач холбогдлын зөрүүний үр дүнг авч үзвэл хамгийн их зөрүүтэй хүчин зүйлээр бүтээгдэхүүн (0.233), 2-рт чанар (0.122), 3-рт нийгэм (0.062), маркетингийн хүчин зүйл (0.048) хамгийн бага зөрүүтэй гарчээ. Харин дэд хүчин зүйлсийн хоорондын зөрүүг авч үзвэл хамгийн том зөрүүтэйгээр брэнд (0.245), 2-рт сурталчилгаа (0.218), 3-рт эрүүл ахуй (0.152), баталгаажуулалт (0.152), амт (0.134), найрлага зэрэг удаах байруудад орсон байна. Судалгааны үр дүнг нэгтгэн харвал: Монгол хэрэглэгчийн чанарын боловсрол өсөн нэмэгдэхийн хирээр үйлдвэрлэгчийн хариуцлага болон бүтээгдэхүүний чанарт тавих шаардлагууд өндөрсөн. Тухайлбал маркетингийн дэд хүчин зүйлүүд болох брэнд, сав баглаа боодол, хадгалалтын хугацаа зэрэгт үйлдвэрлэгчийн зүгээс бодлого, чиглэлийн хүрээнд ихээхэн анхаарах шаардлага байгаа нь судалгаагаар харагдаж байна. Мөн хэрэглэгчийн эрүүл ахуйн болоод чанарын стандартчилал, баталгаажуулалтын мэдлэг мэдээлэл, шаардлага өндөр болсон

нь үйлдвэрлэгчид хэрэглэгчийн чанартай хэмээн дүгнэж, худалдан авалт хийдэг эдгээр онцлогийг бүтээгдэхүүндээ шингээн үйлдвэрлэх нь бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс ялгарах давуу байдлыг бий болгох боломжтой юм.

Уг судалгаанд дараахи хязгаарлагдмал талууд байна хэмээн үзэв. Нэгдүгээрт, хэрэглэгчидийн хоол хүнсний хэрэглээ, төлөв байдал өөр өөр байдаг тул хэрэглэгчдийг сегментчилэн судлах шаардлагатай,

Хоёрдугаарт, өрхийн орлого, ам бүлийн тоо гэх мэт эдийн засгийн хүчин зүйлстэй уялдуулан судлах шаардлага байгаа зэргийг дурьдаж болно.

Цаашид сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, сонголтын шалгуур үзүүлэлтийг илүү нарийвчлан, сүүний салбарын оролцогч талуудыг хамарсан өргөн хүрээтэй судалгаа хийх шаардлага бий.

## References

- [1] Kim, J. H., A Study on plans for enhancing the profitability of a milk agency, Hanyang University, Master Thesis, 2017.
- [2] Ministry of Food, Agriculture and Light Industry of Mongolia, 2018.
- [3] Kim, S. H., “The effects of TQM practices on firm performance through product, support, and service quality”, *Journal of the Korean Production and Operations*, Vol. 23, No. 2, 2012, pp. 171-196.
- [4] Lee, M. H., Consumption of dairy products and nutrition education associated with milky intake, Konkuk University, Master Thesis, 2012.
- [5] Noh, Y. H. “A study of consumers’ perception on food marking”, *Journal of Consumer Policy Studies*, Vol. 23, 2000, pp. 20-37.
- [6] Kader, A. A., “Increasing food availability by reducing postharvest losses of fresh produce”, *V International Postharvest Symposium*, Vol. 3, pp. 2169-2175.
- [7] Choi, M. S. Survey on the consumption pattern of the minimally processed fresh fruits and vegetables by urban women, Chung-Ang University, 2002.
- [8] Sabir, L. B., “Customer satisfaction parameters for fruits and vegetables retail-An AHP”, *International Journal of Advancement in Engineering Technology, Management & Applied Science*, Vol. 3, No. 2, pp. 6-18. 2016
- [9] Park, S. Y., Kim, H. J., and Nam, E. S., “A study on consumption behavior for milky and dairy products among middle school students”, *Culinary Science & Hospitality Research*, Vol. 17, No. 3, pp. 236-258.
- [10] Shin, S. Y., Lee, E. K., Cho, J. S., Lee, J. W., and Lee, S. W., “Improvement of port logistics in Korea for increasing import and export of fresh food cargoes”, *Korea Maritime Institute*, 2019, pp. 1-228.
- [11] Angowski, M. and Bujanowicz-Haras, B., “Consumers on organic food market-factors determining the choice of dairy products”, *Acta Scientiarum Polonorum. Oeconomia*, Vol. 18, No. 2, 2019, pp. 5-12.
- [12] Kurajdova, K. and Taborecka-Petrovicova, J. “Literature review on factors influencing milk purchase behaviour”, *International Review of Management and Marketing*, Vol. 5, No. 1, 2015, pp. 9-25.
- [13] Hysen, B., Mensur, V., Muje, G., Hajrip, M., Halim, G., Iliriana M., and Njazi, B., “Analysis of consumer behaviour in regard to dairy products in Kosovo”, *Journal of Agricultural Research*, Vol. 46, No. 3, 2008, pp. 311-320.
- [14] Besterfield, D. H. “Quality Control”, Prentice-Hall, 1986.
- [15] Park, H. R., “The consumers’ evaluative criteria of quality on the organic clothes and their purchase intention”, *Journal of the Korea Academia-Industrial Cooperation Society*, Vol. 16, No. 11, 2015, pp. 8001-8011.
- [16] Kim, M.-S. and Kim, M.-S., “The consumers’ evaluative criteria of quality on the clothing products”, *The Research Journal of the Costumer Culture*, Vol. 11, No. 1, 2003, pp. 47-65

# Happiness Metaphors in English and Mongolian

Chojin Zolzaya

*Chojin Zolzaya, Department of English Language, Mongolian University of Science and Technology,*

*zayamust@gmail.com*

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажлаар баяр баясгалан “happiness” хэмээх сэтгэлийн хөдлөл заасан концептуаль метафор англи монгол хэлээр хэрхэн илэрч байгааг концептуаль метафорын онолын хүрээнд /СМТ/ судалсан. Метафор нь бүх хэлэнд түгээмэл байдаг хэдий ч, тухайн улс үндэстний түүх, соёлыг тусгасан өвөрмөц хэлбэрээр илэрдэг. Судалгааны ажлаар англи монгол хэлний сэтгэл хөдлөл заасан метафорыг онолын загварын хүрээнд бодит эх сурвалжаас “MIP Steen 1999” буюу метафорыг илрүүлэх аргаар түүвэрлэн, нүүдэлчин ба суурьшмал соёлт ард түмний сэтгэлгээний онцлогыг жишээн дээр тулгуурлан тайлбарласан. Энэ ажлын онцлог нь “HAPPINESS” буюу баяр баясгалан, аз жаргал хэмээх сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн метафорыг утга зүйн үүднээс судлан, ялгаатай байдлыг Барселона (2001), Ковесес (2001) нарын боловсруулсан хэд хэдэн параметр үзүүлэлтээр авч үзлээ. Судалгааны ажлын үр дүнд концептуаль метафор нь тухайн үндэстний түүх, соёл, зан заншлаас хамаарахыг батлан, англи, монгол хэлэнд маш уран яруу илэрч байгаа нь харагдаж байна.

**Түлхүүр үг:** *эх үүсвэр ба бай хүрээ, хэл шинжлэл, когнитив, хэл соёл, сэтгэлгээ*

## 1. Оршил

Энэ судалгааны ажил нь метафор ба түүх, соёлын хоорондын уялдаа холбоо, англи монгол хэлний баяр баясгалан аз жаргалыг илэрхийлсэн метафор хоёр хэлэнд хэрхэн илэрч байгааг зэрэгцүүлэн судлах, метафорын төсөөтэй ба ялгаатай байдлыг бодит жишээгээр нотлон харуулсан. Мөн орчин цагийн когнитив хэл шинжлэлийн онолын хүрээнд хурцаар хөндөгдөн, судлаачдын дунд хэлэлцэгдэж байгаа метафорын түгээмэл, универсаль болон соёлын онцлогийг тусгасан ойлголтын талаарх асуудалд, сэтгэлийн хөдлөл илэрхийлсэн *баяр/happiness/* хэмээх концептуаль метафорыг судлан, нүүдэлчин монгол түмний хэл соёл нь суурьшмал соёлтой ард түмнээс хэрхэн ялгаатай болохыг батлан харуулахыг зорьсон.

Судалгааны ажил нь оршил, онолын хэсэг буюу концептуаль метафорын талаарх эрдэмтдийн үзэл, баримтлал, өнөөгийн чиг хандлага, судалгааны арга зүйд тохирсон параметруудийн онцлог, хэрхэн ашигласан байдал, мөн ажлын үр дүн, санал, дүн шинжилгээ гэсэн үндсэн бүлгүүдээс бүрдсэн. Мөн түүнчлэн энэ судалгааны ажлаар концептуаль метафорын /source, target domain/ домайн (цаашид эх үүсвэр ба бай хүрээ гэх) хоорондын концептуаль интеграцийн үзэл, уялдаа холбоо болон англи, монгол хэлэнд хэрхэн илэрч байгааг тухайн хоёр хэлний жишээгээр батлан харуулж, онолын үндэслэлтэй тайлбарласан бөгөөд аль ч хэлэнд түгээмэл ерөнхий концептуаль метафор байдаг хэдий ч, аливаа улс үндэстний соёлын онцлогийг харуулсан сэтгэлийн хөдлөл заасан концептуаль метафор нь маш нарийн уран яруу онцгой байдлаар илэрдэг болохыг судалсан.

## 2. Концептуаль метафорын онол

Метафор судлал нь хэл шинжлэлийн маш сонирхолтой сэдвийн нэг байсаар ирсэн. “Metaphor” гэдэг үг нь “metaphora” гэх грек үгнээс үүсэлтэй. Когнитив хэл шинжлэлийн ухаан хөгжихөөс өмнө метафорыг зөвхөн утга зохиолын уран яруу хэлбэр хэмээн үздэг байсан. Метафор нь философи, түүх соёл, улс үндэстний сэтгэлгээний онцлог зэргийг харуулж байдаг учраас судлаачдын хувьд маш чухал судалгааны сэдэв болсоор байна. Концептуаль метафорын сонгодог онолыг анх Ж. Лакофф, М. Жонсон (1980) нар дэвшүүлэн гаргасан. Концептуаль метафорын сонгодог онол, концептын тухай ойлголт, метафор загварын тухай үзэл баримтлалын талаар бид америкийн эрдэмтэн судлаачид Ж. Лакофф, М. Жонсон (1980), Редди (1979) “The Conduit Metaphor” нарын “Metaphors we live by” бүтээлүүдээс харж болно. Эдгээр бүтээл нь концептуаль метафорын онолын хөгжилд чухал хувь нэмэр оруулсан. Когнитив хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл метафорыг эх үүсвэр/source domain/ болон бай/target domain/ хүрэнүүдийн хоорондын харьцаанд хамааруулан авч үзнэ.

Метафорын систем нь үгийн сан, хэл зүй, утга зүй болон найруулга зүйд асар их үүрэгтэй. Метафорыг ойлгоход эхийн хүрэнээс байн хүрээнд шилжүүлэн ойлгодог. Концептуаль метафор нь “тухайн хэл эзэмшигчдийн соёлын парадигмийн салшгүй хэсэг” (Ж. Лакофф 1993:210) болсон байдаг тул хүмүүс метафор хэмээн ухамсарладаггүй байна. Мөн Ж.Лакофф, М.Жонсоны (1993: 203) когнитив үзлээр бол метафор нь концептуаль систем дэх эх хүрэнүүдийн хоорондын оноолт юм. Хэл шинжлэлд концептуаль метафорыг том үсгээр бичиж тухайн хэлний концептыг илэрхийлдэг. Ковесесс З.,(2005) “метафор нь олон талт үзэгдэл бөгөөд, аливаа хэлэнд байх төдийгүй, концептийн систем, түүнчлэн нийгэм соёлын бүтэц, сэтгэлгээ болон хүмүүсийн үйл байдалд хүртэл оршин байдаг” гэжээ.

Энэхүү судалгааны ажил нь сэтгэлийн хөдлөлийг илэрхийлсэн концепт нь цогц бүтэцтэй ба энэ нь концептуаль метафороор илэрч байгааг онцлон тэмдэглэж байна. Мөн техник технологийн эрин эрчимтэй хөгжихийн зэрэгцээ 1980 оноос хойш корпус хэл шинжлэлийн судалгаа эрчимтэй хөгжиж, метафорыг судлахад чухал нөлөөтэй болж ирсэн. Дегнан (2005) онд метафорыг судлан илрүүлэхэд корпусыг хэрхэн ашиглах арга зүйн чиг хандлагыг гаргаж өгсөн нь судлаачдад нэг том алхам болсон юм.

Монгол судлаачид сүүлийн жилүүдэд концептуаль метафорыг судлан, когнитив хэл шинжлэлийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна. Гэвч бид нэлээд дорвитой дэлхийд танигдсан когнитив хэл шинжлэлийн судалгааны ажил хийх шаардлагатай юм. Монголч эрдэмтэн А. Оберползерова (2006) угсаатан зүйн судалгаа хийн, монгол хэл, соёл, харилцааны чиглэлээр судалгаа хийн, монгол түмний соёл, хүмүүсийн хэл ярианы онцлог, зэргийг өөрийн бүтээлдээ нэлээд дэлгэрэнгүй тусган харуулсан байдаг. Мөн судлаач Б. Төмөрхуяг (2011), улс төрийн дискурс дэх концептуаль метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь тус чиглэлийн судлаачдад хүртээмжтэй ажил болсон юм. Харин англи монгол хэлэн дэх сэтгэлийн хөдлөл заасан концептуаль метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан энэ ажил нь нилээд өвөрмөц судалгаа болж байгаагаараа онцлогтой.

## 3. Судалгааны арга зүй

Энэ судалгаа нь когнитив семантик буюу танихуйн хэл шинжлэлийн утга зүйн хүрээнд хийгдсэн. Сэтгэлийн хөдлөл /баяр баясгалан, happiness/ заасан концептуаль метафор англи монгол хэлэнд хэрхэн илэрч байгааг олж, ижил төсөөтэй болон ялгаатай байдлыг гаргаж тавих

нь энэ судалгааны ажлын гол зорилго учраас, хоёр хэлний шилжсэн утга илэрхийлсэн 1000 орчим метафор, адилтгал, зүйрлэлийг түүвэрлэн авч анализ хийлээ.

Англи хэлний жишээг когнитив хэл шинжлэлийн хүрээнд концептуаль метафорын судалгаа хийсэн судлаачдын бүтээл, толь бичиг, СОСА корпус судалгаанаас түүвэрлэсэн. СОСА (Corpus of Contemporary American English) нь 520 сая үгийн сангай хэл шинжлэлийн судалгаа хийхэд өргөн цар хүрээтэй, төрөл бүрийн мэдээллийн сан агуулсан электрон файл юм. Энэ сан нь 1990-2015 оны англи хэлний (American English) төрөл бүрийн эх үүсвэрээс авсан мэдээллийг багтаасан тул өргөтгөсөн дискурс, контекстийн хүрээнд анализ хийж үзэх боломжтой. Англи хэлний сэтгэлийн хөдлөл (*баяр happiness*) заасан концептуаль метафорыг электрон сан ашиглан судалснаар тухайн ард түмний харилцааны бодит яриа, контекстийг судлан үзэх боломжтой.

Монгол хэлний концептуаль метафорын жишээ баримтыг тайлбар толь бичиг, орчин цагийн монголын зохиолчдын өгүүллэгүүд болон дуу, яруу найраг, шүлэг, Монголын сонгодог бүтээл “Монголын нууц товчоо” аман яриа, интернет мэдээ, цахим орчны дискурсын хүрээнд нилээд олон бүтээлээс түүвэрлэн авсан. Энэ судалгааны ажлын хүрээнд метафорын ялгаатай байдлыг Барселона А.,(2001), Ковесес З.,(2001) нарын боловсруулсан хэд хэдэн параметр үзүүлэлтээр авч үзсэн.

### **3.1. Метафорыг илрүүлэх арга /Metaphor Identification Procedure (Steen 1999) (MIP)**

Судалгааны ажлын явцад төрөл бүрийн эх үүсвэрээс түүвэрлэсэн монгол хэлний концептуаль метафорыг олохдоо Стин, Праглежаз МIP /1999/ нарын метафор илрүүлэх аргыг ашигласан. Энэ арга нь практикт тулгуурласан, системтэй арга барил юм. МIP арга дараах үе шатаар метафор илрүүлдэг (Steen 1999).

1. Төрөл бүрийн эх текст уншиж тухайн хэлний метафорыг олж түүвэрлэх
2. Дискурс дэх метафорт анализ хийн сэтгэл хөдлөл заасан зүйрлэл мөн эсэхийг тогтоох
3. Тухайн дискурс дэх утга нь үгийн үндсэн утгаас ялгаатай эсэхийг шалгах
4. Үгийн контекстийн утга үндсэн утгын хоорондын хамаарал болон эх үүсвэр хүрээ, бай хүрээнүүдийн хамаарал, төсөөтэй шинжийг тогтоох шалгах
5. Тухайн метафорийг тэмдэглэх бүртгэх

### **3.2. Сонгосон параметр үзүүлэлтүүд Барселона, Ковесес (2001)**

Судалгааны ажлын явцад англи монгол хэлэнд аль алинд нь ерөнхий концептуаль метафор */universal conceptual metaphor/* байгаа хэдий ч, эдгээр нь маш нарийн өвөрмөц хэллэгээр тухайн соёлд баяжин хэрэглэгдэж байгаа нь ажиглагдсан. Иймд судалгааны ажлын үр дүнд түүвэрлэн шалгасан жишээг Барселона А., Ковесес З., (2001) нарын боловсруулсан дараах гурван төрлийн параметр үзүүлэлтээр авч үзлээ.

1. Эх үүсвэр болон бай хүрээнүүдийн хоорондын онолт байгаа эсэх */The existence and non-existence of the mappings/*
2. Тухайн хэлний зүйрлэсэн хэллэг нь хэрхэн баяжин илэрч байгаа байдал */degree of linguistic elaboration*
3. Зүйрлэсэн хэллэг нь тухайн хэлэнд хэвшсэн байдал */degree of conventionalization/*

Судлаач Барселона А., (2001) аливаа хэлний зүйрлэсэн хэллэг нь */metaphorical expression/* нөгөө хэлний хэллэгээс ялгарах онцлог нь тухайн хэлний уран яруу нарийн онцгой хэлбэр, хэм хэмжээ юм” гэж тэмдэглэжээ. Зүйрлэлийн ялгаатай байдлыг авч үзсэн дараагийн нэг үзүүлэлт нь хоёр хэлэнд метафор хэрхэн баяжин боловсронгуй болон хэрэглэгдэж байгаа байдал юм. Ковесес З.,(2001: 151) хэлний метафорын баяжин боловсронгуй болж байгааг эх үүсвэр болон бай

хүрээний оноолт нь хоёр хэлэнд хэрхэн их бага хэмжээгээр баяжин хэрэглэгдэж байгаа байдал буюу тогтсон хэм хэмжээ юм” гэж тайлбарласан байна. Англи монгол хэлний сэтгэлийн хөдлөл илэрхийлсэн концептуаль метафор нь тухайн хэлэнд өөр өөр байдлаар хэвшсэн нь судалгааны ажлын явцад харагдаж байна.

#### 4. Судалгааны ажлын үр дүн

Судалгааны явцад түүвэрлэн анализ хийсэн 1000 гаруй сэтгэлийн хөдлөл илэрхийлсэн англи, монгол хэлний жишээнээс энэ өгүүлэлд зөвхөн аз жаргал, баяр баясгалан “HAPPINESS” илэрхийлсэн концептуаль метафор тухайн хэлэнд ямар үг хэллэгээр баяжин хэрэглэгдэж байгааг авч үзлээ. Дараах хоёр бүлгээс концептуаль метафор нь англи монгол хэлэнд хэрхэн ижил төсөөтэй болон ялгаатай байдлаар илэрч, мөн нүүдэлчин болон суурьшмал соёлтой хоёр ард түмний хэл, сэтгэлгээ соёл концепцтийн ялгааг олж харах болно.

##### 4.1. Концептуаль метафорын түгээмэл шинж

Судалгаанаас харахад англи монгол хэлэнд аль алинд нь байгаа түгээмэл ерөнхий концептуаль метафор байна. Аз жаргал баяр баяслыг илэрхийлсэн метафор нь хүний мэдрэхүй болон амьдралын явцад бий болсон туршлага дээр тулгуурлан бий болсон түгээмэл шинжтэй. Ийм учраас хоёр хэлэнд түгээмэл метафорууд элбэг байна. Судалгааны явцад дараах концепцууд хоёр хэлэнд ерөнхий схемийн түвшинд оршиж байна. “БИЕ БОЛ СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙГ АГУУЛЖ БАЙГАА САВ, THE BODY IS A CONTAINER FOR EMOTIONS; **English:** *She overflowed with happiness*, Ковесес: 1988), **Монгол:** *Зүрх сэтгэл мин баяр хөөрөөр дүүрэн байна. ИМ) АЗ ЖАРГАЛ БАЯР ХӨӨР- ДЭЭШЭЭ, HAPPINESS IS UP; English: I am feeling up, Ж.Лакофф, М.Жонсон: 1980), Монгол: Сэтгэл өөдрөг байна. ХЯ). HAPPINESS IS BEING OFF THE GROUND; English: I am six feet of the ground Ковесес 2000: 24), Монгол: Тэр бүр хөөрчихсөн явна. ХЯ) АЗ ЖАРГАЛ БОЛ ГЭРЭЛ ГЭГЭЭ, HAPPY IS LIGHT, English: She brightened up at the news, ОТБ, 2000” **Монгол:** *Хүү нь ирээд нар нь гарч байна. ИМ) гэх мэт.**

Хоёр хэлний хувьд аз жаргал баяр баясгалантай холбоотой үндсэн метафорыг авч үзье. Ж.Лакофф ба М.Жонсон (1980) болон Ковесес (1991) нар “HAPPY IS UP” метафортой уялдуулан аз жаргал баяр хөөр бол өөдөө дээш чиглэсэн зүйл гэх санааг гаргаж ирсэн. Ж.Лакофф ба М.Жонсон (1980: 50)-ийн хэлснээр “эдгээр зүйрлэлүүдийн үндэс нь аз жаргалын мэдрэмж болон бидний босоо, эгц дээшээ байдлыг мэдрэх мэдрэмж-хөдөлгөөний туршлага хоёрын хооронд системчилсэн хамаарал юм.” Англи хэлний “HAPPY IS UP, HAPPINESS IS BEING OFF THE GROUND” гэсэн концептуаль метафор монгол хэлэнд байна. Доорх жишээнүүдийг авч үзье: HAPPY IS UP: *Англи хэл: I am feel up, Lighten up! (Ж.Лакофф ба М.Жонсон 1980); Монгол хэлээр: Өнөөдөр сэтгэл санаа өөдрөг байна, Тэр бүр хөөрчихсөн явж байна. ИМ) гэх мэт.* Энэ жишээн дээрх хэллэгүүд нь хүмүүс аз жаргалтай баяр хөөртэй байгааг харуулж байна.

##### 4.2. Концептуаль метафорын ялгаатай байдал

Судалгааны энэ хэсэгт аз жаргал баяр баяслыг илэрхийлсэн зүйрлэлийг англи, монгол хэлээр тайлбарласан. Гол ялгааг Барселона (2001) болон Ковесес (2001) нарын санал болгосон сонгосон параметруудийн дагуу шинжлэн авч үзлээ.

**Параметр 1** нь хоёр хэл дээрх хэлний онцлогт тохирсон зураглал байгаа эсэх энэ ангилалд хамаарна. Энэхүү судалгаагаар англи хэлэнд АЗ ЖАРГАЛ БОЛ ДЭЭД ТЭНГЭРТ БАЙХ ЯВДАЛ, “HAPPY IS BEING IN HEAVEN; *It was heaven on earth, I was in seventh heaven (Ж.Лакофф,*

М.Жонсон 1980) ” АЗ ЖАРГАЛ БОЛ САВАНД БАЙГАА ШИНГЭН, “HAPPINESS IS A FLUID IN A CONTAINER, *He was overflowing with joy* (Ковесес 1991: 34) ” АЗ ЖАРГАЛ БОЛ ОЛЗЛОГДСОН “АМЬТАН, HAPPINESS IS A CAPTIVE ANIMAL; *His feelings of happiness broke loose*”, АЗ ЖАРГАЛ БОЛ БАЙГАЛИЙН ХҮЧ; “HAPPINESS IS A NATURAL FORCE, *He was swept off his feet*, (Ковесес 2000: 24)” зэрэг концептуаль метафор байна. Харин монгол хэлний хувьд АЗ ЖАРГАЛ БОЛ АМТАТ ХООЛ *аз жаргалыг амтлах*, АЗ ЖАРГАЛ БОЛ САВАНД БАЙГАА ХАЛУУН ШИНГЭН *халуун баяр*, АЗ ЖАРГАЛ БОЛ БӨӨН ЮМ *бөөн баяр* гэх мэт концепц ухагдахуун байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна.

**Параметр 2** нь англи, монгол хэлний сэтгэлгээний зураглал хэл шинжлэлийн хувьд хэрхэн илэрч байгаа ялгааг авч үзсэн. “HAPPY IS UP, АЗ ЖАРГАЛ-ӨӨДӨӨ ДЭЭШЭЭ” гэсэн ойлголт нь англи хэл дээр илүү нарийн боловсруулагдан тухайн хэлэнд хэрэглэгдэж байна. (*Жишээ нь: I am feel up; Lighten up!*). Аз жаргалыг илэрхийлэх “БАЙР САВ, CONTAINER” хэмээх ерөнхий метафор монгол хэлэнд илүү баяжин өвөрмөц байдлаар илэрч байна. Монголоор аз жаргал хүний бие, нүд, сэтгэл зүрхэнд оршдог гэдгээс харж болно (*Жишээ нь: Миний сэтгэл, сэтгэл баяр хөөрөөр бялхаж байна*, (Б. Сарантуяа, *Сорхогтун хатан: 2011*), *Магнай хагартлаа баярлах* (МСТБ: 1990)

**Параметр 3** нь хэл шинжлэлийн уламжлал тухайн хэлэнд хэвшсэн байдлын талаар авч үзсэн. Аз жаргал баяр хөөрийг өөдөө дээшээ, шингэн зүйл ухаангүй зүйл гэх санааг илтгэсэн “HAPPY IS UP, HAPPINESS IS A FLUID IN CONTAINER, HAPPINESS IS INSANITY” концептуаль метафор англи хэлэнд маш их түгээмэл хэрэглэгддэг бөгөөд энэ нь тухайн хэлний хувьд хэвшсэн ойлголт юм. Англи хэлэнд аз жаргалыг илэрхийлэх хамгийн уламжлалт хэллэг бол “*to overflow with joy, joy welled up, to burst with joy, баяр хөөрөөр дүүрэн, баяр баясгалан дүүрэн, баяр хөөрөөр тэсрэх*, (ОАМТБ: 2006)” зэрэг юм. “АЗ ЖАРГАЛ БОЛ БӨӨН ЮМ, HAPPINESS IS ACCUMULATION, АЗ ЖАРГАЛ ГЭРЭЛ, HAPPINESS IS LIGHT, АЗ ЖАРГАЛ БОЛ ШИНГЭН ЗҮЙЛ, HAPPINESS IS FLUID” гэх мэт концептуаль метафор монгол хэлэнд түлхүү уламжлагдан хэрэглэгдэж ирсэн. Аз жаргалын тогтсон үг хэллэгүүд байдаг, тухайлбал “бөөн баяр болох; нар гарах, гэрэл гэгээ цацруулах, нар мандах; халуун баяр; аз жаргалаар дүүрэн, аз жаргал, баяр баясгалангаар дүүрэн байх” гэж монголоор аз жаргалтай, баяр баясгалантай байхыг хэлдэг.

Хоёр хэл дээрх баяр басгалан, аз жаргалын зүйрлэлүүдийн ижил төстэй болон ялгаатай талуудыг дараах байдлаар товч тайлбарлав: Хоёр соёл нь “хүн бол аз жаргалыг агуулж байгаа сав” гэж ойлгодог. Бид нэг хүн төрөлхтөн бөгөөд бидний зан араншин, физиологийн нөлөө нь соёл иргэншилд ижил байдаг тул хоёр хэлэнд аз жаргалын тухай ижил зүйрлэл байна. Түүнчлэн хоёр соёлд “АЗ ЖАРГАЛ БОЛ АМЬДРАЛ, ХҮЧ ЧАДАЛ HAPPINESS IS VITALITY” гэсэн ойлголтоос үүдэлтэй хүний бие махбодын туршлагад тулгуурлан аз жаргал бол “амьдрал дулаан, идэвхтэй байдал”, “үхэл бол хүйтэн” гэсэн үзэл санаа байгааг дэвшүүлж байна. Ж.Лакофф, М.Жонсон (1980) нар “ӨӨДӨӨ ДЭЭШЭЭ “UP” гэх мэт чиг баримжаатай холбоотой аз жаргалын зүйрлэлийн үндэс нь “аз жаргал, happiness” хэмээх сэтгэл хөдлөл болон бидний босоо байрлал дахь мэдрэхүй-хөдөлгөөний туршлага хоёрын хооронд системчилсэн хамаарал байдаг” гэж онцлон үздэг. Үүний дагуу англи, монгол хэл нь “HAPPY IS UP, АЗ ЖАРГАЛ-ӨӨДӨӨ ДЭЭШЭЭ” гэсэн ерөнхий зүйрлэл хоёр соёл түгээмэл байна.

Хэлний хэрэглээнээс харахад энэ хоёр соёл нь өөр өөр хэл шинжлэлийн боловсруулалт, уламжлалт илэрхийлэл, аз жаргалын тухай сэтгэлгээний зураглал бүхий концептуаль метафортой байгаа нь харагдаж байна. Тухайн хоёр хэлээр ярьдаг хүмүүс аз жаргалтай байгаа сэтгэл хөдлөлийг илэрхийлэхийн тулд эх хэлний өөр өөр үг хэллэгийг хэрэглэдэг. Хэдийгээр хоёр соёл иргэншил нь аз жаргалыг илэрхийлэх " САВАНД ДАХЬ ШИНГЭН, FLUID IN A

CONTAINER, " метафорыг хуваалцдаг ч гэсэн өөр өөр дэд метафоруудтай байна. Аз жаргалын хувьд шингэний температурыг англи хэлээр заагаагүй болно. Гэтэл монголчууд аз жаргалыг саванд хийсэн халуун шингэн гэж ойлгодог. Энэ зүйрлэлд температурыг илүү тодорхой зааж өгсөн бөгөөд энэ нь тухайн соёлын хувьд хамгийн дээд аз жаргал баяр баяслыг илтгэнэ. Түүгээр ч зогсохгүй англи хэлээр аз жаргалын "ТЭНГЭРТ БАЙХ, BEING IN HEAVEN", гэсэн ойлголт нь АЗ ЖАРГАЛ "HAPPINESS" эх домэйны үүрэг гүйцэтгэдэг. Концепцийн зүйрлэлд ашигладаг үзэл баримтлал нь тухайн соёл дахь тэдний үзэл суртал, нийгэм, шашны туршлага дээр суурилдаг. Үүний дагуу монгол хэлэнд энэ ойлголт байхгүй. Харин монголчууд амьд ахуйдаа хүний төлөө сайн сайхан зүйл хийсэн бол насан эцэс болсны дараа тэнгэрт дэвших буюу диваажинд байх болно гэж үзэл баримтлалын хувьд итгэдэг. Энэ нь монголчуудын шашин шүтлэгтэй нягт холбоотой. Харин "АЗ ЖАРГАЛ ҮНЭ ЦЭНЭТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН HAPPINESS IS A VALUABLE COMMODITY" гэдэг зүйрлэл нь англи хэлээр ярьдаг хүмүүс аз жаргалыг хүмүүсийн бусдад өгч, авах боломжтой үнэт зүйл гэж үздэгийг харуулж байна. Харин монгол хэлэнд аз жаргалыг хамгийн нандин эрдэнэ гэж үздэг.

"АЗ ЖАРГАЛ БОЛ БАЙГАЛИЙН ХҮЧ HAPPINESS IS NATURAL FORCE" гэдэг зүйрлэл нь аз жаргалын эрч хүчийг онцлон харуулдаг. Аз жаргалын хүчийг англиар "байгалийн хүч natural force" гэж ойлгодог. Англи хэлээр ярьдаг хүмүүс аз жаргалыг олзлогдсон амьтан гэж бас ойлгодог. Монголчууд аз жаргалыг олзны амьтан гэж ойлгодоггүй. Эдгээр үзэл баримтлалын ялгаа нь амьдралын тухай ялгаатай туршлагаас үүдэлтэй юм. "АЗ ЖАРГАЛТАЙ ХҮН БОЛ САЙХАН АМЬДРАХ АМЬТАН, A HAPPY PERSON IS AN ANIMAL THAT LIVES WELL" концептуаль метафор хоёр хэлэнд аль алинд нь байгаа хэдий ч энэ ойлголт нь өөр өөр хэлбэрээр тусгагдсан байдаг. Монголчууд аз жаргалтай эрх чөлөөтэй хүнийг тэнгэрт нисч буй шувуу эсвэл Монголын тал нутагт эрх чөлөөтэй хулан тахьтай адилтган шүлэглэн бичсэн байдаг. Түүгээр ч барахгүй барууны соёлд хүмүүс нүүдлийн соёл иргэншлээс илүү бие биенээсээ хамааралтай байдаг. Нүүдлийн соёл иргэншилд хүмүүс дөрвөн улирлын турш бэлчээр сайтай газар хайж, байгалийн жамаар малаа өсгөн амьдардаг. Нүүдэлчин ард түмэн олон зууны турш эзгүй хээр талд бусдаас хамааралгүй ганцаараа амьдарч ирсэн. Одоо ч хөдөөгийн айлууд ийм л амьдралаар амьдарч байна. Иймээс энэ бүх туршлага нь аз жаргалыг эрх чөлөө, аз жаргалтай хүнийг эрх чөлөөтэй амьтан гэж үзэх үзэл санааг энэ соёлд бий болгох гол шалтгаан болж чадна.

Энэхүү судалгаагаар "аз жаргал, happiness" гэдэг ойлголт монгол хэлэнд олон утгатай болохыг тогтоожээ. Монголчууд эрт дээр үеэс байгаль дэлхий, түүний хууль тогтоомжийг хүмүүст таниулах зорилготой есөн чухал хүсэл эрмэлзэлтэй байдаг. Монгол хэлэнд аз жаргалын тухай ойлголтыг хөнгөвчлөх гурван чухал зүйл байдаг. Эхнийх нь амьдын жаргал. Энэ нь аз жаргалыг амьдрал, амьд байх гэсэн ойлголттой холбодог. Хоёр дахь нь амар амгалангийн тухай ойлголт юм. Монголчуудын хувьд оюун санааны зовлон нь хүний амьдралын хамгийн хэцүү зүйл гэж үздэг. Жаргалын дээд сэтгэл амар амгалан гэдэг үгэнд энэ ойлголт тусгалаа олсон байдаг нь хүний хийморь лундаа амгалан байвал хамгийн чухал аз жаргал гэж үздэг. Гурав дахь нь эрүүл мэндийн тухай юм. Монголчууд аз жаргалыг эрүүл мэнд гэж үздэг, өвчин үгүй бол жаргал (өвчингүй жаргах) гэж зүйрлэн хэлдэг. Иймд аз жаргал гэдэг ойлголт нь монгол ахуйд "АЗ ЖАРГАЛ ЭРҮҮЛ МЭНД, HAPPINESS IS HEALTH" гэсэн зүйрлэл маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол хэл дээрх аз жаргалын зүйрлэл нь хүнийг залуу насандаа хэрхэн аз жаргалтай байхыг заадаг. Аз жаргалын тухай ойлголтыг нүүдэлчин ард түмний хамгийн чухал хүслийн нэг гэж үздэг тул энэ соёлд аз жаргалын тухай нарийн, уламжлалт сэтгэлгээний онцлогыг тусгасан зүйрлэлээр баялаг юм.

Мөн нүүдэлчин соёлд *магнай тэнийх, нуруу тэнийх* (МСТБ,1990 зэрэг соёлын онцлогт

тохирсон метафорууд нь нүүдэлчин ард түмний мал аж ахуйн туршлагаас үүдэлтэй. Удаан салсны дараа дахин уулзаж аз жаргалыг мэдрэх тохиолдолд *магнай тэнийх* хэллэгийг хэрэглэх нь түгээмэл байдаг. Энэ ойлголт нь монголчуудын түүхтэй нягт холбоотой. Эрт дээр үед нүүдэлчид гадаад, дотоод зөрчилдөөн ихтэй байсан нь дайн, тулааны улмаас айл өрх, ард түмнээ олон жил салгаж байсан. Энэ нь баяр баясгалан, уйтгар гунигийг элэг, зүрх, цээжтэй холбож ойлгоход хүргэж болзошгүй юм. Түүгээр ч зогсохгүй малчид өвөлжилт хүндэрсэн хойноо “*Хүн малын нуруу тэнийж байна*” гэж “*Одоо хавар болж, хүн мал сайхан жаргаж байна*” хэмээн ярих нь бий. Аз жаргалыг монголоор бие, нүд, зүрх, сэтгэл, элэгээр илэрхийлдэг. Бас нэг сонирхолтой баримт бол монголчуудын уламжлалт “гэр” орон сууцыг аз жаргалын сав гэж үздэг. (*Жишээ нь: тэдний инээж баясалдах нь гэр хагармаар... Д.Нацагдорж, Цагаан сар ба хар нулимс, 1932*). АЗ ЖАРГАЛ бол амттай хоол, ундаа гэдэг зүйрлэл нь аз жаргалын чухлыг онцолж өгдөг. Амттай хоол, ундаа нь тухайн хүнд эрч хүч, амьд үлдэх хүчийг өгдөг. Аз жаргалыг хүмүүст илүү их эрч хүч өгч, илүү сайхан мэдрэмж төрүүлдэг эерэг сэтгэл хөдлөл гэж үздэг. Эдгээр ижил төстэй зүйл дээр үндэслэн монгол хэлээр ярьдаг хүмүүс аз жаргалыг амттай хоол, ундаа гэж үздэг. (*Жишээн нь: жаргал амсах, ИМ*)

Аз жаргалын сэтгэл хөдлөлийн талаархи зүйр үгийн зарим тогтсон хэллэгүүд байдаг. “Монголын нууц товчоо” (МНТ: 2011) хэмээх сонгодог түүхэн сурвалжид олдсон хэл шинжлэлийн нотлох баримтаас үзэхэд эрт дээр үеэс монгол хэлээр ярьдаг хүмүүс аз жаргалыг гэрэл гэгээ гэж үздэг болохыг харуулсан байна. Энэхүү түүхэн сурвалж нь нүүдэлчдийн амьдралын тухай ойлголтыг тусгасан зүйр үг, ардын үлгэр, зүйр цэцэн үг, магтаал, домог зэргээр баялаг юм. Нүүдэлчин ард түмний дунд олон зуун жилийн турш ардын үлгэр, мэргэн үгсээс гаралтай аз жаргалын зүйрлэлүүдийг англи хэлтэй харьцуулахад маш уламжлалт байдлаар илэрхийлсэн баримтууд байдаг. (*Жишээ нь нүдэндээ галтай гэрэлт, нүд нь галтай, нүүрэндээ гэрэлтэй МНТ: 2011*). Энэхүү тайлбарыг ардын үлгэрт аз жаргалтай, баяр баясгалантай хүнийг дүрслэхдээ ихэвчлэн ашигладаг. Монгол хэлээр ярьдаг хүмүүс аз жаргал баяр хөөрийг сэтгэл, нүүрэнд нь галын гэрэлтэй гэж үздэг. Мөн бид хэл шинжлэлийн өөр төрлийн танин мэдэхүйн үйл ажиллагаа болох хувь хүний сэтгэлгээг илэрхийлэх зарим жишээг олсон (*Жишээ нь: аз жаргал хаалгыг минь тогшино*). Дээрх жишээнээс харахад зүрх бол хайр, уйтгар гуниг, баяр хөөрийг багтааж байдаг контейнер буюу сав, орон зай гэсэн ухагдахууныг илэрхийлж байгаа нь аль ч хэлэнд универсаль болохыг харуулж байна. Үүнээс дүгнэхэд аль ч хэлэнд универсаль нийтлэг концептуаль метафорууд байдаг, учир нь бид хүмүүн учир уурлах, баярлах, гуних, хайрлахад нэг ижил физиологийн шинж чанар илэрдэг.

## 5. Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүнд англи, монгол хэлний аз жаргал баяр баясгалан илэрхийлсэн концептуаль метафорыг судлан, хоёр хэлний ижил төстэй болон ялгаатай талыг когнитив хэл шинжлэлийн утга зүйн хүрээнд судалж, нүүдэлчин түмний хэл соёл, түүх сэтгэлгээний онцлогийг, сууршмал соёлт ард түмний хэл соёлтой харьцуулснаар, танихуйн хэл шинжлэлийн хөгжилд тодорхой хувь нэмэр болно гэж найдаж байна. Хоёр хэлний хувьд ижил төсөөтэй универсаль метафор байгаа хэдий ч, мөн тухайн хэл соёлын онцлогийг харуулсан маш өвөрмөц зүйрлэсэн хэллэг болон концепт байна. Монгол хүмүүсийн сэтгэлгээ нь суурьшмал соёлтой англи, америкийн ард түмнээс өөр төдийгүй, монголчуудын хувьд ертөнцийг үзэх үзэл, нүүдэлчин ахуй, байгал дэлхийтэй ойрхон байдаг зэрэг олон хүчин зүйлүүд метафор үүсэн бий болж хэрэглээнд нэвтрэхэд нөлөөлж байна.

## Ном зүй

1. Barcelona, A. 1986. "On the Concept of Depression in American English: Cognitive -Approach", *Revista Canaria de Estudios Ingleses*, 12: 7-33.
2. Barcelona, A. 2001. "On Metaphor the Systematic Contrastive Analysis of Conceptual Metaphors: Case Studies and Proposed Methodology", <http://www.google.com>
3. Deignan, A. 2005. *Corpus Linguistics*, Amsterdam: John Benjamins Publishing.
4. Kovecsés, Z. 1986. *Metaphors of Anger, Pride, and Love: A Lexical Approach to the Structure of Concepts*, Amsterdam John Benjamins.
5. Kovecsés, Z. 1990. *Emotion Concepts*, Berlin and New York: Springer-verlag.
6. Kovecsés, Z. 2000a. *Metaphor and Emotion*, Cambridge: Cambridge University Press.
7. Kovecsés, Z. 2002. *Metaphor: A Practical Introduction*, Oxford: University Press.
8. Kovecsés, Z. 2005. *Metaphor in Culture*, Cambridge University Press.
9. Lakoff, G. and M. Johnson. 1980. *Metaphors We live By*, Chicago: Chicago University Press.
10. Nacey, 2009. *Introduction to the Metaphor Identification Procedure (MIP)*, <http://www.slideserve.com>
11. Oberfalzerova, A. 2006. *Metaphors and Nomads*, PhD. Dissertation, Charles University at Muncie Indiana.
12. Choijin, Z. 2015. *Emotion Metaphors in English and Mongolian: With Special Reference to Anger, Love, Happiness and Sadness*, GNU, Korea
12. COCA корпус

### Ашигласан толь бичиг

1. Д. Алтангэрэл, . 2001. Орчин цагийн монгол англи хэлний толь, Улаанбаатар хот
2. Ч. Арьяасүрэн, Х. Нямбуу, 1990. Монгол соёлын тайлбар толь, Улаанбаатар хот
3. Oxford Monsudar English Mongolian Dictionary, 2006. *The World's Leading English Mongolian Dictionary*, Oxford University Press.
4. Oxford Advanced Learner's Dictionary of Current English, 1996. Oxford University Press.

### Ашигласан уран зохиол, дуу

1. Монголын нууц товчоо. 2011. Улаанбаатар, Мөнхийн үсэг
2. Б. Сарантуяа, 2011, Сорхугтани, Улаанбаатар, Адмон.
3. Д.Нацагдорж, 1932, Цагаан сар ба хар нулимс, Улаанбаатар хот

### Эх сурвалжийн товчилсон үг:

Монголын нууц товчоо -МНТ, 2011  
Оxford англи монгол толь бичиг-ОАМТБ,2006  
Орчин цагийн монгол англи толь бичиг-ОЦМАТБ, 2001  
Монгол соёлын тайлбар толь бичиг-МСТБ,1990  
Интернет мэдээ мэдээлэл-ИМ  
Харилцан яриа -ХЯ

### Technical metaphor expression

Badamdorj Enkhzul<sup>1</sup>

*Badamdorj Enkhzul<sup>1</sup>, Mongolian University of Science and Technology, School of Foreign languages, e\_zulaaa@yahoo.com*

**Хураангуй:** Орчин үеийн нийгэмд хүний мэдлэгийг илэрхийлэх, тайлбарлахад гол тулгуур болсон хэлний үгийн санг бүрдүүлэгч нэр томъёог цаг ямагт боловсронгуй болгож, зөв оноож байх нь чухал тул энэхүү судалгааны үндэслэл болголоо. Мэргэжлийн хүрээнд нэр томъёог тодорхой нэг утгатай байх нь мэргэжлийн хүмүүсийн харилцаанд нэр томъёог янз бүрээр ойлгон хүлээж авах, буруу мэдээлэл авахаас сэргийлнэ. Үйлдвэрлэл, техникийн хувьд элдэв механизм, тэдгээрийн эд анги, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, эд материал, бодис, элдэв мэргэжлийн нэр зэрэг нь шинжлэх ухааны мэдлэгийн онолыг бодвол өөрчлөгдөх нь бага бөгөөд утгын хувьд хүрээ нь тодорхой байдаг тул ийм салбарын нэр томъёо харьцангуй тогтонги олон салаа утгагүй байдаг гэж үздэг. Орчин үед техник, технологийн үг хэллэг нь голдуу англи хэлээр дамжин орж ирж салбар бүрт шинэ мэдээлэл, нэр томъёог авах болсон ба уг нэр томъёог агуулгын талаар яв цав нийцсэн нэр томъёо болгон тогтоох нь чухал. Мөн хэл шинжлэлийн чиг хандлагаар нэр томъёог боловсруулахад техникийг ашиглан, улмаар машинд таниулж цахим сан үүсгэхдээ олон салаа утгагүй нэг утгыг ирэлхийлсэн нэг нэр томъёо тогтоох нь чухал бөгөөд үүнд хэл шинжлэлийн шаардлага болох товч тодорхой, олон хувилбаргүй, ойлгомжтой, тогтолцоотой байх хэм хэмжээт байх нь чухал зэргээрээ энэхүү судалгааны ажилын ач холбогдол оршино.

**Түлхүүр үг:** нэр томъёо, хэл шинжлэл, техник, технологи, хэм хэмжээ

#### 1. Оршил

Метафор нь эрт эдүгээгийн өрнө дорнын утга уянгын зохиол бүтээлд түгээмэл хэрэглэгдсээр ирсэн байна. Метафорыг үзэх үзлийн түүхэн хөгжлийн тухай авч үзэхэд, хамгийн анх анзаарч, түүний ач холбогдолын тухай онцгойлон дурьдсан хүн бол Аристотель юм. Тэрээр “Туурвил зүй” (МЭӨ 336-332-р оны хооронд бичсэн) бүтээлдээ “... метафор гэдэг нь утгыг өөрчилсөн үгийг төрлөөс хэлбэр рүү шилжүүлэх явдал юм” хэмээн тодорхойлсон байдаг. Мөн Ромын улс төрч, уран илтгэгч, философич, эрдэмтэн М.Цицерон “Зүйрлэл нь ярианы илэрхийлэлийг сайжруулж, түүнд гүнзгий ерөнхий утгыг нэмнэ” хэмээжээ. Дюмарсайс (1730) -“Метафор нь цэвэр харьцуулалтаас өөр юу ч биш”, Оросын судлаач Ю.С.Степанов - “ертөнцийн хөрөг” хэмээн тодорхойлсон бол Америкийн эрдэмтэн Ортони (1996) ... метафор нь уг чанартаа хэлний бус ойлголт, метафорыг илтгэж байгаа хэл нь концептуаль метафорын гадаад илрэл юм гэжээ. Г.Кулиев: Метафор нь хэлний гүйцэтгэдэг бүхий л үүргийг гүйцэтгэнэ (нэрлэх, чимэглэх, урнаар илэрхийлэх, танин мэдэхүй, заах гэх мэт.) 1980 онд Ж.Лакофф, М.Жонсон нар концептуаль метафорын онолыг гаргаж тавьсан бөгөөд “метафорын тогтолцоо нь когнитив механизм мөн,

хүний сэтгэхүйн явц нь олонх тохиолдолд метафорлог” шинжтэй байдаг гэжээ. Метафорын тухай маш нарийн судалж тодорхойлсон судлаач бол манай нэрт хэл шинжээч Ш.Лувсанвандан билээ. Цаашлаад хэл шинжээч Ж.Баянсан хийсвэрлэлийг “Хэл соёлын харилцан хамаарлын мөн чанарыг таньж мэдэх гол арга зарчим ” гэж үзсэн байдаг. Метафорын тухай дээрх олон орны эрдэмтэдийн үзэл баримтлалуудаас дүгнэхэд метафорын судалгааны эхэн үеүдэд метафорыг зөвхөн уран зохиол яруу найрагт үгийн утга нэмэх чимэглэх төдий хэлний үүрэг гүйцэтгэдэг хэмээн ойлголттой байсан бол орчин үеийн когнитив хэлшинжлэл метафор нь дүрийг тодотгогч, хэл яриаг чимэглэгч утга бус харин сэтгэхүйн үндсэн үйл ажиллагаа, ертөнцийг танин мэдэх, тайлбарлах, бүтэцлэх арга үзэж байна. [3] Метафор нь хэл болон соёл сэтгэлгээний хөгжилд оролцож байдаг. Тийм ч учир дэлхийн олон улс үндэстэн метафор үүсгэх, загварчлах, хэл яриандаа хэрэглэх туршлагаараа өөр өөр. Монгол хэлэнд мал, амьтантай холбоотойгоор үүссэн хэвшмэл хэллэг, метафор буюу зүйрлэл үлэмж олон байдаг. Хэл-сэтгэхүйн холбоонд түшиглэн хүн, нийгэм, байгалийн юм, үзэгдлийг танин мэдэх, ойлгох, түүнийгээ мэдээлэх, дамжуулах арга нь улс үндэстэн бүрт харилцан адилгүй байдаг.

Метафор нь нүүдэлчин монголчуудын эрхэлдэг аж ахуй, амьдралын хэв маяг, туршлага, утга соёлтой нь салшгүй холбогдож, улмаар хүн-нийгэм- байгаль гэсэн гурвалыг холбон өвөрмөц сонин мэдээллийг зөөж тээж иржээ. Монголчууд үгийн утга шилжүүлэх, далд утгатай шууд бус нэрлэлтийг үүсгэх, зүйрлэл, төлөөлүүлэл, хүншүүллийг хэрэглэдэг. Тухайлбал: Дөргүй бух шиг, зуун ямаанд жаран ухна, тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй гэх мэт мал, амьтан эх үүсвэртэй монгол метафоруудыг ажиглан шинжвээс, орон зай, цаг хугацааны хувьд бие хүнээс гэр бүлд, улмаар төр улсын ажилд хүртэл хамаарч, чиглэсэн онцлогтой байна. Өнөө үед метафорыг зөвхөн уран зохиолын илэрхийлэл гэж үздэг үзэл үгүй болжээ.

Лакофын онолоор метафор (герег хэлний *metaphora* буюу “шилжүүлэлт” гэсэн үгнээс гаралтай) гэдэг ойлгоцыг хэл шинжлэл, найруулга зүйн судалгааны хүрээнд бидний ойлгож ярьж ирсэн уламжлалт ойлгоцоос ихээхэн өөрөөр авч үзсэн. Үүнийг сийрүүлбэл:

- Метафорын мөн чанар нь нэг юмны гол шинжийг өөр зүйлд оноож ойлгож хүлээж авахад оршино. Метафор нь зөвхөн хэлэнд буюу өөрөөр хэлбэл үгэнд хамаарах төдий зүйл биш. Хүний сэтгэхүйн үйл явц нэлэнхүйдээ метафорчлагдсан байдаг. (1, pp. 5-6).
- ...бидний туршлага, үйл ажиллагааны дийлэнх нь уг чанартаа метафорчлагдсан, хүний ойлголтын тогтолцооны ихэнх нь метафорын тусламжтай бүтэцчилэгдсэн. (1, p. 147).
- ...метафор төсөө (*similarity*) үүсгэдэг ба тэр нь туршлагын өөр өөр ангилал бүхий зүйлсийн хооронд байдаг ерийн төсөөнөөс нэлээн хол ойлголт юм. (1, pp. 147-152).
- Метафор бол хүн юмыг ойлгоход амин чухал зүйл, та бидний амьдралд шинэ бодит байдал, шинэ утга үүсэх нэг механизм (*mechanism for creating new meaning and new realities in our lives*) гэж бид үзнэ. (1, p. 195-196)
- Метафорт бидний туршлагын зарим талыг товойлгон тодруулж (*to highlight*), хооронд нь уялдуулдаг (*to make coherent*) тийм үр дагаврууд байна. Зарим метафорын хувьд бидний туршлагын чухамхүү талуудыг товойлгон тодруулж, уялдаа дараалалд оруулдаг нь илэрхийллийн цорын ганц арга ч байж мэднэ. Мөн метафор та бидний хувьд бодит байдлыг (*realities*) бүтээж,
- онцгойлон хэлэхэд нийгмийн бодит байдлыг (*social realities*) бүтээж болно. Метафор бас та биднийг ирээдүйн үйл рүү нь чиглүүлэгч болж чадна. (1, pp. 156-158).
- ... уг чанартаа метафор ухагдахуунт (*conceptual*) шинжтэй. Метафор нь юмыг ойлгох чухал

- хэрэгсэл, нийгэм, улс төрийн бодит байдлыг бүрэлдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг (they play a
- central role in the construction of social and political reality). Эндээс дүгнэхэд эрпэмтэн Лакофф метафорийг уран яруу зүйрлэлийн үүрэгтэйгээс гадна хүний оюун ухаан, уураг тархитай салшгүй холбоотойг энэхүү бүтээлээрээ харуулжээ. [1]

Орчин үеийн амьдрал хурдацтай хөгжиж, бидэнд шинэ санааг байнга авчирч, бидний амьдралын хэв маяг төдийгүй бидний хэлэнд нөлөөлдөг шинэ бүтээлүүд, төхөөрөмжүүд техникийн харилцаа холбоо нь зарим техникийн үйл явц, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг, хэрэглээний талаархи мэдлэг, ойлголтыг шаарддаг.

Метафорыг зөвхөн хэл ярианд хэрэглэхээс гадна бидний сэтгэлгээнд ашигладаг. Бидний бодож, үйлдэж байгаа ойлголтын хувьд бидний ердийн үзэл баримтлалын систем нь тийм юм үндсэндээ зүйрлэл шинж чанартай. Мефорик сэтгэлгээ бол хүмүүсийн хоорондын болон бусадтай харилцахад байнга ашиглагддаг сэтгэлгээ ертөнцийг ойлгох. Улс төр, эдийн засаг, технологийн өөрчлөлтүүд нь хүмүүсийг ашиглахад хүргэсэн үзэл бодлоо илэрхийлэх хүчирхэг хэл шинжлэлийн хэрэгсэл, үзэл баримтлалын төрөл зүйрлэл нь энэ зорилгод хүрэх хэрэгсэл гэж үздэг. Метафор нь техникийн нэр томъёо үүсгэх хэрэгсэл юм. Шинжлэх ухааны хэл нь нарийн, хатуу бөгөөд тодорхойгүй мөн сэтгэл хөдлөлийг илэрхийлдэггүй. Тиймээс шинжлэх ухааны бүхийл салбарт метафор илэрч байдаг. Үүнд:

Нийгмийн сэтгэл зүйд хамаарах нь: *хаврын синдром, дээдэс, буу халах, будаа болох (болгох), хуцах*

Улс төрд хамаарах нь: *албан тушаалын дон, улс төрийн хожоо, нэр сэвтэх (баасдах), ногоон гэрлээр*

Эдийн засагт хамаарах нь: *мөнгө босгох, төсөвт тусгах, нүүрсээр амьсгалах, баялгийнхаа хэргийг гаргах,*

Хуульд хамаарах нь: *цоорхой хууль, эрх зүйн орчин, хөөн хэлэлцэх хугацаа, хуулийн цоорхойг ашиглах,*

Бизнест хамаарах нь: *шан татах, хоолойн дээр хутга тавих, багалзуурдах, онхолдуулах, сөхрөх, томрох,*

Нийгмийн амьдралын олон салбар, янз бүрийн үзэгдлийг суурь мэдээлэлийг метафор өөртөө шингээжээ. Үүгээр нийгмийн бодит байдалд үүссэн түүхэн нөхцөл байдлын явцыг ямар нэг байдлаар тодорхойлж болох талтай байна. Үндэсний хэлний түүхэнд харь үг нутагших, тэдгээр нь их багаасаа шалтгаалан үнтэстний хэл, сэтгэхүйд эерэг сөрөг ямар нэг байдлаар нөлөөлөх бол түгээмэл үзэгдэл. Тэгвэл метафорчлах сэтгэлгээ бас харь сэтгэлгээнээс орж ирж нутагшдаг байна. Ийнхүү нутагшихдаа эх концептээ хадгалдаг ч, эс хадгалдаг ч бололтой юм. Мэдээж үүнд цаг хугацааны болон ахуй, соёл, сэтгэл зүйн хүчин зүйл голлох нөлөөтэй. Бас ийм үйл явцын уг сурвалжийг соёл хоорондын харилцаанаас хайх хэрэгтэй байх. Монголын түүхийн нэг хэсэг зурвас дорнын соёлтой, нөгөө хэсэг зурвас оросын соёлтой холбоотой байсан, одоо гуравдахь хэсэг түүхэн зурвас барууны соёлтой илүүтэй их холбоотой байгааг харгалзвал тэдгээр тус бүрээс метафорчлах сэтгэлгээ (үг илэрхийлэл нь орчуулгатай орчуулгагүй) шилжин суурьшсан баримт олныг олж болно. Жишээ нь өнөө цагт идэвхтэй хэрэглээнд байгаа заримаас нь дурьдвал: *загалмайлсан эцэг (God father), хөгжлийн түлхүүр (development code), түлхүүр тоглогч (key player), уур амьсгал (climate), хөгжлийн өдөөгч (growth catalyst), алтан боломж (golden chance), генсек, боевик, спикер (speaker), рейтинг (rating), санхүүгийн ертөнц (financial world), матрын нулимс унагах (to shed crocodile tears), нэгдсэн вант улс (united kingdom), чээнж (change), улс төрийн шоу, шоудах, монголжсон концепт болсон байна.[5] Монгол судлаачид сүүлийн*

жилүүдэд концептуаль метафорыг судлан, когнитив хэл шинжлэлийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж байна. Гэвч бид нэлээд дорвитой дэлхийд танигдсан когнитив хэл шинжлэлийн судалгааны ажил хийх шаардлагатай юм. Монголч эрдэмтэн А. Оберползерова (2006) угсаатан зүйн судалгаа хийн, монгол хэл, соёл, харилцааны чиглэлээр судалгаа хийн, монгол түмний соёл, хүмүүсийн хэл ярианы онцлог, зэргийг өөрийн бүтээлдээ нэлээд дэлгэрэнгүй тусган харуулсан байдаг. Мөн судлаач Б. Төмөрхуяг (2011), улс төрийн дискурс дэх концептуаль метафорыг когнитив хэл шинжлэлийн үүднээс судалсан нь тус чиглэлийн судлаачдад хүртээмжтэй ажил болсон юм.[4]

## 2. Судалгааны арга аргачилал

Концептуаль метафорын жишээ баримтыг тайлбар толь бичиг, эрдэм шинжилгээний бүтээлээс түүвэрлэн авсан. Стин, Праглежаз МIP /1999/ нарын метафор илрүүлэх аргыг ашигласан. Энэ арга нь практикт тулгуурласан, системтэй арга барил юм. МIP арга дараах үе шатаар метафор илрүүлдэг (Steen 1999).

1. Төрөл бүрийн эх текст уншиж тухайн хэлний метафорыг олж түүвэрлэх
2. Дискурс дэх метафорт анализ хийн сэтгэл хөдлөл заасан зүйрлэл мөн эсэхийг тогтоох
3. Тухайн дискурс дэх утга нь үгийн үндсэн утгаас ялгаатай эсэхийг шалгах
4. Үгийн контекстийн утга үндсэн утгын хоорондын хамаарал болон эх үүсвэр хүрээ, бай хүрээний хамаарал, төсөөтэй шинжийг тогтоох шалгах
5. Тухайн метафорийг тэмдэглэх бүртгэх

Доуглэс Батлер (1986) онд техникийн салбарын метафор нь дөрвөн гол үүргээр хэрэглэгддэг гэж тодорхойлсон. Үүнд: техникийн метафор нь 1) хэсгүүд болон эд анги болон орон зайг нэрлэх; 2) үйлдэл, цаг хугацааг онцлон тэмдэглэх; 3) цаг хугацаа, орон зайг бус харин шинж чанарыг илэрхийлэх, 4) цаг хугацаа, орон зайг хоёуланг нь онцолж загвар модел гаргах гэж тодорхойлсон байна.

## 3. Судалгааны үр дүн

Бид энэхүү судалгааны ажлаар техник технологийн салбарын метафор хэрхэн хэрэглэгдэж байгааг судлан түүвэрлэж ажиглалт хийлээ. Хүснэгт 1- метафор загварыг ашиглан техник технологийн метафорын загварыг харуулж байна. Эдгээр жишээнээс харахад техник технологийн дискурс дэх метафор нь маш өвөрмөц байдлаар илэрч байгаа нь харагдаж байна. “*Elevation head*”, “*Insert jaw*” гэсэн энэ зүйрлэлүүд нь монгол хэлнээ *шагайлтын хаялбар, орлуулах уруул* гэж орчуулагдсан байна. Хүний *толгой “head”*, эрүү “*jaw*” хэмээх эрхтний үүрэг нь тухайн техникийн эд ангийн үүрэгтэй ижил үүрэгтэй тул ийнхүү нэрлэсэн байна. Метафор нь тухайн эх ба бай хүрээний хоорондох хамаарлын хүрээнд ойлгогдох ба тухайн зүйлийн ижил төсөөтэй шинж дээр тулгуурлан адилтган зүйрлэдэг. Метафор утга шилжүүлэлтийг харуулахдаа амьд бус зүйлийн шинжийг амьд бус зүйлд шилжүүлсэн байдлыг *Wrench jaws - эрэгний түлхүүрийн уруул хэмээн орчуулсан байна. Англи хэлний jaw буюу – хүний эрүү хэмээх амьгүй зүйлийг Wrench буюу эрэгний түлхүүр гэсэн амьгүй зүйл рүү шилжүүлснийг* гэх мэтээр харуулжээ.

Хүснэгт 1

| Метафор илэрхийлэл | Англи тайлбар   | Монгол орчуулга             | Салбар           |
|--------------------|---|-----------------------------|------------------|
| Elevation head     | The elevation head ( $h_z$ ) of any point is its height above the datum line.           | Шагайлтын хаялбар           | Уул уурхай       |
| Insert jaw         | Elongates the look of the jaw by placing an implant either under the ear or by the chin | Орлуулах уруул              | Уул уурхай       |
| Gripping jaw       | Placing an implant either under the ear or by the chin                                  | Хавчих уруул                | Уул уурхай       |
| Wrench jaws        | A tool with jaws used for holding, turning or twisting. ...                             | Эрэгний түлхүүрийн уруул    | Уул уурхай       |
| Switch arm         | A conducting path in an electrical circuit  | Шилжүүлэх залгуурын гулсавч | Уул уурхай       |
| Contact arm        | a conducting arm that rotates   | Холбогч гар                 | Уул уурхай       |
| Face of crystal    | side of crystal   | Кристалын талст             | Уул уурхай       |
| Bed of brick       | Bricks' bottom  | Тоосгоны доод тал           | Барилгын салбарт |
| Gripping jaw       | Gripping month  | Хамагч                      | Уул уурхай       |
| Pipe elbow         | An elbow is installed between two lengths of pipe                                       | Дамжуулах хоолойн өвдгөвч   | Эрчим хүч        |

2017 онд Шармини Абдулах техникийн салбарын метафорыг орчуулгын талаас нь судалсан. Жишээ нь: “Chemical engineers process **raw** materials.” гэсэн өгүүлбэрт байгаа метафорыг авч үзье. Энэхүү өгүүлбэрийн “Raw” гэсэн метафор нь “*uncooked, as articles of food*” түүхий болгоогүй хоол хүнс, чанаж боловсруулаагүй хоол хүнс гэсэн утга илэрхийлдэг. Харин энэ өгүүлбэрт “*raw materials*” буюу утга шилжин хэрэглэгдэж байна. Мөн “Engineering technologists **bridge** the gap between engineering and management” (Sharmini Abdullah 2017: 128). Жишээ нь “bridge” гэсэн үгийн үндсэн утга нь “a structure spanning and providing passage over a river, chasm, road, or the like” Гол, ангал, зам гэх мэт зүйлийг дайран өнгөрч, дамжин өнгөрөх байгууламж” гэсэн утгатай. Гэтэл энэ өгүүлбэрт үндсэн утгаар биш *a connecting, transitional, or intermediate route or phase between two adjacent elements, activities, conditions, or the like*” холбож өгөх гэсэн” утгаар орж байна. Дээр хоёр жишээг авч үзвэл энэ хоёр зүйлийн ижил төсөөтэй шинж дээр тулгуурлан хийсвэр ухагдахууныг бай хүрээнд илэрхийлж байна.

Англи, монгол ард түмэн танин мэдэхүй, соёл сэтгэлгээний онцлогоос үүдэн хүний зан чанар, байдлын таньж мэдэхдээ өөр өөрийн онцлогтой байгаа нь метафорын орчуулгаас харагдаж байгаа юм.

Метафор утга шилжүүлэлтийг шилжих чиглэлээр нь дараах байдлаар тоймлон үзүүлж болох юм. Амьд бус зүйлийн шинжийг амьд бус зүйлд шилжүүлэх (техникийн салбарт)

Амьд зүйлийн шинжийг өөр амьд бус зүйлд шилжүүлэх

Хүснэгт 2-оос метафор утга шилжүүлэлтийг харуулахдаа амьд бус зүйлийн шинжийг амьд бус зүйлд шилжүүлсэн байдлыг “*bed of brick- тоосгоны доод тал*”, “*hot bus-цахилгаан дамжуулж буй утас*” гэх мэтээр харуулжээ.

## Хүснэгт 2

| Метафор илэрхийлэл | Англи тайлбар                                     | Монгол орчуулга           | Салбар           |
|--------------------|---|---------------------------|------------------|
| Face of crystal    | side of crystal                                   | Кристалын талст           | Уул уурхай       |
| Bed of brick       | Bricks' bottom                                    | Тоосгоны доод тал         | Барилгын салбарт |
| Hot bus            | Energized with power                              | Цахилгаан дамжиж буй утас | Эрчим хүчний     |
| Gripping jaw       | Gripping mouth                                    | Хамагч                    | Уул уурхай       |
| Pipe elbow         | An elbow is installed between two lengths of pipe | Дамжуулах хоолойн өвдгөвч | Эрчим хүч        |

Энэхүү жишээнээс харахад шинжлэх ухааны төрөл бүрийн салбарт ялангуяа техник технологийн салбар нь маш өвөрмөц метафороор баялаг бөгөөд энэ нь тухайн салбарын хувьд хэвшсэн байна. Судалгаанаас үзэхэд техник технологийн нэр томъёонд илэрч буй метафор нь ихэвчлэн утга шилжих аргаар үүсэж байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь “*pipe elbow – дамжуулах хоолойн өвдгөвч*” *elbow буюу тохой* гэсэн хүний бие эрхтэн заасан нэр үг нь механизмын жийргэвчийн үүргээр хэрэглэгдэж байна. “*Bed of brick – тоосгоны доод тал*” хүний унтдаг ор - *Bed* гэсэн нэр үг утга шилжиж юмны доод талыг зааж байгаа метафороор хэрэглэгдэж байна. Хүний бие эрхтний нэрийн утга шилжсэн утгат үгийн сангийн бүрэлдэхүүний хувьд утга шилжүүлж нэр томъёо үүсэхэд оролцсон үгийг хүний бие эрхтний нэрийн утга шилжсэн метафор.

## Хүснэгт 3

| Үг     | Шууд утга  | Шилжсэн утга  | Жишээ                          |
|--------|--|---|--------------------------------|
| Нүд    | Хүн амьтны цогц эрхтэн, махбод   | Цэвэрлэгээ хийх зориулалт бүхий нүх<br>Халуун үе                    | Cleaning eye(hole)<br>Fire bed |
| Нүүр   | Хүний толгой урд хэсэг   | Кристалын талс  | Face of a crystal              |
| Толгой | Дээд хэсэгт орших зүйл-Хүн, хүн амьтны биеийн эрүү гавал хоёроос бүтэх хүзүүн дээр тогтох дээд хэсгийн гол эрхтний нэг | Тооцоот түрэлт<br>Даралтын хэлбэлзэл, даралт уналт                  | Design head<br>Fall head       |
| Хоолой | Хүзүүний өвөр хэсэг, юм залгих мөр, амьсгалын мөрийн зарим хэсэг   | Шатаагуурын түлшний сав   | Burner throat                  |
| Ам     | Хүн, амьтны уруулын завсархи сүв   | Hand triggering-Гар асаалт  |                                |
| Хэл    | Хүн амьтны хэл   | Ачааны бахин базуур Хөшгүүргэн баривч                               | Lifting tongs<br>Lever tongs   |
| Хөл    | Хүн, амьтны хөл  | Зуухны галын хотол Мухар салаа                                      | Boiler water leg<br>Dead leg   |
| Тохой  | Гар бугалгыг холбогч   | Шугам хоолойн булан   | Duct elbow                     |
| Шүд    | Хүн, амьтны амны дотор талд байх олон хазуур яс  | Хөрөөний шүд Хөрөөний арзгар<br>Toothed wheel,gearing-Шүдэн (араат) | Saw teeth<br>Gullet tooth      |

Хүснэгт 4 өөр бусад эд зүйлсээр утга шилжүүлж нэр томъёо үүсэхэд оролцсон метафоруудыг үзүүлээ.

Хүснэгт 4

| Үг     | Шууд утга                | Шилжсэн утга  | Жишээ                                     |
|--------|--------------------------|---|---|
| тогоо  | Гал тогооны хэрэгсэл     | Хуралдварын хоовон                                  | Sintering pan                             |
| ор     | Хүний унтдаг ор          | Буцлах давхарга Шүүх үе<br>Хөлдөөх аппаратын тавцан | Boiling bed<br>Filter bed<br>Freezing bed |
| Дун    | Усны амьтан              | Камерын гадна бүрхүүл кабель                        | Cabinet shell                             |
| Ханцуй | Хүний хувцасны нэг хэсэг | Брезентэн оруулга                                   | Canvas shelve                             |
| Халаас | Хүний хувцасны нэг хэсэг | Самбарын/панелийн үүр                               | Wall pocket                               |
|        |                          | Эсэргүүлцлийн үүр                                   | Pocket of resistance                      |
| Хорхой | амьтан                   | Хорхой араат харьцал                                | Worm gearing                              |

#### 4. Дүгнэлт

Метафорын өвөрмөц шинж чанар нь утга уран зохиол, яруу найрагт үгийн утга нэмэх, үгийг чимэглэх зэрэг үүрэгтэй ба түүгээр ч зогсохгүй шинжлэх ухааны бүхий л салбарын нэр томъёонд илэрч мөн тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Шинжлэх ухааны салбаруудад метафор хэрхэн илэрч байгаа мөн үүгээрээ тухайн салбарт гарч байгаа ололт амжилт, доголдож буй асуудлуудыг метафорын ачаар хэрхэн хүчтэй илэрхийлж нийгэм олон нийтэд нөлөөлж болох нь тодорхой ажиглагдаж байна. Судалгааны явцад техник технологийн салбарын нэр томъёонд метафор хэрхэн илэрч байгааг судалсан судалгаа дутмаг байгаа нь харагдаж байна. Судалгааны ажлын үр дүнд англи, монгол хэлний техник технологийн жишээн дээр судлан, хоёр хэлний ижил төстэй болон ялгаатай талыг когнитив хэл шинжлэлийн утга зүйн хүрээнд судалж, нүүдэлчин түмний хэл соёл, түүх сэтгэлгээний онцлогийг, сууршмал соёлт ард түмний хэл соёлтой харьцууласнаар, танихуйн хэл шинжлэлийн хөгжилд тодорхой хувь нэмэр болно гэж найдаж байна. Хоёр хэлний хувьд ижил төсөөтэй универсаль метафор байгаа хэдий ч, мөн тухайн хэл соёлын онцлогийг харуулсан маш өвөрмөц зүйрлэсэн хэллэг болон концепт байна. Иймд энэхүү судалгаагаар техник технологийн салбарт илэрч буй метафорыг утга зүйн үүднээс судлаж, техникийн чиглэлээр сурч буй оюутнууд тухайн чиглэлээр ажиллаж буй хүмүүст метафорын илэрхийлэлийг зөв таниж, хэрэглэх зэрэг үйл ажилд тодорхой хувь нэмэр оруулах ач холбогдолтой болно.

#### Ашигласан эх

- [1] Lakoff, G. & Johnson, M. (2003) *Metaphors we live by*. The University of Chicago Press.
- [2] Lakoff, G. (1993) *The contemporary theory of metaphor // Metaphor and thought*. Ed. by Ortony A. Cambridge University Press.
- [3] Баянсан, Ж. (2016) Хэлний соёл судлалын үндсэн асуудал. [www.greenbough.mn/article.php?content=77](http://www.greenbough.mn/article.php?content=77). УБ.
- [4] Золзаяа, Ч. (2014) ЭШБичиг, “Emotion Metaphors in English and Mongolian: With Special Reference to Anger, Love, Happiness and Sadness” (x257) УБ
- [5] Марсар, Ц. (2013) АСТА MONGOLICA. МУИС-ийн ЭШБичиг, Цаг үе ба метафорчлах сэтгэлгээ, (x123-129). УБ

## **The effects of Customer satisfaction on the reuse intention in the Mongolian postal delivery service: Domestic & global service as moderation role**

Battumur Gerelmaa<sup>1</sup>, Gantumur Khongorzul<sup>2</sup>, Wonjong Kim<sup>3</sup>  
<sup>1,2,3</sup> *Department of Industrial Management, Gyeongsang National University,*  
*Corresponding Author: Wonjong Kim*

**Abstract:** The delivery service is a fast-growing business under the pressure of e-commerce. This paper determined Delone and McLean's Information system success model to measure the effect of system quality, e-trust on the reuse intention of the website-based delivery service in Mongolia. Data were collected by surveying 150 customers who had experience, using SPSS 21.0 and AMOS 20.0 statistic package program. The statistical results supported all four proposed hypotheses. The study confirmed the electronic service quality of system quality were significant predictors of e-trust.

**Keywords:** System quality, service quality, e-trust, e-reuse-intention

### **1. Introduction**

Postal services play a fundamental position in every country, for the reason that of the double impact they make as of public and economic position of view. The postal business is shifting daily in the situation of the fourth industrial revolution, especially in developed countries [1]. Enterprises have been undergoing a basic change of the Fourth Industrial Revolution, and the alteration is determined by the acceptance and growth of innovative know-how such as big statistics or artificial intelligence. In developing countries, some successful postal economic models have developed towards greater outreach, and new opportunities [2]. Over the last decades, the postal industry has changed from a public and traditional organization to a combination of community and personal operators. Public companies are attempting to transform their representation, which has been characterized by a requirement of e-SQ. This position has lead to a innovative bloodthirsty condition in the postal services sector in which operators use these technologies to advance their services and create new ones in response to customers' need [3]. Reform and modernization of the postal sector, based on postal market development, sector trends and rapid technological development. Digital transformation has become a strategic priority for Posts that want to remain relevant. Postal operators around the world are implementing new technologies to adapt to customer demand for electronic services (e-services). Other issues include the emergence of new confidential competitors as a result of liberalisation and repair modernization in this division [4], especially customer satisfaction in Mongolia's postal sector [5] Reform and modernization of the postal sector, based on postal market development, sector trends and rapid technological development. However, no studies have specifically examined the dimensions of e-SQ and its consequences in the postal services sector. The relationships among the three important elements in the success of e-services, e-SQ, satisfaction, and loyalty, are not yet clear. This work contributes to the e-services literature by

clarifying the relationships among e-service quality, e-trust, and reuse-intention. To the best of our knowledge, an examination of this specific subject has not yet been undertaken, particularly in the context of e-services in the postal services sector. This study proposes and validates a scale for measuring e-SQ, online trust, and online reuse-intention. A model of the relationships among the three constructs is designed and tested, particularly with regard to whether e-SQ in the postal services sector positively and directly affects online trust.

[Table 1] Postal economics: Industrialized, low income countries

| Industrialized countries                   | Low-income countries                  |
|--|---------------------------------------|
| High letter-post volume                    | Low levels of letter-post volume      |
| B2C- driven traffic                        | B2C may not be a driver of traffic    |
| High salaries and heavy automation         | Lower salaries and limited automation |
| Large economies of scale for home delivery | Often no home delivery                |

## 2. Theoretical Background

### 2.1 E-Service Quality and E-Trust

Service quality is defined by Parasuraman, Zeithaml, and Berry [6] as a customer’s decision about an entity’s general. Service value leads to potential intended raise, such as improvement in user truthfulness and enhance in a firm’s operations, competence and productivity [7]. Accordingly, it is extremely important to appreciate service quality within the e-commerce domain, and what customers worth in their web-based dealings. One of the primary definitions of e-service quality is by Zeithaml, Parasuraman [8] “the extent that a website facilitates efficient and effective shopping, purchasing, and delivery of product and services.” Previous research has focused on the different dimensions of e-service quality, E service quality-technical adequacy, content quality, information quality, efficiency, E-recovery service-responsiveness, compensation, E-satisfaction, E-trust, E-service quality is clearly of equal relevance and importance in the private and public sectors.

[Table 2] Review of relationship among Interactivity, Accessibility and Customization

| Constructs | Quality       | (Santika, 2020) | (Shankar, 2020) | (Hendrayati, 2020) | (Rita, 2019) | (Salameh, 2015) | (Çelik, 2011) | (Jung, 2010) | (Carlson, 2010) | (Gorla, 2010) | (Kuo, 2009) | Smith, T.J. (2008). | (Yang, 2005) | (Kuo, 2005) | (Klopping, 2004) | (Ribbink, 2004) | (Cox, 2002) |
|------------|---------------|-----------------|-----------------|--------------------|--------------|-----------------|---------------|--------------|-----------------|---------------|-------------|---------------------|--------------|-------------|------------------|-----------------|-------------|
|            |               | E-Service       | Interactivity   |                    |              |                 |               |              |                 |               |             |                     |              |             |                  |                 |             |
|            | Accessibility |                 |                 |                    |              |                 |               |              |                 |               |             |                     |              |             |                  |                 |             |
|            | Customization |                 |                 |                    |              |                 |               |              |                 |               |             |                     |              |             |                  |                 |             |

H1-1: Customization should be relatively significant to e-trust.

H1-2: Accessibility should be relatively significant on e-trust

H1-3: Interactiony will be relatively significant on e-trust

## 2.4 E-Trust and E-Reuse-intent

Examining the literature to date on the issue of e-service quality it is evident that there are three aspects

| Constructs       | Quality | (Santika, 2020) | (Shankar, 2020) | (Hendrayati, 2020) | (Rita, 2019) | (Salameh, 2015) | (Çelik, 2011) | (Jung, 2010) | (Carlson, 2010) | (Gorla, 2010) | (Kuo, 2009) | Smith, T.J. (2008). | (Yang, 2005) | (Kuo, 2005) | (Klopping, 2004) |
|------------------|---------|-----------------|-----------------|--------------------|--------------|-----------------|---------------|--------------|-----------------|---------------|-------------|---------------------|--------------|-------------|------------------|
| E-Customer Trust |         |                 |                 |                    |              |                 |               |              |                 |               |             |                     |              |             |                  |
| Reuse Intention  |         |                 |                 |                    |              |                 |               |              |                 |               |             |                     |              |             |                  |

to e-service quality: (1) user-focused; (2) user satisfaction; and (3) outcomes. The assumptions underlying these three measures are: . profit orientation; . homogeneous consumer groups; . definable tasks; and measurable outcomes [9].

The E-SQ is highly concerned due to it highly related with success or failure of internet based company such as delivery service. Website quality or E-SQ plays a key role in determining the web experience of the customers [10].


[Table 3] Review of relationship among E-Customer Trust and Reuse-intention

H3: E-Trust should be relatively significant on the reuse-intention

## 3. Research Methodology


### 3.1 Research Model and Measures

The first DeLone & McLean Success Model provided an inclusive structure for measuring information system performance. The new, updated model is based on the empirical and theoretical additions of investigators who have checked or argued the creative model. The updated model shown in Figure 1 consists of six interrelated measures of information system success. Including that system quality, information quality, service quality, use, user satisfaction, net benefits.



[Figure 1] Conceptual model

The primary improvements to the original model include (a) the addition of service quality to reflect the importance of service and support in successful IS systems, and (b) the collapsing of individual impacts and organizational impacts into a more parsimonious net benefits construct [11]



[Figure 2] Research model

Measures in this study were supplemented and modified based on previous researches. First, for this measurement items for characteristics of service quality have been adopted from Parasuraman et. al.[12] Shi et. al.[13], and each component has been adapted to prepared the purpose of the study. Second, measures for e trust, reuse intention and loyalty have been hired from Isa et. al.[14]. All structures are measured on a seven-point Likert. Several 188 surveys were used to collect 150 respondents were used for final analysis. Expect 38 questionnaires with irrelevant data and missing values, using SPSS 21.0 and AMOS 20.0 statistic package program. [Table 4] shows the measurement items and related sources.

[Table 4] Measurement scales.

| Construct.              | Items  |
|-------------------------|--|
| Customization<br>(CU)   | CT1. I feel that my personal needs have been met when using this site.                   |
|                         | CT2.This site provides me with information according to my preferences.                  |
|                         | CT3. I feel that site has the same norms and values as I have.                           |
|                         | CT4. I feel secure when providing private information to this site.                      |
| Accessibility<br>(AC)   | AC1. This postal company system's high speed of page loading.                            |
|                         | AC2. This postal company system's accessibility of the site                              |
|                         | AC3. This postal company system's accessibility of the site                              |
|                         | AC4. This postal company system's logical layout.  |
| Interactivity<br>(IT)   | IT9. This postal company provides interactive feedback between customers and the company |
|                         | IT10. This postal company provides follow-up services to customers.                      |
|                         | IT9. This postal company provides message board forum for customers-to customers.        |
|                         | IT10. When promises to do something by certain time, they should do it                   |
| E-Trust<br>(ET)         | CT1. I trust the web site to keep my personal information safe                           |
|                         | CT2. I trust the web site administrators will not misuse my personal information         |
|                         | CT3. I am happy with the standards by which this company is operating.                   |
|                         | CT4. This company operates scrupulously.   |
| Reuse intention<br>(RI) | SI1. I will make more services through this company in the future                        |
|                         | SI2. I will increase services through this company.                                      |
|                         | SI3. I will intensify services through this company                                      |
|                         | SI4.I will recommend this company to other people.                                       |

### 3.2 Data collection

The demographic characteristics of respondents on the various parameters like gender, education, time of stay, postal services, and country are represented as follows: characteristics of service quality of consumer satisfaction in the postal service and to confirm the relative for on consumer satisfaction. About the gender of the respondents, two-thirds of the respondents were female (50.16%) and one-third of the respondents were male (19.80%). The fact the women are being served requires that appropriate services be provided to female clients. Table 5 shows that the greater part of respondents matured 30 to 39 years accounted for 67,03% of the full amount participants. People in a group are the age at which they engage in many prolific activities in their daily lives. It suits their interests. In particular, the needs of women aged 30-39 need to be studied and services improved. However, this study only shows selected customers. Global parcels (EMS) used 58.66 percent of all customers, 27..13 percent used domestic delivery services, and 10 percent used logistics services. In recent years, the company's business has grown a certain percentage of the consumer.

[Table 5] Respondents

| Division                             | Item              | Frequency | Rate(%) |
|--------------------------------------|-------------------|-----------|---------|
| Gender                               | Male              | 29,       | 19,80   |
|                                      | Female            | 121       | 50,16   |
| Age                                  | 20's              | 16        | 10,16   |
|                                      | 30-39             | 101       | 67,03   |
|                                      | 40-49             | 12        | 8       |
|                                      | 50-59             | 21        | 14      |
| Postal services<br>(Which have used) | Newspaper         | 10        | 6,66    |
|                                      | EMS               | 88        | 58,66   |
|                                      | Domestic delivery | 41        | 27,13   |
|                                      | Logistics         | 10        | 6,66    |

## 4. The results of research paper

### 4.1 Reliability analysis

Reliability analysis examines the relationship between each group of questions. This measurement is consistent with the inside compatibility of acceptable structures when the rate of Cronbach's Alpha is above .70 . As be able to be seen from [Table 3], the Cronbach Alpha coefficients are upper than the recommended values (.839 -.955). From these figures, it can be seen that our objects have high-quality internal densities in each dimension, in short, that our statistics are significant and have the required reliability.

[Table 6] Reliability analysis

| Constructs        | Items         | Cronbach's Alpha |
|-------------------|---------------|------------------|
